

Улсын бүртгэлийн
дугаар...

Төсөл хэрэгжүүлсэн
гэрээний дугаар:ШуСс-2018/20

Сэтгэл судлал онол арга зүйн сэтгүүл ТББ

**МОНГОЛ ХҮНИЙ СЭТГЭЦИЙН ХӨГЖИЛ СУДЛАХ
ТЕСТҮҮД НУТАГШУУЛАХ БА ҮНДЭСНИЙ САН
БҮРДҮҮЛЭХ**

**Суурь судалгааны ажлын тайлан
(2018-2020)**

Төслийн удирдагч:

П.Цэрэндондов (Ph.D), профессор

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол шинжлэх ухааны яам

Тайлан өмчлөгч:

Сэтгэл судлал онол арга зүйн сэтгүүл ТББ

Улаанбаатар хот

ГАРЧИГ

УДИРТГАЛ	1-2
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ХҮНИЙ СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙГ ОНОШЛОХ СУДАЛГААНЫ АРГА, АРГА ЗҮЙ	
1.1 Судалгааны арга, арга зүйнүүдийг сонгосон үндэслэл	3-5
1.2 Арга зүйнүүдийн танилцуулга	6-12
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРЧУУЛГЫН СОРИЛЫГ ӨӨРИЙН ОРНЫ НӨХЦӨЛД ЗОХИЦУУЛАХ НЬ	
2.1 Орчуулгын сорилыг өөрийн орны нөхцөлд зохицуулан хэрэглэх онол-арга зүйн зарим асуудал	13-17
2.2 Даалгаварт задлан шинжилгээ хийх	18-41
2.3 Гадаадын судлаачдын боловсруулсан аргачлалыг зохицуулан хэрэглэх асуудал	42-45
2.4 Гадаадын орчуулгын сорилуудыг зохицуулан хэрэглэсэн судлаачдын арга туршлагаас	46-48
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗОХИЦУУЛАН НУТАГШУУЛСАН ТЕСТҮҮД	
3.1 Амьдралын зам тест	48-54
3.2 Мэргэжлээс шалтгаалах стрессийг оношлох, залруулах тест	55
3.3 Зан үйл, сэтгэл хөдлөлийг үнэлэх тест	60-63
3.4 ТАТ тест Thematic Apperception Test	63-69
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЕРТӨНЦ ЗӨВЛӨМЖ	70-73
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	77-78
ХАВСРАЛТ	79-90

УДИРТГАЛ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

- Хүний нөөц чадавхийг илрүүлэн, хөгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байгаа 21 дүгээр зуунд улс үндэстэн, хэсэг бүлэг, хувь хүний тархины хөгжил, сэтгэл зүйн онцлогийг судлан таних харгалзан үзэх зайлшгүй шаардлага улам бүр нэмэгдэж байна.
- Монгол улсад боловсролын шинэчлэлт хийгдэж Монгол хүүхдийн бие, оюун, сэтгэцийн онцлогийг шинжлэх ухааны үндэстэй судлах, хөгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирсэн.
- 2009 онд БСШУЯ-ны Шинжлэх Ухаан Технологийн Сангийн санхүүжилтээр МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн дэргэд /Сэтгэл зүйн үйлчилгээний үндэсний төв/ Тархи судлалын төвийг байгуулсан билээ. Энэхүү төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжих, Монгол хүн бүрт хүрч ажиллах боломж бүрдүүлэх

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Монгол хүний сэтгэцийн хөгжлийг үнэлэх сэтгэл зүйн тест сорилуудад адаптаци хийж, өөрийн оронд нутагшуулах

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- Сэтгэцийн хөгжил төлөвшлийн онцлогийг тодорхойлох зориулалт бүхий нэн шаардлагатай сэтгэл зүйн тестүүдүүдийг сонгох, захиалах, орчуулах эх хэлнээ хөрвүүлэх
- Сэтгэл зүйн тестүүдийн орчуулгад дүн шинжилгээ хийх, сэтгэл судлаач болон мэргэжилтнүүдээр хэлэлцүүлэх
- Монгол хүүхдийн сэтгэцийн хөгжил болон нийгэм сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох судалгааг зохион байгуулах
- Сэтгэл зүйн тест сорилуудад адаптаци, тохиргоо хийх, даалгавруудын хүндрэлийн индексийг тодорхойлох
- Монгол хүүхдийн сэтгэцийн хөгжлийг судалсан судалгааны дүгнэлт, тайлан гаргах
- Төслийн эцэст гарын авлага боловсруулах

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

- Монгол хүний сэтгэл зүй өөрөөр хэлбэл, бие, оюун ухаан, танин мэдэхүй, сэтгэлийн онцлогийн талаарх холбогдох эх сурвалж, судалгаа шинжилгээний үр дүнд контент анализ
- Сэтгэл зүйн оношилгооны суурь тестүүдийг харьцуулалт, үнэлэлтийн аргаар болон эмпирик судалгааны тоон аргаар судалгаа шинжилгээ хийсэн.

СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

- Увс, Хөвсгөл, Хэнтий, Дорнод, Эрдэнэт, Дундговь, Архангай, Сэлэнгэ, Улаанбаатар зэрэг газруудаас арга зүйн бүрээр түүвэрлэн эмпирик судалгааг бүсчилэн авсан.
- 13-18 насны хүүхдүүд, насанд хүрэгчдийн хувьд 19-63 насныхан хамрагдсан.

ТӨСЛИЙН ҮР ДҮН

1. Монгол үндэстэн хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онцлог, нийгэм- сэтгэлзүйн хөгжил, төлөвшлийг тодорхойлох судалгааны арга зүй, судалгааны сантай болох
2. Монгол үндэстэн хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онцлог, нийгэм- сэтгэлзүйн хөгжил, төлөвшлийн зарим онцлогийг судалснаар сургалтыг үр өгөөжийг сайжруулах, эрчимжүүлэхэд сэтгэл судлалын шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах боломж бүрдэнэ.
3. Судалгааны дүнд тулгуурлан монгол үндэстэн хүүхдийн нийгэм- сэтгэл зүйн хөгжил, төлөвшлийн онцлогийн талаар эрдэм шинжилгээний тайлан бичиж, хэвлүүлсэн байна.
4. Дижитал үеийнхний сэтгэл зүйн онцлогийн талаар багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхэд зориулсан сэтгэл зүйн зөвлөмж, гарын авлага боловсруулсан.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ХҮНИЙ СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙГ ОНОШЛОХ СУДАЛГААНЫ АРГА, АРГА ЗҮЙ

1.1 СУДАЛГААНЫ АРГА, АРГА ЗҮЙНҮҮДИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ


Сэтгэл зүйн суурь тест сорилуудад адаптаци хийж Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлон, өөрийн оронд нутагшуулах зорилго бүхий энэхүү төслийн хүрээнд Тархи судлал болон сэтгэл судлалын хэрэглээний салбарт ашиглагдаж байгаа бие хүний сэтгэцийн хөгжлийн оношилгоо, үнэлгээний суурь тест сорилуудад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр *нэгдүгээрт*, бие хүний сэтгэцийн хөгжлийг оношлоход хэрэглээний салбарт өргөн хэрэглэгдэж буй сорилууд; *хоёрдугаарт*, сэтгэл судлаач мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургуулийн сэтгэц оношилгооны хичээлд сургалтын хэрэглэгдэхүүнээр ашиглах, *гуравдугаарт*, Монгол хүний сэтгэцийн хөгжлийн онцлогийг оношлох, үнэлгээний сан бүрдүүлэхэд чухал ач холбогдол бүхий тестүүдийг сонгосон болно. Үүнд:

1. Сэтгэцийн хөгжлийг оношлох, үнэлэх суурь тест сорилуудыг судалж, жагсаалтыг гаргасан.
2. Сэтгэцийн хөгжлийг оношлох, үнэлэх суурь тест сорилуудад хэрэглээний ач холбогдол, эдийн засгийн /зардал/ зэрэг талаас нь дүн шинжилгээ хийж, тестийг сонгон сэтгэл судлаачид, мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтэн судлаачдад болон төслийн багийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнгээс гарсан санал, зөвлөмжийг тусган Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлох, тест сорилуудыг сонгосон болно.
3. Монгол хүний сэтгэцийн хөгжлийн оношилгоо, үнэлгээ хийхэд дараах тестүүдийг ОХУ-ын “ИМАТОН” төв Профессиональный психологический инструментарий, АНУ-ын “PRO - ED” компанитай харилцаа холбоо тогтоож, тестүүдийн захиалгыг хийж, худалдан авах гэрээг байгуулсан болно.
4. Бид төслийн хүрээнд Монгол хүний сэтгэцийн хөгжлийн оношилгоо, үнэлгээ хийхэд дараах тестүүдийг сонгосон юм. Үүнд:
 - Приложение к методике рисуночных метафор “Жизненный путь”
 - Thematic Apperception Test
 - Методика интегральной диагностики и коррекции профессионального стресса (ИДИКС)
 - Behavioral and Emotional Rating Scale “BERS-2”



- Приложение к методике рисуночных метафор «Жизненный путь»




- Тест Гилфорда диагностика «Социального интеллекта»





- Методика интегральной диагностики и коррекции профессионального стресса ИДИКС



- Thematic apperception test “TAT” Harvard University Press Cambridge Massachusetts



- Behavioral and Emotional Rating Scale “BERS-2”



1.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙНҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

1. “Амьдралын замнал” (Приложение к медотике рисуночных метафор “Жизненный путь”) проектив тест нь хүний сэтгэлийн хөдөлгөөн, темперамент боон зан төлөвийн зарим онцлог чанар, өөрийн амьдралын талаарх үзэл төсөөлөл, түүнд хандага, тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, боломжийг тодорхойлох, амжилтад хүрэх зорилгоо тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөх зэрэг нөхцөл байдлыг илрүүлэх зорилготой.

Амьдралын зам” арга зүй нь насанд хүрэгчид болон өсвөр насны хүүхдүүдэд сэтгэл зүйн оношилгоо, зөвлөгөөний цогц арга юм. Энэхүү сорилыг дараах хоёр аргаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээрт, Үйлчлүүлэгч өөрийн амьдралыг уурган хэлбэрээр дүрсэлнэ.

Хоёрдугаарт, зурсан зургаа сэтгэл зүйчтэй хамт хэлэлцэн тайлбарлана.

Амьдралын зам арга зүй нь:

- Эдийн засгийн хэмнэлттэй. Тусгай тоног төхөөрөмж, ямар нэгэн онцгой материал, багаж хэрэгсэл шаардлагагүй. Үйлчлүүлэгчдийн талаарх мэдээлэл олж авахад цаг ордоггүй, 30 минут зарцуулдаг. Үр дүнг боловсруулахад тогтоосон стандарт шаарддаггүй.
- Гүн гүнзгий мэдээлэл олж авах боломжтой. Зөвлөгөө болон өдөр тутмын харилцаа, ердийн байдалд илрэх үйлчлүүлэгчийн хувийн сэтгэл зүйн онцлог, гарч ирж чадаагүй, нуугдмал ухамсарт шинжийг илрүүлнэ.
- Түгээмэл мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөөг өгөх болон өргөн хүрээтэй асуудлыг шийдвэрлэхэд уян хатан хэрэглэх боломжтой.
- Үйлчлүүлэгчтэй ажиллахад сэтгэл засал талаасаа өндөр үр ашигтай арга болно.

Тус арга зүйн тайлбар гүйцэтгэж байгаа даалгаврууд болон гарсан үр дүнгүүд нь үйлчлүүлэгчийн асуудалд бодитой хандах болон үйлчлүүлэгчид өөрийн мэдрэмж, харилцаагчөлөөтэй илэрхийлэх боломжийг өгдөг. Үүнээс гадна,

- Үйлчлүүлэгчтэй харилцаа тогтоох болон ярилцлагын үед гарах бэрхшээлийг багасгаж, гарах үр дүнд нөлөөлнө.
- Зөвлөгөөний үед зөвлөгч болон үйлчлүүлэгч хоёрын үүргийг амжилттай хуваарилж, үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох, үйлчлүүлэгчээ идэвхтэй байлгана.

Мөн түүнчлэн арга зүйн тайлбар, харагдах байдал, нэвтрүүлсэн туршлага, гарсан үр дүн, эдийн засгийн хэмнэлт гээд олон зүйлд нь ач холбогдол өгч болох ч хүлээн авч буй мэдээлэл гүн гүнзгий, уян хатан байдгаараа ижил төрлийн бусад аргаасаа ялгагдана.

2. Мэргэжлийн стрессийг оношлох, залруулах ИДИКС арга зүйг Оросын алдарт сэтгэл зүйч, Сэтгэл судлалын шинжлэх ухааны доктор А.Б.Леорова мэргэжлийн стресс болон хүний үйл ажиллагааны сөрөг байдлын хүрээнд явуулсан эрдэм шинжилгээний 30 гаруй жилийн туршлага дээрээ тулгуурлан боловсруулсан байна. Энэхүү технологи нь орос, герман, англи хэл дээр зэрэг боловсруулагдсан (Герман улс. Мюнстер хот. GmbH. SMP¹-ын тусламжтайгаар) бөгөөд европын хэд хэдэн орнуудад энэ аргачлалыг байгууллагын зөвлөгөө өгөх хүрээнд мэргэжилтнүүд ашиглаж байна. Ажлаас шалтгаалах стрессийг оношлох, түүнийг залруулах аргачлал (ИДИКС) хэмээх психометр сорилын орос хэл дээрх хувилбарыг бий болгоход Москвагийн Улсын их сургуулийн Сэтгэл судлалын факультетийн сэтгэл судлалын дэд доктор, шинжлэх ухааны хамтрагч А.А. Качина оролцсон байна. Төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн сөрөг стрессийн үр нөлөөг арилгах, үнэлэх зорилготой, бүх үе шатууд нь шинэчлэгдэж бүрэн стандартчилагдсан ИДИКС системийн хэрэглээний хувилбарт хувь хүний, ажил мэргэжлийн болон байгууллагын зөвлөгөө өгөх практик сэтгэл зүйчид анхаарлаа хандуулахыг санал болгож байна. Энэ системийг бий болгоход мэдээллийг олж авах гурван өөр төрлийн хэрэгцээ шаардлага бүхий "эцсийн хэрэглэгч" байна гэж үзсэн. Үүнд:

- Хувь хүний сэтгэц-оношилгооны шинжилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгч эсвэл зорилтот бүлгийн оролцогчид
- Сэтгэл зүйн нөлөө үзүүлэх эрхтэй мэргэжлийн зөвлөгчид (сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмнэлгийн ажилтан)
- Захиалагч байгууллагын төлөөлөгчид (удирдлага, захиргааны ажилтнууд) орно.

Ажлын орчин дахь стрессийн хүчин зүйлийг арилгахад чиглэгдсэн оновчтой үйл ажиллагааг бий болгохыг зорьсон энэхүү тогтолцооны үзэл баримтлалын үндэс нь ажлаас үүдэлтэй стрессийн тодорхой хам шинж бүхий гурван шатлалт загвар юм. Стрессийн бүрэн мөчлөгийн сөрөг илрэлийн шалтгаан, үр нөлөөг тогтооход,

- Хөдөлмөрийн болон байгууллагын эрсдэлт хүчин зүйлүүд
- Хөдөлмөрийн нөхцөл дэх бэрхшээл учруулж буй субъектив төлөв

¹ Software fuer Managemant und Personalentwicklung-Удирдлагын болон ажилтнуудын программ хангамж

- Хурц болон архаг стресст байдлын шинж тэмдгийн өөрчлөлт
- Мэргэжилтэн-бие хүний зан байдалд илрэх стрессийн хэв шинжийн өөрчлөлтүүдийн бэхжилт зэрэгт хүч, анхаарлаа хандуулжээ.

Энэхүү олон хэмжээст оношилгооны үр дүн нь мэдээллийг нэгтгэх хэлбэрээр стрессийн янз бүрийн үзэгдлийн чанар, түүний хөгжлийн түвшинг тодорхойлох явдал юм. Түүнээс гадна, тохиолдол бүр дэх онцлогууд дээр өвөрмөц хам шинжийг илрүүлж, түүний хөгжлийн динамикийн аюултай хүчин зүйлүүдийг тодорхойлж, улмаар урьдчилан сэргийлэх болон засаж залруулах зорилго бүхий арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулах зорилгыг хангаж өгдөг.

Орчин үед, янз бүрийн үүрэг хариуцлага бүхий менежерүүд, эмнэлгийн мэргэжлийн ажилтнууд, их, дээд, дунд сургуулийн багш нар, компьютерийн компаний ажилтнууд, инженер-техникийн мэргэжилтнүүд, банкны байгуулгынхан ба албан хаагчид, мөрдөн байцаагч болон цэргийн албан хаагчид зэрэг олон төрлийн мэргэжилтнүүдийг ажиллаж байх үед нь энэхүү аргачлалыг хэрэглэж ихээхэн туршлага хуримтлуулсан байна. Сэтгэл судлалын хэрэглээнд энэхүү оношилж-эмчлэх зорилго бүхий системийг ашигласнаар байгууллагын ажилтны эрүүл мэндийг хамгаалж, стресстэй тэмцэхэд өндөр ашигтай үр дүн гарч байгааг нотолж байна.

Стресс оношлох зориулалттай ИДИКС тогтолцоо нь стрессийг өдөөж, нөлөөлж байгаа хүчин зүйл, стрессийн тодорхой шинж тэмдэг, тэдгээрийн сөрөг үр дагавар, түүний даамжрах үеийн үнэлгээн дээр тулгуурладаг. Энэ нь давтан стрессийн түвшинд цогц, хангалттай үнэлэхийн тулд тодорхой тохиолдол бүрийн онцлогт тохирсон арга хэмжээг оновчтой авахад чиглэгдсэн.

Энэхүү систем нь бие хүнийг оношлох арга хэрэгсэл бөгөөд үүнийг ашиглахдаа эхлээд онолын хандлагад суурилагд улмаар тухайн хүнд стресс үүссэн байдал, түүнчлэн хэрхэн даамжирч байгааг ажлын тодорхой нөхцөл байдлын онцлог ба тухайн бие хүний сэтгэл зүйн онцлогт тулгуурлан судлах нь зохистойг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Харилцан ялгаатай аргачлалуудыг ашиглах үед судлуулагчдын хэтэрхий өндөр сонголтуудыг дундажлан авч болно.

Энэхүү аргачлалаар 17-оос дээш насны хүмүүсээс судалгаа авах ба даалгаврыг гүйцэтгэх стандарт хугацаа бол 20-30 минут гэсэн хязгаарлалттай.

- **3. TAT Thematic Apperception Test** TAT нэрээрээ алдаршсан энэхүү сорилын тусламжтай бие хүний шинжүүд, түүний зөрчилт байдал, давамгайлах сэдэл, сэтгэл хөдлөл, харилцаа зэргийг илрүүлэх боломжтой. Мөн судлуулагчийн нуугдмал бодол санаа, өвчтний үл ухамсарлахуйн улмаас ил гаргах боломжгүй зүйлсийг ч илрүүлэхэд тохиромжтой сорил юм. Хэрэглээ, ач холбогдол TAT нь бие хүн, түүний зан үйл болон сэтгэцийн өөрчлөлт, эмгэгийг илрүүлэхэд чиглэгдсэн хэдий ч судалгааны төгс арга зүй биш юм. Уг арга зүй дөрвөөс доош насны хүүхдийг оношлоход үр дүнгүй болох нь тогтоогдсон. Harrison болон бусад эрдэмтдийн нэгэн адил TAT болон Rorschach-ын сорилыг хослуулан хэрэглэхэд илүү үр дүнтэй байх бөгөөд судлуулагчийн талаарх цогц мэдээллийг олж авч болно. Энэ аргыг сэтгэц задлан шинжлэл болон сэтгэл засалд хэрэглэхийг зөвлөж байна. Үндэслэл Сорилын зарчим нь цуврал сорилын зургийг судлуулагчид үзүүлж, зураг тус бүрт түүх яриулах явдал. Түүх яриулахад хоёр үндсэн сэтгэл зүйн үзэл баримтлал байдаг. 1. Хүмүүс тодорхойгүй нөхцөл байдлыг өөрийн амьдралын туршлага, одоогийн хүсэл сонирхлынхоо дагуу тайлбарлах эрмэлзэлтэй байдаг. 2. Зохиож буй түүхэнд өөрсдийнх нь сэтгэлийн хөдөлгөөн, туршлага ухамсартай, ухамсаргүйгээр нөлөөлж байдаг

Судлаач судлуулагчид цуврал бүхий дараалсан зургуудыг үзүүлж ярилцана. Ярилцлага судлуулагчийн зан байдлын зарим шинжүүдийг илрүүлэхэд тусална. Судлуулагчийн ярьсан түүх тухайн хүний өмнөх амьдрал, туршлагад түшиглэн нөхцөл байдлыг ойлгоход туслах мэдээллүүдийг өгнө. Өөрөөр хэлбэл, судлуулагчаар чөлөөтэй төсөөлүүлэн өөрийнх нь тухай яриулж нууцлаг зарим зүйлийг мэдэж болно гэсэн үг. 6 Ингэхийн тулд судлаач дараах байдлаар ярилцаж болно. Жишээ нь: Би таны ярьж байгаа зүйлийг сонирхож байна. Таны ярианд гарч буй тэр залуу ямар ааш зантэй вэ? Түүнийг ээж нь аашилж загнадаг байсан уу? Энэ мэт зүйлийг би танаас тодруулах хэрэгтэй байна. Эсвэл “Таны ярьсан зүйлд зарим нэг зүйл тодорхой биш учир дүгнэлт хийхэд хүндрэлтэй байна. Та тодорхой тайлбарлахгүй юу?” гэх мэтээр хандах хэрэгтэй.

Мөн судлаач дараах тохиолдолд судлуулагчид дэмжлэг үзүүлж болно. Үүнд: 1. Судлуулагч өөрт тохиолдсон зүйлийг нэг бүрчлэн цаг хугацаагаар нь санахгүй байх 2. Судлуулагчийн яриаг шаардлагатай үед тасалж ярих сонирхлыг нэмэгдүүлэх, яриаг урамшуулах 3. Судлуулагч ярьсан зүйлдээ дүгнэлт хийж чадахгүй байвал “Ийм нөхцөлд та өөрөө юу хийх байсан вэ? Юу хийж чадах байсан вэ?” гэх мэт асуултаар хөтлөх 4. Судлуулагчийн яриа хэт их сунжирвал “Эцэст нь юу болсон бэ? Яаж төгсөх вэ?” гэх

зэргээр засч болно. Сэтгэл зүйч, судлаач энэ мэтээр ярилцаж сонссон зүйлээ нэг бүрчлэн тэмдэглэн авах хэрэгтэй.

Судлуулагчийн дотоод ертөнцийг рентгенээр харсан мэт мэдээлэлтэй болсны дараа түүний ажил, үүрэг нь дуусна. Судлаач эхний ярилцлагын дүгнэлт, дараагийн ярилцлагын төлөвлөгөөг харьцуулж үзэх шаардлагатай. Сорилын материал Сорилын материал нь гялгар цагаан цаасан дээр хэвлэсэн 19 зураг, нэг хоосон цаас байна. Судлаач судлуулагчтай 20 зураг юу илэрхийлсэн тухай ярилцана. Ямар ч зураггүйгээр ярилцлага хийж болох ч энэхүү зураг тус бүр тухайн хүний төсөөллийг бүрэн гаргаж, өөрсдийхөөрөө шийдэлд хүрэхэд нь туслах ёстой. Сорилд орсон зургууд нь 1936 онд Харвордын сэтгэл судлалын төвөөс гаргасан эх хувилбарын гурав дахь өөрчлөлт юм. Судлуулагчийн зан төлвийг өөр аргуудын тусламжтайгаар судалж үнэлгээ хийж болно. Энэ үнэлгээ судлуулагчийн дүр бүтээх чадвараас хамаарна. Зарим нэг туршилтаас үзэхэд, ялангуяа ямар нэг шалтгаанаар өвчилж, 7 удаан хугацаагаар эмчлүүлж буй өвчтнүүдэд энэ сорил тохирч байгаа нь ажиглагдсан байна. Уг сорил хүний мөн чанарыг өөрчлөх бус хувь хүний нууцыг задлахгүй гэсэн зарчимд тулгуурладаг. Судалгааны үр дүн сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хувьд түүний ерөнхий дүр төрхөд тулгуурлана. Энэ нь анагаах ухааны үндсэн зарчимд нийцнэ.

Мөн энэ тухай Стейнфордын их сургуулийн доктор Рипапортын ажилд тусгагдсан. Судлуулагчид өөртөө нь ижил хүйсийн хүний зургийг харуулахад ярилцлага илүү үндэс сайтай байсан бөгөөд гарах үр дүн ч үнэн, зөв болдгийг туршилтууд харуулсан. Нийт зургийн 11 нь аль ч хүйсийн хүнд үзүүлэхэд тохиромжтой. Бидний туршилт 40-45 насны үе дээр хязгаарлагдаад байна. Учир нь зургуудын хувьд тухайн хүний эцэг эхээс заавал ахмад биш эсвэл үе тэнгийн хүний зураг байх ёстой гэсэн зарчим байдаг. Доктор Р. Невит Сэнфордын үзснээр, хүүхдүүдийн хувьд энэ нөлөөлөх чухал зүйл биш ч зургууд 7-14 насны хүүхдүүдэд тохиромжтой юм гэжээ. Хоёр цуврал сорил тус бүр 10 зурагтай. Хоёрдугаар цувралын зургууд эхний цувралын зургуудыг бодвол илүү сонирхолтой, эрчтэй, өвөрмөц байдаг.

4. Зан үйл, сэтгэл хөдлөлийн үнэлгээний BERS тест

Зан үйл, сэтгэл хөдлөлийг үнэлж судлах BERS тестийн эхний хувилбар таван үзүүлэлтийн 52 өгөгдөл байсан. Үүнд: хүмүүстэй харилцах харилцааны давуу чанар, гэр бүлийн оролцоо, хувь хүний давуу чанар, сургууль, сургалтын үйл ажиллагаа, аффектив, сэтгэл хөдлөлийн давуу чанар. ЗСҮТ (BERS) тестийг хүүхдийн талаар мэдлэгтэй, тухайн

хүүхэдтэй тогтмол харилцаатай байдаг эцэг эх, багш, сургуулийн сэтгэл зүйч, боловсролын зөвлөх, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс мэдээлэгчээр оролцохоор боловсруулагдсан.

Тус тестийг ашиглах үндсэн зорилго нь боловсрол, сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг хүүхдэд ганцаарчилсан хөтөлбөрөөр хүргэхэд ашиглах явдал бөгөөд хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний явцыг хянах, үр дүнг үнэлэхэд хэрэглэнэ. ЗСҮТ (BERS) тест жишиг хэмжээс, тохироц чанар, баталгаат чанар сайтай сэтгэц хэмжил зүйн үзүүлэлт өндөр юм. Тестийн хэрэглээний үр дүн ихэнхдээ эерэг үнэлгээтэй байна. Хоёр жишээг толилуулъя.

“Тус тест чадамжид анхаарлаа хандуулснаар ихэнхдээ зан үйлийн доголдол, сэтгэл хөдлөлийн асуудлыг харж үнэлгээ оношилгоо хийдэг байсан өнөөгийн практикаас ялгаатай байсан. Түүгээр зогсохгүй тус тестийн сэтгэц хэмжил зүйн үзүүлэлт сайтар хангагдсан нь практикт нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чиглэсэн оношилгоо үнэлгээ хийх найдвартай арга хэрэгсэл болж байна”

“Давуу талыг үнэлэхэд чиглэсэн оношилгооны энэхүү тест нь сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, сувилагч, боловсролын зөвлөх мэргэжилтэн, багш нарын ажилд үнэ цэнэтэй мэдээллээр хангаж байна” ЗСҮТ/BERS анхны тестийг хүүхдүүд, практикийн ажилтнууд, гэр бүлийн гишүүд, удирдах ажилтнууд, судлаачид таатай хүлээн авч үнэлсэн. Судлаачид тус тестийг хүүхдийн холбогдолтой төрөл бүрийн судалгаанд тохируулан ашигласан үр дүн гарсан байна. Үүнд боловсролын байгууллага, сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд үнэлгээний арга хэрэгсэл болгож ашиглах, багш, нийгмийн үйлчилгээний мэргэжилтнүүдэд хүүхдэд чиглэсэн интервенци үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх зэрэг зориулалтаар ашиглажээ. Гэвч ЗСҮТ/BERS тестийг ашигласан мэргэжилтнүүд тус тестэд цогц чанар зэрэг зарим зүйлс дутагдалтай байгааг тэмдэглэсэн. Үүнд: (а) оношлуулж үнэлүүлж байгаа хүүхдээс авах мэдээллийн дутмаг байдал; (b) эцэг эх, багшийн үнэлгээнд суурилсан тусгай нормчилсон үзүүлэлт байх хэрэгцээ; (c) Хүүхдийн ажил мэргэжлийн сонголт, ирээдүйн зорилгын талаар асуумж байх хэрэгцээг тус тус дэвшүүлсэн.

Тус арга зүйг ашигласан судлаачдын санал хүсэлтийг судалсны үндсэн дээр Зан үйл, сэтгэл хөдлөлийн үнэлгээний BERS тестийг сайжруулан боловсруулсан. Хоёр дахь сайжруулан боловсруулсан хувилбар нь эхний BERS тестийн зорилго, формат, агуулга, онооны ажилбарыг хадгалсан бөгөөд дараах байдлаар нэмж боловсруулалт

хийсэн болно. Үүнд:

1. 11-18 насны хүүхэд өөрийн давуу чанараа үнэлэх 57 өгөгдөл бүхий Хүүхдийн тестийг нэмсэн.
2. 5-18 насны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч бөглөх 57 асуулт даалгавар бүхий Эцэг эхийн тестийг нэмсэн.
3. Дэд тестүүдэд хүүхэд, багш, мэргэжилтэн, эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийн сурлагын амжилт, нийгэм, спорт, гэр бүл, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох давуу талыг тодорхойлох найман нээлттэй асуултыг нэмж оруулсан.
4. Хүүхдийн тест, Эцэг эхийн тестийн норматив түүврийн шинж чанарыг 2000 оны хүн амын тооллогын мэдээлэлтэй харьцуулан тодорхойлж, ингэснээр АНУ-ын хүн амыг төлөөлөх чанар дээшилсэн.
5. Анхны ЗСҮТ/BERS тестийг бага зэрэг өөрчилж боловсруулан ЗСҮТ 2/BERS-2 Багшийн тест гэж нэрлэсэн. Энэхүү тестийн стандарт оноог сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй болон эмгэггүй гэж оношлогдсон хүүхдийн оноог харьцуулахаар боловсруулсан.
6. Өсөлт хөгжлийн давуу чанарыг тодорхойлох таван асуулт даалгавар бүхий үнэлгээний хэсгийг Эцэг эхийн тест, Хүүхдийн тест дээр нэмсэн.
7. Анхны ЗСҮТ/BERS тест болон ЗСҮТ2/BERS-2 тестийн баталгаат чанар, тохироц чанарыг тодорхойлох судалгаа хийж судалгааны үр дүнг оруулсан.
8. Тестийг зохион байгуулах, оноо үнэлгээ өгөх ажилбарыг нарийвчлан тодруулж тайлбарлаж тусгасан.
9. ЗСҮТ 2/BERS-2 тестийн үр дүнгийн нэгтгэлийг судлаачид хоёр ба түүнээс дээш дэд тестийн үр дүнг нэгтгэн дүгнэхэд зориулан оруулсан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРЧУУЛГЫН СОРИЛЫГ ӨӨРИЙН ОРНЫ НӨХЦӨЛД ЗОХИЦУУЛАХ НЬ

2.1 ОРЧУУЛГЫН СОРИЛЫГ ӨӨРИЙН ОРНЫ НӨХЦӨЛД ЗОХИЦУУЛАН ХЭРЭГЛЭХ ОНОЛ-АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Сэтгэц оношилгоо нь туршилтад үндэслэн XIX зууны эцсээс хөгжиж эхэлсэн бөгөөд энэ үеэс сэтгэл судлалд хэмжилтийн үзэл санаа эрчимтэй нэвтэрсэн. Сэтгэц оношилгооны асуудал судалгааны бие даасан салбар болж хөгжсөн нь хүмүүсийн сэтгэцийн хөгжлийн ялгааг тодруулах гэсэн эрдэмтдийн сонирхолтой холбоотой. Сэтгэл зүйн оношилгооны тухайн үеийн хөгжилд F. Galton (1869), J. Cattell (1890), H. Ebbinghaus (1885), A. Binet, V. Henri (1896), A. Binet, Th. Simon (1905) нарын бүтээл чухал үүрэг гүйцэтгэжээ.

Тестийг эхлээд хүний оюун ухааны түвшинг тодорхойлох, дараа нь бие хүн түүний хариу үйлчлэлийг судлах арга болгон ашигласан.

Швейцарийн нэрт сэтгэл зүйч, мэдрэлийн эмч H. Rorschach 1921 онд “Сэтгэц оношилгоо” гэсэн бүтээлээ хэвлүүлжээ. Энэ бүтээл гарснаар сэтгэц оношилгооны хөгжилд шинэ үе гарсан гэж үздэг. Энэ нь бие хүнийг судлахад чанарын шинэ хандлагыг илэрхийлэх болсонтой холбоотой. Хөгжлийн дараачийн үед бүлэг тест гэж нэрлэгддэг олон үзүүлэлт, зэрэглэлтэй, олон хувилбартай тестийг хэрэглэх болжээ. Тухайлбал, Америкийн сэтгэл зүйч Д.Векслер (D. Wechsler)-ийн боловсруулсан (1939, 1955) оюуны хөгжлийн түвшинг тодорхойлоход чиглэсэн бүлэг тест нь дотроо үгэн ба үгэн биш (зураг, дүрст) хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд тус бүр нь хэд хэдэн дэд сорилыг өөртөө багтаана.

Тест судлалын эхэн үеийн болон түүний дараа үеийн хөгжилд Баруун Европ, АНУ-ын сэтгэл судлаачдын бүтээл их хувь нэмэр оруулсан төдийгүй, сэтгэц оношлын асуудлыг улам боловсронгуй болгосон юм.

1930-1940-өөд оны үеийн Оросын (тэр үеийн ЗХУ-ын) сэтгэл судлалын ухааны сэтгэц оношилгооны асуудал нь М.С. Бернштейн, Л.С. Выготский, П.П. Блонский, Н.Д.Левитов зэрэг олон эрдэмтэдтэй салшгүй холбоотой. Хэдийгээр энэ үед сэтгэц оношилгоог хааж, хориглож зогсонги байдалд оруулсан боловч алгуур аажим хөгжсөөр хөгжлийнхөө дараагийн үетэй золгожээ.

Оросын сэтгэл зүйн оношилгооны хөгжлийн хоёр дахь үе шатыг 50-60аад онд эхэлсэн гэж үздэг. Энэ үед сэтгэл зүйн судалгаанд тэр дундаа оюун ухааны хөгжлийн судалгаанд чанарын шинэ хандлага буй болжээ. А.А.Люблинскаягийн судалгаа нь ерөнхийдөө үг ярианы хөгжил, түүний үүргийн онцлогийг судлахад зориулагдсан бол А.Р.Луриягийн удирдлагаар үйл ажиллагааны зохилдлогод үг ярианы гүйцэтгэх үүргийг тус тус судалжээ. Д.Б. Эльконин тэргүүтэй эрдэмтэд бага насны хүүхдийн гол үйл ажиллагаа болох тоглоомын үүрэг, ярианы хөгжлийг судалсан байна.

Бине Симоны тестийг анх судлаач Г.Годдорд Америкт хэрэглэж байжээ. Ингэхдээ цагаачдыг судалсан бөгөөд огт адаптаци хийгдээгүй тэрхүү сорилоор хүмүүсийн оюун ухааныг оношлоход оюун ухааны түвшин маш доогуур тэр бүү хэл олон хүмүүс оюуны хомсдолтой гэсэн үр дүн гарсан байна. Харин дараа нь Термен дахин шинэчилж адаптаци хийн өмнөх хувилбараас тэс өөр болгосон байна.

“Тест” гэдэг нь дундад зууны үед Англи, Франц хэлэнд орж ирсэн бөгөөд “testum” гэдэг латин үгнээс гаралтай. Testum нь шавраар хийсэн савыг /данхыг/ хэлдэг байсан ба тэр үед хүмүүс шил шавраар хийсэн саваа зууханд хийж шатаах, халаахынхаа өмнө “testum”-ийг зуухандаа хийж зуухныхаа халалтыг тохирсон эсэхийг шалгадаг байжээ. Test нь янз бүрийн үгтэй нэгдэж тодорхой утгуудыг илэрхийлнэ. Test bed - нисэх онгоцыг ажиллахаас өмнө түүний хөдөлгүүрийг шалгадаг багажийг хэлнэ. Test card – зурагтын нэвтрүүлгийг бэлтгэн явуулахын тулд зураглалын чанарыг шалгадаг хөдөлгөөнгүй зургуудыг хэлнэ. Эндээс үзэхэд тест нь янз бүрийн утгыг илэрхийлдэг боловч ихэнх тохиолдолд ямар нэгэн зүйлийг шалгах, судлах, турших, сорих гэсэн ухагдахууныг илэрхийлдэг байна.

Тестийн арга нь сэтгэл судлалын судалгааны бусад аргаас нэлээд онцлогтой. Тест нь бусад шинжлэх ухааны туршилттай нэгэн адил нарийвчлан сонгож авсан сонголтод тулгуурлан хийгддэг. Тест нь стандартчилсан хэмжилттэй байна. Стандартчилал нь тестийг явуулах журам, түүнийг үнэлэх үнэлгээ, тестийг хэрэглэж буй нөхцөл бүрт ижил байхыг шаардана. Тестийн судалгааг явуулахад нэгэн ижил нөхцөл, бололцоог судлуулж байгаа хүнд олгож байж сая янз бүрийн хүмүүсээс авсан судалгааны үр дүнг харьцуулах боломжтой болно. Ийм нэгдмэл нөхцөлийг хангахын тулд тест зохиогч нь тестийг хэрхэн явуулах талаар нарийвчилсан заавар боловсруулсан байх шаардлагатай.

Тестийн стандартчиллын дараагийн нэн чухал шат бол **нормчлол** тогтоох асуудал юм. Ямар ч гэсэн сэтгэл зүйн тестийн үзүүлэлтийг урьдчилан тодорхойлох норм байдаггүй. Энэ нь хэвийн хөгжилтэй судлуулагчдын гүйцэтгэж буй тестийн даалгаврын дундаж ач холбогдлоор тодорхойлогдоно. Гэхдээ нормчиллыг хэрхэн тогтоож, судалгааны үр дүнг ямар түвшинд боловсруулж байна вэ? гэдгээс үлэмж шалтгаална. Тестэд тавигдах өөр нэг чухал шаардлага бол тест нь заавал **бодит хэмжилт** байх ёстой. Энэ шаардлагыг хангахын тулд тестийн судалгааны үр дүнг тайлбарлах тайлбарлал нь судлаачийн субъектив дүгнэлтээс ангид байж чадвал сая тестийн бодит чанар хангагдах юм.

Сэтгэл судлалын шинжлэх ухаанд сэтгэл зүйн оношилгооны 15 мянган арга байгаагийн 3 төрлийн тестийг арай илүү нийтлэг хэрэглэдэг. Энэ нь

Нэгдүгээрт авьяас чадварыг тодорхойлох тест юм.

Хоёрдугаарт амжилт гаргах эсэхийг илрүүлэх тест нь тухайн хүн тодорхой үйл жиллагаанд бэлэн байгаа эсэхийн зэргэмжийг тодорхойлох боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл аль нэг үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй мэдлэг чадварын эзэмшилтийн төвшинг тодорхойлдог.

Гуравдугаарт төслийн тест нь тухайн хүнд байгаа сэтгэцийн тодорхой шинжийг илрүүлэхэд чиглэдэг.

Тест нь хэлбэрийн хувьд ганцаарчилсан ба бүлгийн, аман ба бичгэн, бланк, эд юмстай харьцах, аппаратур, компьютер, үгэн ба үгэн бус байж болно. Мөн тестийг агуулгаар нь оюун ухааны, авьяас чадварын, амжилтын, танин мэдэхүйн бие хүний онцлогийг оношлох тест гэсэн таван бүлэгт ангилна.

- 1. Оюун ухааны тест** – Энэ нь хүний оюун ухааны хөгжлийн түвшинг оношилж, хэмжих зориулалттай тест юм. Оюун ухааны тест нь сэтгэц оношилгооны хамгийн өргөн дэлгэрсэн аргад ордог. Оюун ухааны тестүүд хэлбэрийн хувьд бүлгийн ба ганцаарчилсан, аман ба бичгийн, бланк, эд юмстай харьцах болон компьютер тест байж болно.
- 2. Авьяас чадварын тест** – Энэ хэв шинжийн аргачлал нь нэг буюу хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмших хувь хүний боломжийг үнэлэх зориулалттай. Авьяас чадварыг ерөнхий ба тусгай авьяас чадвар гэж ангилдаг. Үүний дагуу ерөнхий ба тусгай авьяас чадварыг оношлох

тестийг ялгаж үздэг. Хэлбэрийн хувьд авьяас чадварын тест нь мөн олон янз байж болно (бүлгийн ба ганцаарчилсан, аман ба бичгийн, бланк, эд юмстай, харьцах болон компьютер тест)

3. **Амжилтын тест** – Энэ нь сургалт, мэргэжлийн болон бусад төрлийн бэлтгэлийн дараа мэдлэг, чадвар, дадлын төлөвшилд гарах амжилт ахицын хэм хэмжээг үнэлэх зориулалттай. Ийнхүү амжилтын тест нь хувь хүний хөгжилд харьцангуй стандарт багц нөлөөллийн үзүүлэх үйлчлэлийг хэмждэг. Амжилтын тестийг сурлагын амжилтг мэргэжлийн ахиц амжилтыг үнэлэхэд өргөн хэрэглэнэ.
4. **Танин мэдэхүйн тест** – Сэтгэцийн хөгжлийн түвшин өөрчлөлтийг оношлоход ашиглана. (хүртэхүй, ой, сэтгэхүй гэх мэт)
5. **Бие хүний онцлогийг оношлох тест** – сэтгэц оношилгооны эдгээр арга барил нь бие хүний сэдэл, сонирхол, хэрэгцээ, харьцаа, хандлага, тодорхой нөхцөл дэх зан үйлийн онцлогийг судлах зориулалттай. Бие хүний хувийн онцлогийг оношлоход тест, агуулга, проектив арга техникийг өргөн ашигладаг.

Тестийн хэрэглэгч гэдэг нь практик шийдвэр гаргахад мэдээллийн гол эх үүсвэрийн хувьд тестийн үзүүлэлтийг ашиглаж буй хүн юм. Тестийн хэрэглэгч нь тест явуулах, тест оношилгооны үр дүнг боловсруулах чиглэлээр мэргэшсэн хүн ч байж болно, үгүй ч байж болно. Тухайлбал, багш, зөвлөгч, боловсролын салбарын ажилтнууд, үйлдвэр болон төрийн байгууллагуудын боловсон хүчний асуудал хариуцсан хүмүүс байж болно.

Сэтгэл зүйч хэрэглэгчдэд тавигдах шаардлага

1. Сэтгэл зүйч – хэрэглэгч нь сэтгэл зүйн боловсролтой, энэ мэргэжлээрээ эрдэм шинжилгээ болон практикийн байгууллагуудад өөрийн үйл ажиллагаанд сэтгэц оношилгооны аргуудыг ашигладаг хүн байна.²Хэрэглэгчийн мэргэшил нь тестийн удирдамжинд зааснаас доогуур байж болохгүй. Тайлбар: тестийг зөвхөн мэргэшсэн судлаачид хэрэглэх шаардлага нь тестийг буруу хэрэглэхээс хамгаалах үүрэгтэй. Хэрэглэгчийн мэргэшил нь тестийн хэв шинжид тохирсон байх ёстой.
2. Сэтгэл зүйч өөрийн чадамжийн хүрээ болон өөрийн ашиглах хэрэгслийн хязгаарыг ухамсарлаж, судалгаа шинжилгээний тодорхой нөхцөлд тогтоосон мэргэжлийн

²Л.Ф. Бурлачук Л.Ф. Морозов С.М (2002) *Словарь-справочник по психологической диагностике*


стандартыг хангаагүй үйлчилгээ үзүүлж, шаардлага хангаагүй аргыг хэрэглэхээс зайлсхийнэ.

3. Сэтгэл зүйч – хэрэглэгч өмнөө дэвшүүлсэн зорилт болон оношилж буй хүн эсвэл түүврийн онцлогт тохируулж тестийг зөв сонгох чадвартай байх ёстой. Тестийг зөв хэрэглэх, түүний үр дүнг тайлбарлах, оношлуулагчийн хувьд ёс зүйн хэм хэмжээг баримтлахад бүх хариуцлагыг хүлээнэ.
4. Өөрийн үйл ажиллагаанд сэтгэл зүйч “Хор хохирол учруулахгүй байх” гэсэн зарчмыг ямагт баримтлах ёстой.
5. Сэтгэл зүйч – хэрэглэгч аргачлалыг хэрэглэхдээ стандарт бүх шаардлагыг нарийн чанд мөрдөх шаардлагатай.
6. Шуудангаар тест оношилгоо явуулж болохгүй.
7. Өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд сэтгэл зүйч- хэрэглэгч нь өөрийн мэдлэг туршлагад тулгуурлаж, түүний үндсэн дээр бие даан шийдвэр гаргаж, түүнийхээ төлөө өөрөө хариуцлага хүлээнэ. Эргэлзээтэй эсвэл маргаантай тохиолдолд сэтгэл зүйч тухайн салбарын шинжээчтэй зөвлөлдөж, авсан зөвлөмжийг бодитойгоор авч үзэх үүрэгтэй.
8. Хэрэглэгч нь эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, энэ аргачлалын боловсруулагчдад илгээх зорилгоор хэвлэгдсэн аргачлалаар статистикийн болон сэтгэл зүйн материал цуглуулах эрх байхгүй.

Даалгаварт хийх задлан шинжлэл нь аргачлалын эцсийн хувилбарт зориулсан хамгийн оновчтой даалгавруудыг сонгох зорилготой юм. Даалгаварт задлан шинжлэл хийх асуудал нь амжилтын тест боловсруулахад ихэд чухал байдаг. Хамгийн оновчтой даалгавруудыг сонгох зарчим болон дүрмийг мэдэж, даалгаварт анализ хийх статистикийн энгийн аргуудыг эзэмшсэнээр амжилтын тестийн чанарыг мэдэгдэхүйц дээшлүүлэх боломжтой юм. Даалгаварт анализ хийхдээ тэдгээрийн чанарын тал буюу даалгаврын агуулга ба хэлбэр болон тоон талыг өөрөөр хэлбэл тэдний статистикийн шинжүүдийг авч үзэж болно.

ДААЛГАВАРТ ЗАДЛАН ШИЖИЛГЭЭ ХИЙХ

Зураг 1



Аль ч тестийн баталгаат болон тохироц чанар эцсийн эцэст түүнд багтсан даалгавруудын онцлогоос хамаарна. Бүх даалгаварт анализ хийх үе шатанд тестийн өндөр баталгаат болон тохироц чанарын суурийг тавьж болно. Зарим даалгавруудыг хасаж, нэмж өөрчилж, дахин харж тестийг мэдэгдэхүйц сайжруулж болно.

ДААЛГАВРУУДЫН ХҮНДРЭЛИЙН ТҮВШИН

Тест оношилгооны ихэнх зорилгод даалгаврын хүндрэлийн түвшинг даалгаврыг зөв гүйцэтгэсэн туршигдагчдын хувиар тодорхойлдог. Даалгавар хялбар байх тусам энэхүү хувь өндөр байх болно.

Ихэвчлэн тестийн даалгаврууд нь хүндрэх дарааллаар байрлаж, туршигдагч харьцангуй энгийн даалгавруудаас эхэлж, аажмаар хүнд даалгаварт шилжинэ. Даалгавруудыг ингэж байрлуулах нь туршигдагчид өөрийн хүчин чадалд итгэх итгэлийг бий болгож, хүнд хэцүү даалгаварт их цаг хугацаа зарцуулж, хийж чадах хялбар даалгавруудыг орхигдуулах магадлал багасна.

Хүснэгт -1

Туршигдагчид	Даалгавар					Сумма
	a	b	c	d	e	
1	1	1	0	1	1	4
2	0	1	0	0	1	2
3	1	0	0	1	1	3
4	1	0	0	0	1	2
5	0	0	0	1	1	2
Сумма	3	2	0	3	5	13

Даалгаврын хүндрэлийн индекс Дараагийн алхам бол тестийн түлхүүрийн дагуу хариулсан туршигдагчдын хувийг гаргахад оршино. Үүнийг “индекс эффективности задани” эсвэл “индекс сложности заданий” гэж нэрлэдэг. Энэ үзүүлэлтийг зөв хариулсан туршигдагчдын нийт тоонд хувааж гаргана. Энэхүү индекс даалгавар тус бүрийн хувьд 0.25-0.75 хооронд хэлбэлзэнэ. Бүх тестийн хувьд 0.5-д ойртож байх нь хамгийн тохиромжтой. Энэхүү индекс нь 0.25-аас бага эсвэл 0.75-аас дээш байх нь сорилтын даалгавар үр өгөөжгүй болохыг харуулж байдаг. Учир нь эхний тохиолдолд сорилтын даалгавар хэт хүнд байсны улмаас маш цөөн тооны туршигдагч зөв хариулт өгч, харин хоёр дахь тохиолдолд даалгавар хэт хөнгөн байсны улмаас ихэнх туршигдагч зөв хариулт өгөх болно. Ийм даалгаврууд оношлох гэж буй сэтгэл зүйн чанарыг тодорхойлоход үнэ цэнэ багатай байна.

Даалгавар тус бүрийн хувьд хүндрэлийн индекс

Хүснэгт -2

Даалгаврын хүндрэлийн индекс	Даалгавар				
	a	b	c	d	e
	0,6	0,4	0	0,6	1

Хүснэгтээс харахад тестийн эцсийн хувилбараас (c) болон (e) даалгавруудыг хасах шаардлагатай болох нь харагдаж байна.

Гадаадын олон тооны “бэлэн” аргачлалаар тестийн санг түргэн баяжуулах арга зам нь олон сэтгэл зүйчдийн хувьд баталгаат болон тохироц чанарыг хангасан сэтгэц оношилгоонд хүрэх хамгийн хэмнэлттэй, дөт зам мэт санагдаж болох талтай. Хэрэв тестийг нийгэм- соёлын өөр нөхцөлд зохицуулах ажил нь зөвхөн тестийн онооны норматив хуваарилалтыг зохиох явдлаар хязгаарлагдвал энэ нь тухайн аргачлалын тохироц болон баталгаат чанарыг шинэ нөхцөлд

хүлээн зөвшөөрч тестийн зохиогчийн онолын үзэл баримтлал болон түүний ашигласан тохироц чанарын шалгуурын агуулгыг ямар ч өөрчлөлтгүйгээр шинэ нөхцөлд шилжүүлнэ гэсэн үг юм. Ер нь аль ч, үүний дотор тохироц болон баталгаат чанар хангаагүй аргачлалаар хуваарилалт гаргаж болдог байна.

Ийм шилжилт нь мэдрэлийн тогтолцооны онцлог шинж, функциональ байдал, мэдрэхүй-хөдөлгөөний үзүүлэлтүүд, когнитив энгийн үйлүүд зэргээр сэтгэцийн зөвхөн энгийн чанарууд, өөрөөр хэлбэл сэтгэцийн үйл ажиллагааны бүтэц динамикийн талын оношилгоонд гарч болох алдаа юм. Гэхдээ энд бас сэтгэц-физиологийн хэмжилт, “физиологийн үзүүлэлтүүдийг” ашигласан тест зэрэг объектив аргуудыг ашигласан байх шаардлагатай гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Харин бие хүний сэтгэцийн интеграл /бүхэл нэгдмэл/ шинж чанарууд болон хувийн ухамсрыг оношлох /сэдэл, хандлага, өөрийн үнэлгээ, ерөнхий авьяас чадвар, харилцааны хэв маяг, үнэт зүйлсийн баримжаалал, сонирхол, /гэх мэт/, түүнчлэн оношилгоонд хэл шинжлэлийн аль нэг элемент багтсан байх /үүнд: зорилт, асуултуудын томъёолол тестийн зааварчилгаа зэрэг хамаарагдана/ эсвэл соёлын тусгай шалгуур ашиглах тохиолдолд зохицуулан хэрэглэх ажил нь зөвхөн тестийн жишиг норм цуглуулах явдлаар хязгаарлаж болохгүй.

Энэ тохиолдолд нийгэм-соёлын шинэ нөхцөлд тестийн баталгаат болон тохироц чанарыг шалгах нухацтай эмпирик ажиллагаа хийх шаардлагатай бөгөөд энэ ажил нь өөрийн багтаамжаараа шинээр аргачлал зохион бүтээх ажилтай бараг адил байдгийг олон судлаачид тэмдэглэсэн байна. Энэ үүднээс, авьяас чадвар, оюун ухаан, зан төлөвийн шинжүүд, сонирхол зэргийг оношлох гадаадын аргачлалуудыг орчуулан хэрэглэх нь сэтгэц оношилгооны хамгийн хялбар зам огт биш юм. Сэтгэц хэмжил зүйн зарчмуудыг ухамсартайгаар аль эсвэл мэдлэг дутмагаас болж үл ойшоох хүмүүсийн хувьд л энэ арга зам нь дөт мэт санагдаж болно. Зохиогдсон тестийг зохицуулах гэдэг нь тестийг нийгэм соёлын шинэ нөхцөлд хэрэглэхэд түүний зохицлыг хангах цогц ажиллагаа юм.

Өдөөгч материалыг өөрчлөх шаардлагагүй проектив арга техник болон үгэн бус сорилуудын хувьд зохицуулах ажил төвөг багатай байдаг байна. Харин төрөл бүрийн асуулга, түүнчлэн оюун ухааны тестийн бүтцэд орох үгэн дэд сорилуудын хувьд энэхүү асуудал гарч ирнэ. Судлаачийн өмнө тулгарах гол бэрхшээл нь янз бүрийн улс орны ард түмний хэл яриа, зан заншил, уламжлал, нийгэм - соёлын ялгаатай холбоотой. Тестийг зохицуулахад хэл

шинжлэлийн үүднээс түүний үгийн сан болон хэл зүйг оношлох гэж буй түүврийн нас болон боловсролын онцлогт тохируулах, үгийн далд, шилжүүлсэн /коннотатив/ утгыг харгалзах шаардлагатай. Түүнчлэн нийгэм соёлын ялгаатай холбоотой багагүй бэрхшээл тулгардаг. Тест зохиогдсон тухайн нийгмийн соёлын өвөрмөц онцлог, зан заншил, уламжлал, үнэт зүйл зэрэг нь хэл ярианд тусгалаа олсон байх ба энэхүү онцлогт тохирч нийцсэн адил хувилбарыг өөр соёлд олоход ихэд төвөгтэй, зарим тохиолдолд боломжгүй байж болох ч талтай.

Даалгаврыг сольж шинэчлэх ажлыг зохион байгуулахдаа дараах зарчмыг баримтлах хэрэгтэй.

- Монголчуудын хэл соёл уламжлал, эрхэлдэг үйл ажиллагаа, монгол орны цаг агаар, нутаг, байгалийн онцлог, амьтан ургамлын ертөнц зэргийг харгалзах,
- Өөрчлөх шаардлага бүхий даалгавар нь оюун ухааны үйл ажиллагааны аль талыг хэмжих зориулалттай болохыг тооцох,
- Тест зохиогчийн сэтгэц хэмжил зүйн нарийн боловсруулалтыг аль болох бага хөндөж, эх материалын утга санааг хэвээр хадгалахын хамтаар монгол хүний сэтгэлгээ ахуйд тохирсон үг хэллэгийг хэрэглэхийг зорих

Оросын сэтгэл зүйч А.А. Бодалёв, В.В. Столин нар орчуулгын олон хэмжүүрт тест- асуулгыг зохицуулан хэрэглэх эмпирик – статистикийн ажлын шаардлагатай дараах үе шатуудыг санал болгосон байна. Үүнд:

1. Тест асуулгын бүрэлдэхүүн хэсгүүдийн дотоод тохироц чанар , дотоод зохицолд задлан шинжлэл хийх.Тестийн зохиогчид тухайн аргачлалын зохиох хэрэглүүрийн хувьд энэхүү задлан шинжлэлийг ашигласан тохиолдолд түүнийг хийх нь зайлшгүй шаардлагатай байдаг байна. Энэхүү задлан шинжлэл нь эмпирик бүх индикаторуудын огтлолцолд оношилгооны ерөнхий нэг шинж чанар /ямар гэдэг нь хараахан тодорхой бус/ оршиж байгааг харуулах зорилготой юм. Ийм задлан факторт анализын тусламжтайгаар гарсан тестийн бүх хэмжүүрийн хувьд зайлшгүй шаардлагатай. Жишээ нь Айзенкийн ЕРІ тест-асуулга, Кеттелийн 16 хэмжүүрийн хувьд дотоод уялдаатай байх шаардлагыг хэрэглэх нь заавал биш. Учир нь эдгээр хэмжүүрийн хувьд даалгавруудыг гадаад шалгуурын дагуу сонгосон байх ба нэг багц хүчин зүйлд холбогдоогүй байдаг. Дотоод уялдаа холбооны анализ нь нэг хэмжүүрт сорилуудын аль алинд нь хэрэглэгдэж болно. Эхний тохиолдолд жирийн тооны машинаар тооцоо хийж болдог бол олон сорилын хувьд компьютерийн тусгай программ ашиглах хэрэгтэй байдаг байна. Гомоген бус шкалын хувьд дотоод

уялдаа холбооны анализ нь даалгавруудын мэдээлэл агуулсан чанарыг багц хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг олгодог.

2. Давтан оношилгоонд тогтвортой байх чанарыг хянаж шалгах

Энэ нь цаг хугацааны явцад өөрчлөгдөхгүй байх шинж чанаруудыг оношлоход зайлшгүй шаардлагатай үе шат юм. Дотоод зохицлын баталгаат чанарын анализын адил ре-тест баталгаат чанарын анализыг тестийн салангид даалгавруудын мэдээллийн агуулга болон тогтворт чанарыг судлах явдалтай зэрэгцүүлэн хийж болно. Ре-тест баталгаат чанарын талаарх мэдээ баримтгүйгээр сэтгэл зүйчийн хувьд хамгийн энгийн урьдчилсан дүгнэлтийг хийх ч ихэд төвөгтэй байх болно.

3. Релейвант гадаад шалгууртай тогтоох корреляцид задлан шинжлэл хийх

Тестийг анхнаасаа шалгуур баримжаалж боловсруулсан тохиолдолд, өөрөөр хэлбэл түүний даалгавруудыг тохироц чанарын ямар нэг шалгууртай харилцан хамааралд оруулах үндсэн дээр сонгосон тохиолдолд тохиргоо хийх энэ үе шат зайлшгүй шаардлагатай байдаг байна. Тухайлбал, Оросын сэтгэл зүйч Ф.Б.Березений удирдлага дор судлаачдын баг ММРІ тестийн хураангуй хувилбарын хувьд ийм ажлыг хийсэн байна.³

4. Тестийн норм жишгийг хянаж шалгах, дахин стандартчилах

5. Олон хэмжүүрт тестийн хувьд хэмжүүрүүдийн хоорондын харьцааны бүтэц нөхөн сэргэх боломжийг шалгах

Эдгээр судлаачид орчуулгын сорилыг нийгэм – соёлын өөр нөхцөлд зохицуулан хэрэглэх ажилбар ихэд нүсэр төвөгтэй болохыг тэмдэглэж “адаптаци” хэмээх нэр томъёоноос татгалзаж, “гадаадын аргачлалыг өөрийн орны түүвэр дээр туршиж үзсэн нь” гэсэн үг хэллэг хэрэглэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байна.

Оросын сэтгэл зүйч Ю.Л. Ханин асуулгыг зохицуулан хэрэглэх ажилбарын дараах үе шатыг санал болгосон. Үүнд:

- Эх хувилбараас хэрэглэгчийн хэл рүү буулгасан орчуулгын урьдчилсан хувилбар боловсруулах
- Хэл шинжээчид болон эх хэлийг эзэмшсэн мэргэжлийн сэтгэл зүйчийг оролцуулан урьдчилсан хувилбарт шинжээчийн үнэлгээ хийх
- Туршилтын орчуулга болон тестийн эх хувийн зохицлыг шалгах

³ Ф.Б.Березен (1976) *Психическая и психофизиологическая адаптация человека*

- Шинэ хэмжүүр /шкал/ тогтоох, өөрийн орны түүвэр дээр зохих жишиг норм цуглуулах

Тестийг зохицуулан хэрэглэхэд судлаач тестийн орчуулгад нэлээд анхаарал хандуулах нь зүйн хэрэг. Энд судлаачид нэлээд бэрхшээлтэй тулгарах бөгөөд практик дээр хэрэглэдэг орчуулгын асуулгуудад дээрх бэрхшээлийг тэр болгон даван туулж чадаагүй болохыг Оросын зарим сэтгэл зүйчид тэмдэглэж байна. Үүний нэг шалтгаан бол асуулт, батламж бүрийн цаана агуулагдах зохиогчийн сэтгэц хэмжил зүйн боловсруулалт юм. Энэ нь түүний халдашгүй байдлыг хангаж байдаг.

Д.Кемпбелл /1980/ симметри ба ассиметри хэмээх 2 төрлийн орчуулгыг ялгаж үзсэн байдаг. Симметри орчуулгын тохиолдолд аргачлалын эх хувилбарын утга санаа хэвээр хадгалагдахын хамтаар ойлгомжтой, ердийн байх чанар илэрч байдаг бол ассиметри орчуулгын хувьд эх хувилбарын хэлэнд илүү хүчтэй баримжаалсан байх явдал ажиглагдана. Тэрбээр стандартчилсан асуулгыг орчуулах явцад эх хувилбарт баримжаалах гэсэн хүсэл ихэвчлэн илрэх ба үүний үр дүнд “тестийн болхи, хачирхалтай хувилбар” гарч ирж болох тухай тэмдэглэсэн байна. Учир нь “асуултуудын харилцан нэг утгат адил төстэй байдлыг алдахаас болгоомжилж орчуулга хийгдэж буй хэлний өвөрмөц, өөр хэлэнд үгчлэн орчуулах боломжгүй хэллэгийг /идиом/ эх хувилбарын ижил төстэй өвөрмөц хэллэгээр солих зүйрлэсэн орчуулга хийгдэхгүй байгаа учраас” дээрх байдал ажиглагдана.

Сэтгэц оношилгооны салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд ийм “хачирхалтай” асуулгуудтай нэг бус удаа тааралдаж байсан нь нууц биш бөгөөд ийм асуулгуудын тусламжтайгаар бие хүний онцлогийг илрүүлэхээс илүү хэл зүйн нарийн бүтцийг ойлгох туршигдагчийн чадварыг илрүүлнэ. Асуулга эсвэл үгэн дэд сорилуудад тухайн аргачлалыг боловсруулсан нийгмийн соёлын онцлог заавал тусгалаа олсон байдаг. Нэг нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн өөрийн хувилбарыг өөр соёлд олох явдал ихэд бэрх, зарим тохиолдолд боломжгүй ч байж болно.

Л.Ф. Бурлачук тестийг зохицуулан хэрэглэн дараах үндсэн үе шатыг санал болгосон байна. Үүнд:

- Тест зохиогчийн онолын үзэл баримтлалд задлан шинжлэл хийх
- Тест болон тестийн зааварчилгыг хэрэглэгчийн хэл рүү орчуулах, эх хувьтайгаа тохирч байгаа эсэхэд шинжээчийн үнэлгээ өгөх

- Сэтгэц хэмжил зүйн шаардлагын дагуу тестийн тохироц болон баталгаат чанарыг ашиглах
- Тохирох түүвэр дээр стандартчилах

Тестийг зохицуулан хэрэглэх дээрх үе шатыг цухас харахад л эмпирик – статистикийн ажлын хэмжээгээрээ шинэ аргачлал бүтээхээс дутуугүй ажиллагаатай байдаг нь харагдаж байна.

Гэхдээ зохицуулсан гадаадын тестийн тусламжтайгаар оношилгоо явуулах нь сул талтай байдгийг анхаарах хэрэгтэй. Тест нь түүнд тусгагдаж төлөөлөгдсөн тэрхүү соёлд туршигдагчдын харьяалагдах хэм хэмжээг илрүүлдгийг олон судлаачид тэмдэглэж байна. Энэ асуудлаар “Тестийн зохиогч, ихэвчлэн туршлагатай эмпирик сэтгэл зүйч нь зөнгөөрөө өөрийн соёлд хэвшмэл байх логик функционал харьцаанд сонгодог.

Тест оношилгоо нь тухайн соёл иргэншилд туршигдагчийн харьяалагдах хэм хэмжээг илрүүлдэг” хэмээн тэмдэглэсэн байна. Иймээс тестийн хамгийн төгс орчуулга болон зохицуулан хэрэглэсэн хувилбар нь уг тест “бусдынх” байж, нийгэм-соёлын бүлэгт зориулагдаж тухайн соёлоос өөрийн төлөөлөгчдийн оюун ухааны хөгжилд тавих шаардлагын дагуу хийгдсэн байдгийг өөрчилж чадахгүй. Тестийг нийгэм соёлын шинэ орчинд шилжүүлэхэд түүний гишүүдийн хувьд тодорхой хэмжээгээр “шударга бус” байх болно.⁴ Энэ асуудалтай холбоотойгоор онолын орчин үеийн хандлагад тохирсон оношилгооны өөрийн аргачлалуудыг шинээр боловсруулах асуудал хурцаар тавигдаж байна.

Гэхдээ гадаадын аргачлалыг зохицуулан хэрэглэх ажлыг эрчимтэй бөгөөд төлөвлөгөөтэй хийх нь зүйтэй. Ялангуяа олон улсад түгэн дэлгэрсэн, өөрийн түгээмэл чанараа нотолсон, баталгаат болон тохироц чанарын өндөр үзүүлэлттэй, олон орнуудад амжилттай хэрэглэгдэж байгаа аргачлалуудын хувьд энэ ажил ихэд чухал.

Баталгаат чанар Баталгаат чанар (reliability) буюу найдвартай байх чанар гэдэг нь сэтгэц оношилгооны хэмжилтийн нарийвчлал болон тестийн үр дүн хөндлөнгийн тохиолдлын хүчин зүйлийн нөлөөлөлд тогтвортой байх хэм хэмжээг тусгах аргачлалын тодорхойлолт юм.⁵ Баталгаат болон тохироц чанар нь сэтгэц оношилгооны аргачлалын чухал үзүүлэлтүүд болдог.

⁴ Анна Анастаси. Сьюзан Урбина (2006) “Психологическое тестирование” Москва

⁵ Г.Сарантуяа (2018) Сэтгэц оношилгоо. Улаанбаатар

Уламжлалт тест судлалд “баталгаат чанар” хэмээх ойлголт нь тестийн нэг хэсэг туршигдагчид дээр давтан хэрэглэх тохиолдолд түүний хоёр удаагийн хэрэглээний үр дүн харьцангуй догтвортой, хоорондоо уялдаатай байхыг илэрхийлдэг. Амеракийн сэтгэл судлаач, Psychological Testing алдарт бүтээлийн зохиолч А.Анастаси (Anastasi&Urbina, 1997) “хүүхэд оюун ухааны тестээр долоо хоногийн эхэнд 110, харин долоо хоногийн төгсгөлд 80 гэсэн үзүүлэлттэй байх тохиолдолд тухайн тестийг найдвартай гэж үзхэд хэцүү” гэж тэмдэглэсэн байдаг. Баталгаатай аргачлалуудыг давтан хэрэглэхэд үр дүн төстэй гардаг. Өөрөөр хэлбэл, тестийн үр дүн эсвэл бүлэг дотор туршигдагчийн эрэмбэ(ранг) тодорхой хэмжээгээр хоорондоо тохирч байдаг. Аль аль тохиолдолд судалгааг давтан явуулахад бага зэрэг ялгаа илрэх боломжтойч энэхүү ялгаа ялимгүй бага, нэг бүлгийн хүрээнд байх нь чухал юм. Ийнхүү, аргачлалын баталгаат нь сэтгэл зүйн хэмжилтийн нарийвчлалыг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд тестээр гарсан үр дүн хэр найдвартай болох талаар дүгнэлт хийх боломж олгодог.

Аргачлалын баталгаат чанарын хэм хэмжээ олон хүчин зүйлээс хамаардаг. Иймээс практик оношилгооны нэг чухал асуудал нь хэмжилтийн нарийвчлалд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсийг илрүүлэхэд оршино.

Сэтгэл зүйн судалгааны үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийг дурьдвал

- Оношлогдох шинж чанарын тогтворгүй байдал
- Оношилгооны төгс бус аргачлалууд, тухайлбал хайнга боловсруулсан аргачлал, шинж Чанараа өөр төрлийн даалгаврууд, бүрхэг томъёологдсон зааварчилгаа г.м.
- Судлаачийн зан үйл дэх ялгаа (туршилтаас туршилтад өөр өөрөөр зааварчилгаа өгөх туршигдагчдыг янз бүрийн аргаар сэдэлжүүлэх г.м
- Туршигдагчдын сэтгэлийн хөдөлгөөний байдал, ядаргаа г.м.
- Туршигдагчдын сэдэлжилтийн түвшин г.м
- Судалгаа явагдах өрөө тасалгааны гэрэлтүүлэг, агаарын хэм, хөндлөнгийн дуу чимээ
- Үр дүнг үнэлж тайлбарлах арга, түүнд илэрч болох субъектив хүчин зүйл.

Эдгээр бүх хүчин зүйлийг харгалзаж, хэмжилтийн нарийвчлалыг бууруулах нөхцөлийг арилгаснаар тестийн баталгаат чанарыг зохих түвшинд хүргэх боломжтой. Ийнхүү, өргөн утгаараа, тестийн баталгаат чанар гэдэг нь тестийн үр дүнгээр туршигдагчдад илрэх ялгаа ямар хэмжээнд хэмжигдэх шинж чанарын бодит ялгааны тусгал болж, ямар ямар хэмжээнд

тохиолдлын алдаатай холбоотой болохыг илэрхийлэх тодорхойлолт юм. Арга зүйн явцуу утгаараа, баталгаат чанар гэдэгт нэг хэсэг туршигчдад өөр өөр хугацаанд тестийг давтан хэрэглэх, тестийн өөр өөр, гэхдээ шинж чанарын хувьд хооронд нь харьцуулах боломж бүхий багц даалгавар хэрэглэх зэргээр судалгааны нөхцөлийг өөрчлөхөд тестийн үр дүн уялдаа холбоотой байх хэм хэмжээг ойлгодог.

Аргачлалын баталгаат чанарт оношлогдож буй түүвэр ихээхэн нөлөө үзүүлдэг. Түүвэр энэхүү үзүүлэлтийг бууруулж ч болно эсвэл дээшлүүлж ч болно. Тухайлбал, туршигдагчдын үнэлгээний тархалт бага байж, үр дүн нь өөрийн утгаар бие биедээ ойр байх тохиолдолд баталгаат чанар зохиомлоор дээшилж болно. Энэ тохиолдолд давтан судалгаа явуулахад гарах үр дүн мөн л нягт бүлгээр байрладаг. Туршигдагчдын эрэмбийн өөрчлөлт ялимгүй бага байх бөгөөд аргачлалын баталгаат чанар өндөр байна. Баталгаат чанар ингэж үндэслэлгүй дээгүүр байх үзэгдэл нь тестээр хамгийн өндөр болон хамгийн доогуур үр дүнтэй бүлгээс бүрдэх түүвэрт анализ хийхэд үүсдэг. Энэ тохиолдолд тохиолдлын хүчин зүйлийн нөлөөн бор бие биеэсээ хол байх үр дүн дарагдаж чадахгүй. Иймээс зохиогч аргачлалын баталгаат чанарыг тогтоосон түүврийг тестийн удирдамжинд тодорхойлсон байдаг.

Сэтгэц оношилгооны практикт баталгаат чанар нь ихэвчлэн нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн бэлтгэл зэргээр ижил төстэй туршигдагчдын түүвэр дээр тодорхойлогддог. Ийм түүвэр тус бүрийн хувьд баталгаат чанарын коэффициентийг тооцож гаргана. Баталгаат чанарын энэхүү үзүүлэлт зөвхөн түүнийг тодорхойлсон түүвэртэй төстэй түүврийн хувьд л хүчин төгөлдөр байх болно. Баталгаат чанарыг шалгасан түүврээс ялгаатай түүвэр дээр аргачлалыг хэрэглэх тохиолдолд энэхүү үзүүлэлтийг дахин шинээр тогтоох шаардлагатай.

Сэтгэц оношилгооны аргачлалын баталгаат чанарыг дээшлүүлэх нэг чухал арга зам бол судалгааны ажилбарын стандарчилал юм. Судалгааны ажилбарыг стандарчилснаар тестийн үр дүнд нөлөөлөх хөндлөнгийн хүчин зүйлийн нөлөө болон алдааны дисперс багасч, тестийн баталгаат чанар дээшлэх болно.

Баталгаат чанарын коэффициент нь гэдэг нь сэтгэл зүйн сорилын баталгаат чанарын статистик үзүүлэлт юм. Баталгаат чанарыг тодорхойлоход корреляцийн анализын аргыг хэрэглэдэг. Ре-Тест баталгаат чанарыг тодорхойлоход эхний болон давтан судалгааны үр дүнгийн корреляцийн коэффициентыг, харин зэрэгцсэн хэлбэрүүдийн баталгаат чанарыг тодорхойлоход тестийн өөр өөр хэлбэрийн тусламжтайгаар гарсан үр дүнгийн корреляцын

коэффициентийг ашигладаг. Тестийн хэсгүүдийн баталгаат чанарыг үнэлэхэд Кьюдер-Ричардсон, Спирмер-Брауны томъёонд суурилж тооцсон коэффициентийг хэрэглэдэг. Баталгаат чанарт анализ хийх ихэд дэлгэрсэн арга бол альфа коэффициентийг тооцох арга байдаг. Хүчин зүйлт-дисперсийн баталгаат чанарыг тогтооход дисперсийн анализын тусгай аргуудыг хэрэглэдэг. Коэффициент 0.75-0.85-аас доошгүй байх тохиолдолд аргачлалыг баталгаатай гэж үздэг. Баталгаат чанар өндөртэй тестүүд 0.90 ба түүнээс дээш эрэмбийн коэффициенттэй байдаг. Баталгаат чанарыг тодорхойлох судалгаа харьцангуй том (200-аас доошгүй туршигдагчид), эх олонлогийг төлөөлөх чадвартай түүвэр дээр хийгдэх ёстой.

Тестийн үр дүнд нөлөөлөх нөхцөл олон байдгийн адил баталгаат чанарын олон төрөл байдаг. Сэтгэц оношилгооны практикт баталгаат чанарын дараах төрлийг өргөн хэрэглэдэг.

Ре-тест баталгаат чанар (test-retest reliability). Ре-тест баталгаат чанар гэдэг нь тестийн үр дүнгийн баталгаат чанарыг тодорхойлох хамгийн ердийн арга бөгөөд нэг л тестийн тусламжтайгаар туршигдагчдыг давтан оношлох замаар тогтоох аргачлалын баталгаат чанар юм. Энэ тохиолдолд эхний болон хоёр дахь судалгааны үр дүнгийн нийцэл эсвэл түүврийн туршигдагчдын эрэмбэ хэвээр хадгалагдах байдлаар баталгаат чанарыг тодорхойлдог. Баталгаат чанарын коэффициент нь нэг хэсэг туршигдагчид дээр явуулсан хоёр судалгааны үр дүнгийн хоорондын корреляцийн коэффициент байх болно. Интервал шкалын хувьд Пирсоны корреляцийн коэффициент, эрэмбийн шкалын хувьд Спирмен эсвэл Кэндэллийн рангийн корреляцийн коэффициентийг хэрэглэдэг.

Ре-тест баталгаат чанарыг тодорхойлоход эхний болон хоёр дахь судалгааны хоорондын хугацаа онцгой ач холбогдолтой. Зарим судлаачид 2 судалгааны хоорондын зай 6 сараас доошгүй байх хэрэгтэй хэмээн тэмдэглэсэн байдаг (Клайн 1994). Энэхүү хугацаа богино байх тусам оношлогдох шинж чанар эхний туршилтын түвшинг хадгалах магадлал ихтэй байдаг. Энэхүү хугацаа уртсахын хэрээр корреляцийн үзүүлэлтүүд бууруулах, хөндлөнгийн хүчил зүйл нөлөөлөх магадлал мэдэгдэхүйц нэмэгддэг. Учир нь тестээр хэмжих шинж чанаруудын насны зүй тогтолт өөрчлөлт эсвэл судлагдах шинж чанаруудын байдал болон хөгжлийн онцлогт нөлөөлөх үйл явцууд гарч болно. Энэхүү шалтгааны улмаас ре-тест баталгаат чанарыг тодорхойлоход урт биш хугацаа сонгодог. Насны өөрчлөлт болон хөгжил илүү эрчимтэй түргэн явагддаг бага насанд энэхүү хугацаа бүр богино байна. Давтан туршилтын хувьд ямар хугацаа хамгийн оновчтой болох тухай асуултад тодорхой хариулт өгөх төвөгтэй.

Аргачлалын сэтгэл зүйн мөн чанар, судалгаа явуулах нөхцөл, түүврийн онцлогоос үүдэн энэхүү хугацааг судлаач өөрөө тогтооно.

Ре-Тестийн арга нь энгийн, ойлгомжтой хэдий ч түүнийг сэтгэл зүйн ихэнх сорилд хэрэглэхэд зарим бэрхшээл тулгардаг. Тухайлбал,

- Аргачлалыг давтан хэрэглэх, ялангуяа хоёр судалгааны хоорондын зай богино байх тохиолдолд туршигдагчдад сэтгэц оношилгооны тухайн аргачлалтай ажиллах дадал бүрэлдэж, ингэснээр хувийн үзүүлэлтүүд дээшилж болох талтай. Ингэснээр тухайн түүврийн туршигдагчдын эрэмбэ мэдэгдэхүйц өөрчлөгдөж, баталгаат чанарын коэффициент буурч болно.
- Эхний болон давтан оношилгооны хоорондын хугацаа богино байх тохиолдолд туршигдагчид өмнөх хариулт, шийдвэр, зөв болон алдаатай хариултынхаа өмнөх зураглалыг сэргээн санах болно. Үүний үр дүнд хоёр судалгааны үр дүн хамааралгүй байж чадахгүй бөгөөд тэдний хоорондын корреляцийн зохиомлоор өндөр гарах болно
- Тестийг давтан хэрэглэх нь түүний мөн чанар өөрчлөгдөхөд хүргэж болно. Энэ нь юуны өмнө авхаалж самбаа шаардсан даалгавруудад хамрагддаг. Туршигдагч асуудлыг шийдвэрлэх зарчмыг нэгэнтээ эзэмшсэн тохиолдолд цаашид завсрын үе шатуудыг алгасч, зөв хариулт өгөх болно.

Баталгаат чанарыг тодорхойлох Ре-Тест аргын дээрх сул тал нь түүнийг сэтгэл зүйн ихэнх сорилд хэрэглэх боломжийг хязгаарладаг. Ре-Тест арга нь мэдрэхүй-хөдөлгөөний сорил, хурдны сорилуудын хувьд илүү тохиромжтой.

Зэрэгцсэн хэлбэрүүдийн баталгаат чанар. Ре-Тест баталгаат чанарт илрэх бэрхшээлээс зайлсхийх нэг арга зам бол тестийн зэрэгцсэн хэлбэрүүдийг (alterenative forms) хэрэглэх арга юм. Энэ нь тестийн харилцан бие биеэ солих хувилбаруудын тусламжтайгаар сэтгэц оношилгооны аргачлалын баталгаат чанарыг тогтоох арга юм. Баталгаат чанарыг ийм аргаар тодорхойлох хэд хэдэн хувилбар байдаг. Үүнд:

- Эхний тохиолдолд баталгаат чанарыг тодорхойлох түүврийн туршигдагчдыг эхлээд үндсэн багц даалгаврын тусламжтайгаар, дараа нь ижил төстэй нэмэлт багц даалгаврын тусламжтайгаар оношилно.

- Хоёр дахь тохиолдолд туршигдагчдын ойролцоогоор тэнцүү хоёр бүлэгт хувааж, нэг бүлэгт тестийн А, нөгөө бүлэгт тестийн Б хувилбарыг өгнө. Тодорхой хугацааны дараа \ихэвчлэн 1 долоо хоногоос хэтрэхгүй\ эсрэг дарааллаар давтан оношилгоо явуулна.

Судалгааны ийм ажиллагаа нь Ре-Тест баталгаат чанарыг тодорхойлох аргын дутагдлаас зайлсхийх боломж олгодог. Үүнд:

- Зэрэгцсэн хэлбэрт агуулгын хувьд өөр материал ашигладаг учраас дасгал сургууль, зарим шийдвэрийг тогтоох боломж багасдаг.
- Давтан судалгааны хоорондын хугацаа багасах нь энэ аргын чухал давуу тал болно.

Зэрэгцсэн хэлбэрүүдийн баталгаат чанарын үндэс үзүүлэлт бол эхний болон давтан судалгааны үр дүнгийн хоорондын корреляцийн коэффициент байна. Тестийн зэрэгцсэн хэлбэрүүдийн хоорондын харьцаа нарийн шинжтэй. Даалгаврын хоёр багц нь ижил үзүүлэлтийг хэмжиж, ижил үр дүн өгч, ижил шаардлага хангахын зэрэгцээ бие биеэсээ харьцангуй хамааралгүй байх ёстой. Практикт бүх сорилын хувьд ялангуяа бие хүнийг судлах аргачлал, асуулгын хувьд энэхүү зорилт хэрэгжих боломжгүй байдаг нь зэрэгцсэн хэлбэрүүдийн баталгаат чанарыг хэрэглэх хүрээг хязгаарладаг. Зэрэгцсэн хэлбэрүүдийн баталгаат чанарын өөр нэг дутагдал бол үндсэн болон нэмэлт хувилбаруудын даалгаврын шийдлийн нийтлэг зарчмыг эзэмших боломж юм. Ийнхүү Ре-Тест баталгаат чанартай харьцуулахад зэрэгцсэн хэлбэрүүдийн баталгаат чанарыг үнэлэх тохиолдолд дасгал сургууль болон давтан судалгааны явцад эзэмших дадлын нөлөө багасах хэдий ч бүрэн устаж үгүй болохгүй. Тестийн хэсгүүдийн баталгаат чанар (split-half). Тестийн хэсгүүдийн баталгаат чанар гэдэг нь тестийн салангид даалгаврын үр дүн хэр тогтвортой байгаад задлан шинжлэл хийх замаар хийх сэтгэц оношилгооны аргачлалын баталгаат чанар юм.

Сорилын даалгавруудыг зөв сонгож, аргачлал нь нэг төрөл байж чадсан эсэхээс сэтгэл зүйн аль ч хэмжилтийн нарийвчлал, бодит чанар хамаардаг байна. Аргачлалын дотоод нэг төрөл шинж байдал нь аргачлалын даалгаврууд нэг л шинж чанарыг хэмжиж буйг харуулдаг. Хэмжих хэрэгсэл нэг төрөл (гомоген) байгааг илэрхийлж, тестийн хэсгүүдийн баталгаат чанарыг тодорхойлох хамгийн энгийн бөгөөд ихэд дэлгэрсэн арга бол тестийг хүнд, хөнгөний түвшингээр ижил хэсгүүдэд хуваах арга юм. Энэхүү аргын мөн чанар нь туршигдагч тестийн адил үнэ цэнэ бүхий хоёр хэсэг даалгаврыг гүйцэтгэхэд оршино. Бүхэл тестээр гарах үнэлгээ хэвийн эсвэл хэвийн тархалтад ойр байх тохиолдолд тестийн хэсгүүдийн аль ч багц даалгаврын гүйцэтгэл ижил төстэй хуваарилалттай байна гэсэн дүгнэлт нь уг аргын үндэслэл

болно. Ийм аргаар баталгаат чанарыг үнэлэхэд шинж чанар болон хүндрэлийн түвшнээр ижил (эквивалент) хоёр бүлэг даалгавар сонгоно. Тестийг дараах арга замаар харьцуулах хэсгүүдэд хуваадаг. Үүнд:

- Даалгавруудыг тэгш болон сондгой дугаараар хуваарилах (тестийн даалгаврууд субъектив хүндрэлийн түвшнээр нарийн чанд эрэмблэгдсэн тохиолдолд);
- Тестийн эхний хэсгийг хоёр дахь хэсэгтэй харьцуулах, эсвэл тестийг дөрвөн хэсэгт хувааж, нэг ба гурав, хоёр ба дөрөв дэх хэсгийг хооронд нь харьцуулж болно.
- Хүндрэл болон дискриминатив индексийн утга ойролцоо буюу ижил байх зарчмаар даалгавруудыг хуваарилах (хуваарилалтын ийм зарчим нь туршигдагч бүх асуултад хариулах шаардлагатай амжилтын тестийн хувьд ихэд тохиромжтой).
- Хурдыг чухалчилдаг тестийн хувьд хэсэг тус бүрийг шийдвэрлэх хугацаагаар даалгавруудыг хуваарилдаг.

Тэгш болон сондгой дугаараар хуваах арга илүү үр өгөөжтэй байдаг. Учир нь энэ арга нь дасгал сургууль, ядрах г.м. хүчин зүйлийн нөлөөллөөс харьцангуй хамааралгүй байдаг байна. Тестийн хэсгүүдийн баталгаат чанарын давуу тал нь давтан оношилгоо явуулах шаардлагагүй байдагт оршино. Ингэснээр дасгал сургууль, өмнөх хариултыг тогтоох зэрэг хөндлөнгийн олон хүчин зүйлийн нөлөөлөл үгүй болно.

Кьюдер-Ричардсоны томьёо (Kuder-Richardson formula). Салангид даалгавруудын баталгаат чанарыг үнэлэх ихэд дэлгэрсэн арга бол Кьюдер-Ричардсоны коэффициентийг тооцох арга юм. Баталгаат чанарыг энэхүү аргаар тодорхойлоход сорилын нэг хувилбарыг ганц л удаа хэрэглэдэг бөгөөд сорилын бүх даалгавраар өгөх хариултын уялдаа холбоог үнэлдэг. Тестийг хэсгүүдэд хуваах аргын адил дотоод уялдаа хамаарлыг тестийн нэг л хувилбарыг нэг л удаа хэрэглэх аргаар илрүүлэх хэдий ч тестийн эквивалент хоёр хэсгийн оронд даалгавар тус бүрийн гүйцэтгэлийн үр дүнд тулгуурладаг. Кьюдер-Ричардсоны хамгийн өргөн хэрэглэгддэг томьёо нь KR-20 томьёо юм:

$$r_t = \frac{k}{k-1} \left[\frac{\sigma_x^2 - \sum pq}{\sigma_x^2} \right]$$

r_t - бүхэл сорилын баталгаат чанарын коэффициент;

K - сорилын даалгаврын тоо;

σ_x - сорилын нийлбэр үзүүлэлтүүдийн стандарт хазайлт;

p - хүндрэлийн индекс

$q = 1 - p$

Даалгаврын гүйцэтгэлийг зөв эсвэл буруу гэж үнэлэх сорилуудын хувьд Кьюдер-Ричардсоны томъёог хэрэглэх боломжтой.

Альфа коэффициент. Альфа коэффициент нь дисперсийн анализад хэрэглэгддэг статистикийн үзүүлэлт юм. Америкийн сэтгэл судлаач Л.Кронбах (1971) санал болгосон. Тестийн баталгаат чанарыг үнэлэхэд өргөн хэрэглэгддэг.

$$a = \frac{n}{n-1} \left[1 - \frac{\sum \sigma_i^2}{\sigma_j^2} \right]$$

n – тестийн даалгаврын тоо

σ_j^2 – бүхэл тестийн стандарт хазайлтын квадрат

$\sum \sigma_i^2$ – салангид даалгавруудын стандарт хазайлтын квадратын нийлбэр

Аргачлалд дихотом хэв шинжийн даалгаврууд (“тийм”-“үгүй”, “зөв”- “буруу”) хэрэглэсэн тохиолдолд хялбаршуулсан дараах томъёог хэрэглэдэг.

$$a = \frac{n}{n-1} \left[1 - \frac{\sum PQ}{\sigma_j^2} \right] \sum PQ = \sum \sigma_j^2$$

P – зөв хариулт өгсөн судлуулагчдын эзлэх хувь $Q = 1 - P$

Альфа коэффициентийн дихотом хувилбар нь Кьюдер-Ричардсоны томъёо юм.

Субъектив үнэлгээний баталгаат чанар. Энэ тохиолдолд өөр өөр шинжээчид хэсэг хүмүүсийг нэг л тестийн тусламжтайгаар судалж, тэдний судалгааны үр дүнг харьцуулж баталгаат чанарыг тодорхойлдог. Баталгаат чанарын энэ төрлийг тодорхойлохдоо шинжээчдийн бие биеэсээ хамааралгүй хөтөлсөн үнэлгээний хуудас, протоколыг хооронд нь харьцуулдаг. Ийм аргаар гарсан корреляцийн коэффициент нь баталгаат чанарын хэмжүүр болно.

Дотоод зохицлын баталгаат чанар. Дотоод зохицлын баталгаат чанар нь тестийг брдүүлэх даалгавруудын хоорондын интеркорреляцийн холбоо хамаарлын хэм хэмжээнд суурилж баталгаат чанарыг тодорхойлох арга юм.

Хүчин зүйл-дисперсийн баталгаат чанар. Хүчин зүйл-дисперсийн баталгаат чанар гэдэг нь тестийн үр дүнгийн дисперсийн анализ дээр суурилж баталгаат чанарыг тодорхойлох арга юм. Энэ тохиолдолд тестийн баталгаат чанар нь бодит дисперс (судалж буй хүчин зүйлийн дисперс) болон гарсан эмпирик дисперсийн харьцаагаар тодорхойлогддог. Эмпирик дисперс нь бодит дисперс болон хэмжилтийн алдааны дисперсээс бүрддэг.

Тохироц чанар Баталгаат чанарын дараа аргачлалын чанарыг үнэлэх гол үзүүлэлт бол тохироц чанар(Validity) юм. Аргачлалын баталгаат чанар тогтоогдсоны дараа түүний тохироц чанарын тухай асуудал шийдвэрлэгдэнэ. Учир нь баталгаат чанар хангаагүй аргачлал тохирохуйц байж чадахгүй. Аргачлалын тохироц чанарын талаарх мэдээлэлгүйгээр хамгийн найдвартай аргачлал ч үр ашиггүй байх болно.

Тохироц чанар нь судлах үзэгдлийн талаарх мэдээлэл болон тэдгээрийг үнэлэх ажилбарын төлөөлөх (репрезентатив) чанарыг агуулсан аргачлалын цогц тодорхойлолт юм.

Тохироц чанарын тухай асуудал нилээд төвөгтэй нарийн асуудлын нэг юм. А.Анастази тохироц чанарыг”...тест юуг хэмжиж байна вэ?, хэмжилтийг хэр зэрэг сайн хийж чадаж байна вэ?” гэдгийг харуулж буй ойлголт хэмээн тодорхойлсон байна.⁶ 1974 онд Америкийн сэтгэл судлаачдын холбооноос (APA) боловсруулсан “Боловсрол болон сэтгэл зүйн тест оношилгооны стандартад тохироц чанарыг тодорхойлохдоо “...аргачлалын тусламжтайгаар бие хүний сэтгэл зүйн аль бүлэг шинж чанарын талаар дүгнэлт хийж болох тодорхой тестийн үнэлгээ эсвэл үнэлгээний бусад хэлбэрт тулгуурласан дүгнэлт хэр үндэслэлтэй болох тухай цогц мэдээ”⁷ гэсэн байна.

Тохироц чанар нь нэг талаас аргачлал хэмжих ёстой зүйлээ хэмжихэд тохирч байгаа эсэх нөгөө талаас аргачлал хэр өгөөжтэй байгааг тусгах цогц ойлголт юм. Тохироц чанар нь тестийн үр дүн судлуулагчийн талаар бусад эх сурвалжаас авсан мэдээ баримттай нийцэж тохирох хэм хэмжээ судлагдаж буй чанарын хэтийн төлөвийн талаарх урьдчилсан дүгнэлтийн үндэслэл зэрэг асуудлыг хамардаг. Ийнхүү тохироц чанар нь тестийн тухай олон төрлийн мэдээлэл агуулдаг. Энэ шалтгааны улмаас тохироц чанарыг тодорхойлох нэгдмэл хандлага байдаггүй.

Судлаач тохироц чанарын аль талыг авч үзэж байгаагаас хамаарч баталгаа нотолгооны өөр өөр арга хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, тохироц чанарын тухай ойлголт нь өөрийн өвөрмөц утга бүхий өөр өөр төрлийг агуулдаг.

Тохироц болон баталгаат чанарын тухай ойлголтын ялгааг хэмжилтийн объект болон зүйл гэсэн ойлголтуудаар дамжуулж тайлбарлах нь тохиромжтой. Аль ч хэмжилтийн тохироц

⁶ Анна Анастази, Сьюзан Урбина (2006) *Психологическое тестирование*. Москва

⁷ *The standards for educational and psychological testing*. (1974) British Columbia

чанар нь объектуудын хэмжигдэх шинж чанаруудын хувьд өөрөөр хэлбэл, хэмжих зүйлийн хувьд гарсан үр дүн ганц утгат (тогтвортой) байхад оршино.

Харин баталгаат чанарын мөн чанар нь ажилбар объектуудын хувьд тогтвортой байхад оршино. Туршилтын объектуудын хувьд тест тогтвортой байх нь объектуудын хэмжигдэх шинж чанаруудын хувьд тогтвортой байх байдлын шаардлагатай боловч хангалтгүй нөхцөл болдог. Өөрөөр хэлбэл, баталгаат чанар нь тохироц чанарын шаардлагатай боловч хангалтгүй нөхцөл юм.

Тохироц чанар < баталгаат чанар Дээрх харьцаа нь тестийн тохироц чанар баталгаат чанараас давуу байж болохгүй гэдгийг харуулж байна. Гэхдээ дээрх харьцааг тохироц болон баталгаат чанарын шууд пропорционал холбоо хамаарал гэж ойлгож болохгүй. Баталгаат чанар дээшлэхэд тохироц чанар заавал дээшлэх албагүй.

Тохироц чанарын коэффициент гэдэг нь тестийн эмпирик тохироцын статистик үзүүлэлт юм. Тохироц чанарын коэффициентыг тооцоход корреляцийн анализын аргыг өргөн хэрэглэдэг. Тохироц чанарыг 200-аас дээш туршигдагчдын түүвэр дээр тодорхойлох нь тохиромжтой болохыг судлаачид тэмдэглэсэн байна. Тохироц чанарын коэффициент статистикийн ач холбогдол бүхий түвшинд байх ёстой. Тохироц чанарын эрэмбийн коэффициент 0.20-0.30-ын хооронд байвал доогуур, 0.30-0.50-ын хооронд бол дундаж, харин 0.60-аас дээш байвал өндөр гэж үздэг.

Конструкт тохироц чанар (construct validity). 1954 онд сэтгэл зүйн тест болон оношилгооны аргачлалуудад зориулсан "техникийн зөвлөмж" (technical recommendations for psychological tests and diagnostic techniques) хэмээх тест оношилгооны орчин үеийн стандартуудын анхны хэвлэл гарснаар сэтгэц хэмжил зүйчдийн үгийн санд "конструкт тохироц чанар" хэмээх нэр томъёо албан ёсоор нэмэгдсэн. Дараагийн жил Кронбах, Мил нар өөрсдийн өгүүлэлд (Cronbach and Meehl, 1955) конструкт тохироц чанарын анхны дэлгэрэнгүй тодорхойлолтыг тусгажээ.

Конструкт тохироц чанар гэдэг нь судалж буй сэтгэл зүйн конструкт ямар хэмжээнд тестийн үр дүнгийн хувьд төлөөлөх шинжтэй байгааг тусгах тохироц чанарын үндсэн төрлийн нэг юм.⁸ Конструктын хувьд практик эсвэл вербал оюун ухаан, сэтгэл хөдлөлийн

⁸ Г.Сарантуяа (2018) Сэтгэц оношилгоо. Улаанбаатар

тогтворгүй чанар, интроверси, хэл яриаг ойлгох, анхаарлын шилжилт, нейротизм, түгшүүр зэргийг авч үзэж болно. Өөрөөр хэлбэл, конструкт тохироц чанар нь тестээр хэмжих сэтгэл зүйн үзэгдлүүдийн онолын бүтцийн хүрээг тодорхойлдог.

Тестийн үр дүн болон онолын конструктын холбоо хамаарлыг тайлбарлахад хэмжих шинж чанарын мөн чанар, түүний хөгжлийн динамик, сэтгэцийн бусад үзэгдлүүдтэй тогтох харилцан үйлчлэлийн талаар төрөл бүрийн мэдээллийг цуглуулах шаардлагатай.

Конструкт тохироц чанарыг тодорхойлох аргын нэг нь тухайн тестийн үр дүнг конструкт агуулга нь тогтоогдсон бусад аргачлалтай харьцуулах арга юм. Шинэ болон конструктын хувьд ижил төстэй тестийн хооронд орших корреляци нь боловсруулж буй тест жишиг аргачлалтай ижил зан үйлийн хүрээ, чадвар, хувийн онцлогийг "хэмжиж" байгааг илэрхийлнэ.

Шалгуур үзүүлэлтийн тохироц чанар нь аргачлалын урсгал болон урьдчилан дүгнэлт хийх тохироц чанарыг агуулж, онош болон урьдчилсан таамаг нь хэмжигдэх үзэгдлийн шалгуурын тодорхой хүрээнд тохирох хэмжээг тусгах цогц тодорхойлолт юм. Ихэнх аргачлал, ялангуяа авьяас чадвар болон оюун ухааны тестүүд нь оношлох болон урьдчилсан тохироц чанараар тодорхойлогддог.

Тохироц чанарын энэхүү 2 хэв шинжийг "эмпирик тохироц чанар" хэмээх ойлголтод нэгтгэх нь элбэг. Өөрөөр хэлбэл, тэдгээрийг тодорхойлох нийтлэг хандлагыг тэмдэглэж байгаа бөгөөд энэ нь тестээр гарсан оноо болон гадаад шалгуурын хоорондын статистикийн корреляцийг тогтоох замаар хэрэгжинэ.

Тохироц чанарын шалгуур үзүүлэлт нь оношлогдох сэтгэл зүйн онцлогуудын хэмжүүр болдог. Тухайлбал, тусгай авьяас чадварын тестийг бусад хичээлийн сурлагын дүн, дуу хөгжим, зураг зэрэг хичээлийн амжилттай харьцуулах замаар шалгана. Оюун ухааны ерөнхий чадварын тестийг сурлагын амжилттай (сурлагын ерөнхий амжилт, мэдлэг болон дадлын нарийн тогтолцоог эзэмшсэн байдал) харьцуулах замаар тохироц чанарыг нь тогтоодог. Тохироц чанарын үзүүлэлт нь тестээс хамааралгүй, практик үйл ажиллагааны тодорхой салбарын хувьд үнэ цэнэ бүхий үзүүлэлт байна.

Тухайлбал, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын салбарын хувьд "сурлагын амжилт" хөдөлмөрийн сэтгэл судлалд "хөдөлмөрийн бүтээмж" анагаах ухааны сэтгэл судлалд "эрүүл мэндийн байдал" байж болно.

Шууд шалгуурын хувьд шинжээчдийн үнэлгээ болон багш, сурган хүмүүжүүлэгчид, удирдах албан тушаалын хүмүүсээс судалгаанд оролцсон хүмүүсийн талаар өгөх тодорхойлолтыг ашиглах нь элбэг байдаг.

Тухайлбал, нийгмийн интроверсийг хэмжих асуулгын шалгуур үзүүлэлтийн тохироц чанарыг тогтооход тестийн үр дүнг судлуулагчийн сайн мэддэг хүмүүсийн үнэлгээ, тухайн онцлог судлуулагчийн зан үйлд илрэх байдлыг ажигласан ажиглалтын үр дүн, харилцааны хүрээний талаарх объектив мэдээлэлтэй харьцуулж болно. Амжилтын тестийн тохироц чанарыг тогтооход хэмжилтийн үр дүнг судлуулагчийн мэдлэг чадварын талаарх багшийн үнэлгээ, сурлагын дүн, хяналтын ажлын үнэлгээ зэрэгтэй харьцуулдаг.

Шалгуур үзүүлэлтийн тохироц чанар нь судлах үзэгдлийн тухайн үеийн байдал болон ирээдүйн төлөв байдлын талаарх урьдчилсан таамгийн магадлал болон үндэслэлийг агуулж байдаг. Энэ тохиолдолд шалгуур үзүүлэлтийн тохироц чанарын хүрээнд урсгал болон урьдчилсан тохироц чанарыг ялгаж үздэг.

Урсгал буюу оношлох тохироц чанар нь туршигдагчдыг оношилж буй шинж чанараар ялгах тестийн чадварыг тусгадаг. Ийм шинж чанарын хувьд ерөнхий авьяас чадвар, санаархлын түвшин, вербал оюун ухаан, түгшүүр зэргийг нэрлэж болно.

Явцуу утгаараа, урсгал буюу оношлох тохироц чанар гэдэг нь тохироц чанарыг нь тогтоож буй тестийн үзүүлэлтүүд судалгааны үе мөч дэх оношлогдох шинж чанарын байдлыг тусгах хамааралгүй шалгуур үзүүлэлтэд тохирч байгааг тогтооход оршино. Урсгал тохироц чанарыг тодорхойлогдох үндсэн арга зам бол тестийн үр дүн болон оношлох шинж чанарын шалгуурын хооронд корреляцийн хамаарал тогтоох арга юм.

Шалгуур үзүүлэлтийн тохироц чанарыг тодорхойлох зайлшгүй нөхцөл бол тестийн үр дүнг тохироцын шалгууртай харьцуулахад оршино.

Практикт тохироцын шалгуурын хувьд дараах үзүүлэлтийг хэрэглэдэг байна. Үүнд:

- Нийгэм хүн ам зүй болон намтар түүхтэй холбоотой өгөгдлүүд (ажилласан жил, боловсрол, мэргэжил, ажилд орсон, ажлаас халагдсан хугацаа)
- Амжилтийн үзүүлэлтүүд (юуны өмнө , авьяас чадварын тест, оюун ухааны тест)
- Мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн бүтээмжийг илэрхийлэх үзүүлэлтүүд
- Ерөнхий болон тусгай авьяас чадвар , бие хүний хувийн онцлогийг үнэлэх тестийн тохироц чанарыг тогтооход бодит үйл ажиллагааны үр дүндсуурилдаг (зурах, загвар бүтээх, дуу хөгжим , өгүүлэл зохиох)
- Эмчийн онош , мэргэжлийн хүмүүсийн үнэлгээ дүгнэлт
- Мэдлэг чадварын сорил
- Тохироц чанар нь тогтоогдсон бусад аргачлал, тестийн мэдээ

Тестийн үр дүн болон шинжээчдийн үнэлгээг харьцуулах замаар шалгуур үзүүлэлтийн тохироц чанарыг тогтооход шалгуур үзүүлэлтийн контаминацийн үзэгдэл илэрч болно. Энэ нь судлуулагчийн оношлогооны үр дүнгийн талаарх мэдээлэл бусад хүмүүсийн зүгээс түүнд хандах субъектив хандлагад нөлөөлөх үзэгдэл юм. Тухайлбал, сурагч нэг хичээлийн тестийг амжилтгүй гүйцэтгэх тохиолдол нь түүний сурах үйл ажиллагаа, сурлагын амжилт болон зан үйлийг үнэлэх багшийн субъектив үнэлгээнд нөлөөлж болно. Контаминацийн үзэгдэл нь сэтгэц оношилгоонд сөрөг нөлөөтэй байдаг. Ийм үзэгдэл нь сэтгэц оношлогооны судалгааны ёс зүйн зарчмыг баримтлах шаардлагыг гаргаж ирсэн.

Агуулгын тохироц чанар гэдэг нь тестийн даалгаврын агуулга хэмжигдэж буй сэтгэцийн шинж чанаруудын хувьд төлөөлөх шинжтэй байх хэм хэмжээг илэрхийлэх тохироц чанарын үндсэн хэв шинжүүдийн нэг юм.

Уламжлалт байдлаар агуулгын тохироц чанарын талаарх цогц мэдээ нь бодит үйл ажиллагаатай төстэй эсвэл түүнд нийцэх үйл ажиллагааг судлах сорилуудын хувьд илүү ач холбогдолтой. Судлагдаж буй үйл ажиллагаа ихэвчлэн нийлмэл шинжтэй байж, өөр өөр төрлийн олон хүчин зүйлээс (хувийн онцлогуудын илрэл, шаардлагатай мэдлэг, чадвар, авьяас чадвар) бүрддэг. Иймээс оношлогдох үйл ажиллагааны зохистой загварыг бүтээхэд судлах үзэгдлийн гол талыг бодит үйл ажиллагаанд нийцүүлж зөв харьцаатай хамрах даалгавруудыг сонгодог. Тийм учраас хүн тодорхой дадал эсвэл тодорхой төрлийн хичээлийг ямар түвшинд эзэмшсэн болохыг хэмжих зориулалттай сорилуудын хувьд тохироц чанарыг тогтоох энэхүү ажилбарыг ихэвчлэн хэрэглэдэг. Ийм тестийн тохироц чанарыг тогтооход түүний агуулгыг авч үзэхэд хангалттай гэсэн сэтгэгдэл төрж болно.

Тухайлбал, зөв бичих дадал чадварыг шалгах зориулалттай тестүүд тодорхойлолтын дагуу зөв бичих үйлдлийг гүйцэтгэх даалгаврыг агуулж байвал тохироц чанарыг хангасан байх ёстой. Гэтэл шийдэл тийм хялбар биш. Оношлогдох бүхий л хүрээг зохистой тусгах даалгаврын түүврийг бүрдүүлэх асуудал шууд гарч ирнэ.

Иймээс юуны өмнө зан үйлийн оношлогдох хүрээнд нарийн шинжлэл хийх шаардлагатай. Ингэснээр тестийн даалгаврууд оношлох хүрээний гол асуудлыг бүрэн бөгөөд зөв зохистой харьцаанд хамарч чадсан гэдэгт итгэлтэй байж болно. Объектив даалгавар хялбархан зохиож болох чиглэлээр тестийг амархан ачаалж болно. Харин тестийг зохиосны дараа биш, харин өмнө оношлох хүрээг аль болох бүрэн дүүрэн тодорхойлох хэрэгтэй. Тухайлбал, зөв зохиогдсон амжилтын тестүүд хичээлийн тодорхой сэдэв төдийгүй, сургалтын зорилго, зорилтуудыг хамарч байх ёстой. Ийнхүү агуулгыг илүү өргөн хүрээтэй тодорхойлж, түүнд баримт материалын мэдлэгийн хажуугаар судалсан дүрмийн хэрэглээ, баримтын тайлбар зэрэг сургалтын чухал зорилтуудыг багтаах шаардлагатай.

Шинээр зохиож буй аргачлалын даалгавруудыг сонгох тэр үеэс агуулгын тохироц чанарын асуудал гарч ирнэ. Тохироц чанарыг тогтоох ажилбар дараах үе шаттай. Үүнд

- Оношлох шинж чанар болон үйл ажиллагааны хүрээг тодорхойлох, нийлмэл чадвар эсвэл үйл ажиллагааг бүрэлдэхүүн хэсгүүдэд задлах
- Бодит үйл ажиллагааны хамгийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн үндсэн дээр тестийн үйл ажиллагааны загварыг боловсруулах
- Боловсруулсан загвар бодит үйл ажиллагаанд ямар хэмжээнд тохирч байгаад шинжлэл хийх, тестийн даалгавар болон бодит үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харьцаа тохирсон хэсгийг шалгах

Тухайлбал, амжилтын тестийн даалгавруудын агуулгыг боловсруулахын өмнө холбогдох сурах бичиг, хичээлийн хөтөлбөрийг нарийн судалж, тухайн чиглэлийн мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авах шаардлагатай. Ийм замаар цуглуулсан мэдээллийн үндсэн дээр тестийг боловсруулах тодорхойлолт (test specifications) зохиодог. Түүнд тестэд хамрагдах агуулгын хүрээ, сургалтын зорилтууд сэдэв тус бүрийн ач холбогдол зэргийг тусгана. Төгсгөлд нь сэдэв тус бүрээр хэв шинж тус бүрийн даалгаврын шаардлагатай тоо хэмжээг заасан байна. Шинжээчид тодорхой даалгаврууд бодит шаардлагад тохирч байгаа эсэхийг үнэлж, тухайн тест холбогдох мэдлэг, дадлыг төлөөлж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийнэ.

Шинжээчдийн үнэлгээг өргөн ашигласнаар агуулгын тохироц чанар нь шалгуур үзүүлэлтийн тохироц чанарыг тодорхойлох ажилбартай ойртож ирдэг. Гэхдээ агуулгад задлан шинжлэл хийхэд шинжээчдийн үнэлгээ тестийн өөрийнх нь шалгуур үзүүлэлт байдаг бол шалгуур үзүүлэлтийн тохироц чанарыг тодорхойлоход шинжээчдийн үнэлгээ нь стандартчиллын түүврийн туршигдагчдад хамааралтай байдагт тохироц чанарын энэхүү хоёр төрлийн гол ялгаа оршино. Агуулгын тохироц чанар нь шалгуур үзүүлэлтэд баримжаалсан тестийн хувьд ихэд тохиромжтой. Ийм тестийн гүйцэтгэлийн тодорхой салбар эсвэл үйл ажиллагааны агуулгын үүднээс тайлбарладаг учраас тэдгээрийн үр өгөөжтэй хэрэглэх эхний чухал нөхцөл бол агуулгын тохироц чанарыг тодорхойлох асуудал юм.

Агуулгын тохироц чанар нь амжилтын тест, мэргэжил сонголт, боловсон хүчний хуваарилалт, мэргэжил эзэмших амжилтад анализ хийх зориулалттай зарим тестийн хувьд тохиромжтой. Нөгөө талаас, агуулгын тохироц чанар нь авьяас чадварыг оношлох, бие хүний онцлогийг тодорхойлох тестийн хувьд тохиромжгүй байдаг.

Гадаад тохироц чанар (face validity, faith validity). Энэ нь мэргэжлийн бус хүмүүс тест “үндэслэлтэй харагдах ” асуудалтай холбоотой. Мөн чанараа “Face” тохироц чанар нь “раппорт” болон “паблик рилейшнз” , өөрөөр хэлбэл судлаачид болон олон нийттэй холбоо харилцаа тогтоох асуудалтай холбоотой.

“Face” тохироц чанар гэдэг нь аргачлалыг хэрэглэх шинж чанар, зорилгын талаар мэргэжлийн тусгай мэдлэггүй туршигчдагч эсвэл өөр хэн нэгэн хүн тест, түүнийг хэрэглэх хүрээ, үр өгөөж болон урьдчилсан дүгнэлт хийх чадавхын талаар үүсэх төсөөлөл юм. “FACE” тохироц чанар нь бодитойгоор тогтоох тохироц чанарын бүрэлдэхүүн хэсэг биш хэдий ч өндөр байх нь чухал юм. “FACE” тохироц чанар нь туршигдагчдыг судалгаанд сэдэлжүүлж өгдөг хүчин зүйл бөгөөд тестийн гүйцэтгэл болон сэтгэл судлаачийн томъёолох дүгнэлтэд илүү нухацтай , хариуцлагатай хандахад нөлөөлдөг.

“FACE” тохироц чанарын түвшин хангалттай байх нь насанд хүрэгчдийг оношлох аргачлалуудын хувьд онцгой ач холбогдолтой.

Тестийн даалгавруудын агуулга хэт хялбар, хөнгөн, судалж буй үйл ажиллагааны мөн чанарт тохироогүй мэт санагдах тохиолдолд туршигдагчдын зүгээс судалгааны нөхцөлд хайхрамжгүй, үл ойшоосон байдлаар хандах хандлагыг бий болгож болно. Үүний эсрэг

аргачлалын боломжийг хэт үнэлэх, түүний чиг зорилго болон урьдчилсан дүгнэлтийн ач холбогдлын талаар буруу төсөөлөлтэй байх нь хүчтэй сэдэлжилт, сэтгэл хөдлөлийн хүчдэл, илэрхий тогтсон зан үйлийг бий болгож болно.

Энэ нь хүсмээр зүйл биш юм. Эдгээр тохиолдолд шаардлага хангаагүй “FACE” тохироц чанарын улмаас тестийн бодит тохироц чанар буурч болно. “FACE” тохироц чанарын талаарх туршигдагч болон сэтгэц оношлогооны мэдээллийн хэрэглэгчдийн төсөөлөлд аргачлалын нэр хаяг багагүй нөлөөлдөг.

Учир нь тестийн тухай мэдээллийн энэ хэсэг энэ мэргэжлийн бус хүмүүст хамгийн хүртээмжтэй байдаг. Аргачлалын талаарх буруу төсөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд судалгааны маягт, асуулгын хуудас, тестийн дэвтэр буруу ойлгогдож болох бүрхэг, үндэслэлгүй гарчиг (тухайлбал, “Би хүний тест”, “Оюуны чадварын тест”, “Амжилтыг үнэлэх цогц сорил” г.м.) тавихаас зайлсхийх хэрэгтэй. Зааварчилгад судалгааны зорилгыг товч тодорхойлох замаар гадаад тохироц чанарыг дээшлүүлдэг.

Ойлгомжтой томъёолол, нэр томъёо, түүнчлэн агуулгын хувьд туршигдагчдын нас, хүйс, мэргэжлийн онцлогийг харгалзсан даалгавруудыг хэрэглэх нь “FACE” тохироц чанарыг мэдэгдэхүйц сайжруулдаг. Үндэслэлгүй дээшлүүлсэн “FACE” тохироц чанар нь шалгуур үзүүлэлтийн контаминацийн нөлөөг нэмэгдүүлж болно.

Стандартчилал Стандартчилал (англ, standard-хэв шинжид хэвийн) гэдэг нь тестийн ажилбар болон үнэлгээг нэгдмэл жишигт оруулахыг хэлнэ. Аргачлалыг стандартчилснаар туршигдагчдын үр дүнг хооронд нь харьцуулах, тестийн үнэлгээг хооронд нь харьцуулах боломж бүрдэнэ.

Сэтгэц оношилгоонд стандартчиллын хоёр хэлбэрийг ялгаж үздэг. Эхний тохиолдолд стандартчилал гэдэгт тестийн үр дүнг боловсруулах, тестийг явуулах ажилбарыг нэгдмэл шаардлагад зохицуулах, тестийн зааварчилгаа, үр дүнг тэмдэглэх арга, судалгаа туршилт явуулах нөхцөлийг нэгдмэл жишигт оруулахыг ойлгоно.

Судалгаа туршилтын ажилбарыг ингэж нарийн чанд тогтоох нь тестийн жишиг хэмжээг тодорхойлох зайлшгүй нөхцөл болдог. Хоёр дахь тохиолдолд стандартчилал гэдэгт үнэлгээний хэвийн (нормал) хэмжүүрийг шинэхэмжүүрт шилжүүлэхийг ойлгодог. Энэхүү

шинэ хэмжүүр нь судалж буй үзүүлэлтийн эмпирик тоон утгад бус, харин түүвэр дэх үр дүнгийн тархалтад түүний эзлэх байршилд тулгуурладаг.

Сэтгэц хэмжил зүйд анхдагч үнэлгээг шилжүүлэх хамгийн дэлгэрсэн арга зам бол дундаж квадрат хазайлтын тусламжтайгаар жишиг хэмжээг тогтоох арга юм. Голч дүнг тогтооно гэдэг нь шинж чанарын шугаман өөрчлөлт юм. Ингэхэд тархалтын дундаж утга нь 0-тэй тэнцүү байна.

$$\sum x_{(x < \bar{x})} = \sum x_{(x > \bar{x})}$$

Тухайлбал, шинээр боловсруулж буй тестийн тусламжтайгаар бүлэг туршигдагчдыг судлахад анхдагч онооны дундаж утга $\bar{x} = 17$ гарсан гэж үзэхэд энэхүү тоог хэмжүүрийн тооцооны төвийн (голч) хувьд авч үзэж, түүний хоёр тал руу $x < \bar{x}$ болон $x > \bar{x}$ үзүүлэлтүүд (үнэлгээний хэвийн тархалт батлагдсан тохиолдолд) симметри байдлаар байрлана.

Жишиг хэмжээ тогтоох ажилбар нь хэмжилтийн өөр масштабт (нэгж) шилжихэд оршино. Энэ нь дараах тусламжтайгаар хэрэгжинэ

$$f(x) = \frac{hn}{\sigma} f(\gamma)$$

n-стандартчиллын түүврийн гишүүдийн тоо

h-эмпирик тархалт дахь өгөгдлийн бүлгийн интервалын урт

f(x)-эмпирик түүвэр дэх онолын давтамж

s-түүврийн стандарт хазайлт

f(γ)-x_i утгын нормчлолын функц

Нормчлолын функцын хувьд ихэвчлэн z-үзүүлэлтийг (стандарт үзүүлэлтийг) авч үздэг. Энэ нь хувь хүний үр дүнгийн хазайлтад пропорционал байх x_i нэгжээр илэрхийлнэ. Хэвийн аль ч муруйтай нийцүүлж болдог учраас түүнийг хэрэглэхэд тохиромжтой байдаг.

$$Z = \frac{x_i - \bar{x}}{\sigma}$$

z-стандарт хэмжүүр дэх стандарт оноо

x-тестийн анхдагч оноо

x-стандартчиллын түүвэр дэх дундаж оноо:

σ-стандартчиллын түүвэр дэх стандарт хазайлт.

Z стандарт оноог гаргасны дараа тестийн оноог тестийн стандарт аль ч хэмжүүрт шилжүүлж болно. Тухайлбал, IQ хэмжүүрт шилжүүлэхдээ дараах томъёог ашиглана. Үүнд:

$$IQ = Z15 + 100$$

Тестийн статистик жишиг нормыг тогтоох стандартчиллын түүвэр 200-с цөөнгүй туршигдагчдыг хамрах шаардлагатай хэмээн сэтгэц хэмжил зүйчид үздэг. Анхдагч үнэлгээг Z-хэмжүүрт шилжүүлсэн нэгэн жишээ хүснэгтээр авч үзье. Өөрөөр хэлбэл, тестийн оноог стандарт үзүүлэлт (z) болон T-онооны хэмжүүрийн үнэлгээнд шилжүүлсэн болно.

Анхдагч үнэлгээг Z-хэмжүүрт шилжүүлсэн байдал

Хүснэгт 3

Анхдагч оноог стандарт оноонд шилжүүлсэн нь (z)			z-хэмжүүрийг T-оноонд шилжүүлсэн нь (M=50; $\sigma = 10$)	
Анхдагч оноо (гүйцэтгэсэн даалгаврын тоо, X)	$X - M_x$	$\frac{x - M_x}{\sigma_x}$	Z оноо	T-оноо $10^{\frac{x-T_c}{\sigma_c} + 50}$
32	-9,07	-2,91	-2,91	20,9
33	-8,07	-2,59	-2,59	24,1
34	-7,07	-2,27	-2,27	27,3
35	-6,07	-1,95	-1,95	30,5
36	-5,07	-1,63	-1,65	33,7
37	-4,07	-1,31	-1,31	36,9
38	-3,07	-0,98	-0,98	40,2
39	-2,07	-0,66	-0,66	43,4
40	-1,07	-0,34	-0,34	46,6
41	-0,07	-0,02	-0,02	49,8
42	0,93	0,30	-0,30	53,0
43	1,93	0,62	0,62	56,2
44	2,93	0,94	0,94	59,4
45	3,93	1,26	1,26	62,6
46	4,93	1,58	1,58	65,8
47	5,93	1,90	1,90	69,0
48	6,93	2,22	2,22	72,2

$$M_x = 41,07; \sigma_x = 3,12$$

Хоёр тестийн үнэлгээгээр x_1 ба x_2 хэвийн тархалттай байх тохиолдолд хэвийн муруйн z-үзүүлэлт дараах утгатай байх болно.

$$Z_h = Z_1 + Z_2$$

Эдгээр тэгшитгэлийг ашиглаж аль ч тархалтыг хэвийн өөр тархалт руу, үүний дотор нэгж тархалт руу шилжүүлж болно. Хүснэгт 1-ээс харахад z - ийн хэмжүүр нь хасах \хувь хүн тестийг дунджаас доод түвшинд гүйцэтгэсэн тохиолдолд\ болон нэмэх утгатай байж болно.

Энэхүү хэмжүүрийн сул тал нь хэмжилтийн нэгжийн хэт том масштаб юм ($s=1$). Хялбарчлах зорилгоор энгийн z -ийн шкалыг шилжүүлж, M_1 ба 0_1 -ийн шинэ утгыг сонгож болно. Шинэ z -ийн үзүүлэлтийг дараах томъёогоор тодорхойлж болно. Үүнд:

$$Z_1=0_1\frac{x_1-x}{0}+M_1 \qquad Z_1=0_1z+M_1$$

Ийм шилжилтийн ачаар сэтгэц оношилгооны уламжлалт хэмжүүрийг хооронд нь харьцуулах, нэг хэмжүүрээс M болон 0 -ийн өөр утга бүхий шинэ хэмжүүрт шилжих боломжтой.

2.3 ГАДААДЫН СУДЛААЧДЫН БОЛОВСРУУЛСАН АРГАЧЛАЛЫГ ЗОХИЦУУЛАН ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ

Бие хүний сэтгэл зүйн онцлогийг үнэлэх найдвартай аргуудыг үндсэн 2 арга замаар бий болгодог. Эхний зам нь гадаадын аргачлалуудыг “зээлж”, орчуулж хэрэглэхэд: харин хоёр дахь арга зам нь оношилгоо үнэлгээний орчин үеийн хандлагад нийцсэн, сэтгэл хэмжил зүйн шаардлага хангасан “өөрийн” аргачлалыг боловсруулахад оршино. Сүүлийн жилүүдэд манай орны сэтгэл зүйчид орчуулгын тестийн адаптацийн асуудалд анхаарлаа хандуулж, гадаадын эрдэмтдийн боловсруулсан аргачлалуудыг “нутагшуулах”, орчин үеийн сэтгэл судлалд өргөн хэрэглэгдэж байгаа сорилуудад суурилж аргачлал боловсруулах чиглэлээр эрчимтэй ажиллаж байна.

Гадаадын тестийг “зээлж” хэрэглэх нь түүнийг зөвхөн орчуулах асуудлаар хязгаарлагдахгүй. Тестийн орчуулга төгс, мэргэжлийн өндөр түвшинд хийгдсэн ч энэ нь аргачлалыг нийгэм, соёлын өөр нөхцөлд зохицуулах цаг хугацаа, хөдөлмөр шаардсан цогц ажиллагааны зөвхөн эхлэл юм. Гадаадын судлаачдын боловсруулсан оношилгоо үнэлгээний аргачлалыг хэрэглэхийн тулд нийгэм, соёлын онцлогийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.

Америкийн сэтгэл судлаач Джером Каганы хэлснээр “Векслер эсвэл Бинегийн сорилыг испани, суахили эсвэл хятад хэл рүү орчуулж, латин америк, зүүн африк болон хятадын 10 настай бүх хүүхдийг судлахад ихэнх хүүхдийн оюун ухааны үзүүлэлт дунджаас доогуур гарах болно”. Оюун ухааны үзүүлэлт ингэж доогуур гарах нь судалгаанд хамрагдсан хүүхдүүдтэй бус, харин өөр соёл иргэншилд зориулагдсан сорилтой холбоотой юм.

Адаптаци \лат. Adaptation зохицуулах\ гэдэг нь тестийг хэрэглээний шинэ нөхцөлд зориулан зохицуулах үйл явц буюу тестийг нийгэм соёлын өөр нөхцөлд хэрэглэхэд түүний зохицлыг хангах цогц ажиллагаа юм. Америкийн сэтгэл судлаач Г.Годдард Бинегийн тестийг АНУ-д анх хэрэглэж туршсан юм. Тэрээр Европоос АНУ-д цагаачлан ирсэн хүмүүсийг судалж оношлох багц аргачлалд Бинегийн тестийг оруулжээ. Энэхүү судалгааны үр дүнгээр Еврейчүүд 83%, Унгар иргэдийн 80%, Итали хүмүүсийн 79%, Орос иргэдийн 87% оюуны хомсдолтой гарсан байна. Адаптаци хийгдээгүй сорилын хэрэглээ ямар үр дагавартай байж болохыг энэхүү жишээнээс тод томруун харагдаж байна. Төрөл бүрийн асуулга болон оюун ухааны тестийн бүтцэд орох үгэн дэн сорилуудын хувьд аргачлалыг зохицуулан хэрэглэх асуудал зайлшгүй гарч ирдэг. Соёлын өвөрмөц онцлог, зан заншил уламжлал, ахуй, нийгэм, соёлын ялгаатай холбоотой бэрхшээл судлаачдын өмнө тулгардаг.

Тест зохиогдсон тухайн нийгмийн, соёлын өвөрмөц онцлог, зан заншил, уламжлал, үнэт зүйл зэрэг нь хэл ярианд тусгагдсан байх бөгөөд энэхүү онцлогт тохирч нийцсэн ижил хувилбарыг олоход ихэд төвөгтэй, зарим тохиолдолд боломжгүй ч байж болох талтай. Гадаадын аргачлалыг “нутагшуулах” асуудлаар Оросын сэтгэл судлаачид багагүй туршлага хуримтлуулсан байна. Оросын сэтгэл судлаач Ю.Л.Ханин \1997\ асуулгыг зохицуулан хэрэглэх ажилбарын дараах үе шатыг санал болгожээ. Үүнд:

1. Эх хувилбарын орчуулгын урьдчилсан хувилбар боловсруулах:
2. Хэл шинжээчид болон эх хэлийг эзэмшсэн мэргэжлийн сэтгэл судлаачийг оролцуулан орчуулгын урьдчилсан хувилбарт шинжээчийн үнэлгээ хийх:
3. Туршилтын орчуулга болон тестийн эх хувийн зохиолыг шалгах:
4. Өөрийн орны түүвэр дээр жишиг хэмжээ тогтоох.

Тестийн адаптацийн үе шатыг дараах байдлаар боловсруулжээ.⁹

Үүнд:

- Тест зохиогчын онолын үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх:
- Тест болон түүний зааварчлалыг хэрэглэгчийн хэлрүү хөрвүүлэх:
- Орчуулсан хувилбар эх хувилбарт тохирч байгаа эсэхэд шинжээчийн үнэлгээ хийх

⁹ Бурлачук.Л.Ф Морозов С.М Словарь-справочник по психодиагностике (2002). Питер

- Сэтгэц хэмжил зүйн шаардлагын дагуу тестийн баталгаат болон тохироц чанарыг шалгах
- Зохих түүвэр дээр тестийг стандартчилах.

Гадаадын аргачлалыг нийгэм, соёлын өөр нөхцөлд зохицуулах ажил ихэд чимхлүүр, төвөгтэй, эмпирик статистикийн ажлын цар хүрээгээрээ шинээр аргачлал зохиохоос дутуугуй байдаг ч ихэд ач холбогдолтой юм. Дэлхийн сэтгэц оншилгоо, сэтгэл зүйн үнэлгээний практикт түгэн дэлгэрсэн аргачлалуудын өөрийн хувилбарыг бий болгож бүтээснээр сэтгэц оношилгоо, сэтгэл зүйн үнэлгээний аргачлалуудын практик хэрэглээний олон улсын туршлагаас суралцах, цаашид өөрийн орны уламжлал, нийгэм, соёлын нөхцөлд тохирсон аргачлалууд бүтээх суурь тавигдана.

Гадаадын аргачлалыг нийгэм, соёлын өөрийн нөхцөлд зохицуулах ажлын нэг хэсэг бол аргачлалыг хэрэглэгчийн хэл рүү хөрвүүлэх алхам юм. Аргачлалыг тухайн хэлийг сайн эзэмшсэн мэргэжлийн сэтгэл судлаач орчуулах шаардлагатай гэдгийг ном зохиолд тэмдэглэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд тестийн орчуулга болон орчуулгын нарийвчлалыг хянах олон арга техникийг боловсруулсан байна. Орчуулгын техник болон түүний зохицлыг хянах аргуудыг авч үзье.

1. Орчуулгын техник

- **Орчуулга /тонгоруу орчуулга/-**Хамааралгүй шууд болон тонгоруу орчуулга: тонгоруу орчуулга эхэд нийцэх тохиолдолд орчуулга оновчтой зөв хийгдсэн гэж үзнэ. Орчуулгыг хийж буй судлаач тухайн хэл, соёлын өвөрмөц онцлогийг сайн мэдэхгүй тохиолдол ч энэ арга техникийг хэрэглэх боломжтой. Үг, хэллэг “зохиомол” шинжтэй байх, адаптаци хийх шаардлагатай тестийн хүрээ хумигдаж болох талтай.
- **Децентрац-** Тухайн хэл болон соёлын хувьд өвөрмөц үг хэллэгийг хасна. Соёл хоорондын ялгааг илрүүлэх үр өгөөжтэй арга техник: нийгэм, соёлын онцлогтой холбоотой хэл ярианы өвөрмөц хэлбэрийг хасдагаараа давуу талтай. Даалгавар, асуудлын мөн чанар нь конструктыг дутуу илэрхийлэх эрсдэлтэй.
- **Конвергент хандлага-** Судлаач бүр аргачлалыг өөрийн соёлд тохируулж боловсруулна: аргачлалыг орчуулж, хянаж шалгана. Ялгааны мөн чанарт гүнзгий нэвтрэн орох боломжийг бүрдүүлдэг. Хэрэгжүүлэхэд төвөгтэй.
- **Коммисын хандлага-** Ялгаатай туршлагатай эсвэл өөр өөрсоёлын төлөөлөгчид орчуулгыг хийдэг. Соёл, хэл шинжлэл болон\ эсвэл сэтгэц хэмжил зүйн ялгаатай

туршлагыг нэгтгэх замаар нийцэлд хүрнэ. Хэрэгжүүлэхэд төвөгтэй, орчуулагчийн байр суурь зэрэг сэтгэл зүйн хүчин зүйл ихэд чухал байдаг.\

2. Орчуулга зөв эсэхийг хянах аргууд

- **Хос хэлтэн хүмүүстэй ажиллах-** Хос хэлтэн хүмүүс эх материал болон түүний орчуулгатай ажиллана. Тестийн эх хувилбар болон түүний орчуулга гэсэн 2 хувилбартай ажиллах учраас ялгааг хянахад тохиромжтой. Олон хэлний оролцоо шаардлагатай төсөлд тохиромжгүй бөгөөд хос хэлтэн хүмүүс бол эх олонлогийн санамсаргүй түүвэр биш.
- **Нэг хэлтэн хүмүүстэй ажиллах-** Нэг хэлтэн хүмүүс эх хувилбар болон орчуулгын хувилбартай ажиллана. Хэрэгжүүлэхэд хялбар. Түүвэр нь нас, боловсрол зэргээр ялгаатай байж болно.
- **Тохиолдлын сорил-** Орчуулсан хувилбарыг асуулгын аргаар хэрэглэж туршина, оролцогчид өөрийн хариултыг тайлбарлана. Даалгаврын зохицлыг шалгана, даалгаврыг хэрхэн тайлбарлаж буйг хянана, төслийн тандах үе шатад тохиромжтой. Харьцуулалт хийх мэдээ баримт олж авах боломж бага бөгөөд албан бус хяналт шинжилгээ болдог.
- **Зэрэгцсэн сохор техник-** Бие биеэсээ хамааралгүй хийгдсэн хэд хэдэн орчуулгыг хооронд нь харьцуулдаг. Хэрэгжихэд хялбар. Зарим даалгаврын үл зохицол болон тестийн агуулгын онцлог орхигдох магадлалтай.
- **Шинжээчдийн оролцоо -** Хэл шинжлэл болон эсвэл соёлын салбарын шинжээчдийг оролцуулах замаар соёлын болон хэл шинжлэлийн ялгааны эх сурвалжийг тодорхойлдог. Гадаад тохироц чанар өндөр, соёлын туршлагыг оновчтой ашиглах боломжтой, олон тооны мэдээ баримт цуглуулах шаардлагагүй. Шинжээчдийн үнэлгээний хоорондын найдварт чанарыг тогтоох шаардлагатай бөгөөд шинжээчдийн дүгнэлт нарийвчлал багатай байж болно.

3. Орчуулгын нарийвчлалыг тодорхойлох post hoc процедур

- **Статистийн процеур-** Эквивалент чанарыг тодорхойлох зориулалттай багц зэмсэг хэрэглэх. Тестийн эх хувилбар болон орчуулсан хувилбарын хоорондын бүрэн нийцэл хангагддаг бусад хандлагатай хослуульж хэрэглэх давуу талтай. Статистийн процедурыг хэрэгжүүлэхэд түүврийн хэмжээ их байх шаардлагатай, статистийн процедурыг бусад аргуудтай хослуулах шаардлагатай (ж., хос хэлтэн хүмүүстэй ажиллах)

2.4 ГАДААДЫН ОРЧУУЛГЫН СОРИЛУУДЫГ ЗОХИЦУУЛАН ХЭРЭГЛЭСЭН СУДЛААЧДЫН АРГА ТУРШЛАГААС

Манай орны эрдэмтэн, судлаач, доктор, профессор О.Мягмар (1988), П.Цэрэндондов (2004, 2005), Д.Эрдэнэчулуун (2005, 2006), Д.Санжжав, Б.Бор (1991), Л.Уранцэцэг, Ч.Түмэндэлгэр (1990), Ж.Батдэлгэр (1994), Д.Ванчигсүрэн (1995), Г. Сарантуяа (2001, 2005) нар ихээхэн хувь нэмэр оруулжээ.

Судлаач З. Мөнхдалай (1992, 1996) оюун ухааны зарим тестүүдийн агуулга аргачлал болон хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх сургах зүйн асуудал талаас нь авч үзсэн байна. Английн сэтгэл зүйч Г.Айзенкийн боловсруулсан тестийг “Өөрсдийнхөө авхаалжийг шалгацгаая”(1995) нэртэйгээр Д.Монхор, Ц.Дорж, Л.Норжий нар найруулан орчуулж хэрэглээнд оруулсан байна.

Доктор, профессор сэтгэлзүйч Б. Туяа “Тестийг зохицуулан хэрэглэх туршилт судалгаа” сэдэвт бүтээлдээ оюун ухааны бүтцийг оношлох Р. Амтхауэрийн (насанд хүрэгчдийн хувилбар) сорилыг монгол түүвэр дээр зохицуулан хэрэглэж туршжээ.¹⁰ Тус бүтээлд Амтхауэрын сорилын баталгаат болон тохироц чанарыг шалгасан ба ЕБС-ийн 9 болон 10 дугаар ангийн 80 сурагч болон их дээд сургуулийн 1 болон 2 дугаар төвшний ангий 231 оюутнуудын бүлэг дээр стандартчилсан байна. Судалгааны ажлын хүрээнд сорилын баталгаат чанарыг ре-тест арга ашиглан, баталгаат чанарын коэффициентийг Спирменин томъёогоор шалгасан $r = .66$, харин тохиороц чанарыг шалгуур үзүүлэлтийн тохироц чанарын коэффициентийг олж шалгасан байна.

Судлаач Н.И.Александровна, О.Туяа, З.Батжаргал, Ж.Отгонгэрэл нар “Соёлын дасан зохицлыг илрүүлэх асуулгын орчуулга болон сэтгэц хэмжил зүйн судалгаа-ОХУ-д суралцаж буй монгол оюутнуудын жишээн дээр” сэдэвт судалгааны ажлын хүрээнд “нийгэм соёлын шинэ нөхцөлд бие хүний дасан зохицлын асуулга” (Опросника адаптаций личности к новой социокультурной среде)-ыг стандартчилсан байна.¹¹ Тус судалгааны хүрээнд ОХУ-Д

¹⁰ Туяа.Б (2006) “Тестийг зохицуулан хэрэглэх туршилт судалгаа ”Оюун ухааны бүтцийг оношлох Р.Амтхауэрийн жишээн дээр” сэтгэл судлалын ухааны философийн докторын зэрэг горилсон бүтээл Улаанбаатар

¹¹ Н.И.Александровна, Туяа.О, Батжаргал.З, Отгонгэрэл.Ж нар (2017) “Соёлын дасан зохицлыг илрүүлэх асуулгын орчуулга болон сэтгэц хэмжил зүйн судалгаа-ОХУ-д суралцаж буй монгол оюутнуудын жишээн дээр” сэдэвт судалгааны ажлын хүрээнд “нийгэм соёлын шинэ нөхцөлд бие хүний дасан зохицлын асуулга” ОХУ

суралцаж буй 222 Монгол оюутныг хамруулан баталгаат чанар болон тохироц чанарыг (хүчин зүйлсийн хамаарлыг тодруулан) тогтоож, асуулгыг стандартчилжээ.

Судлаач Б.Энхтүшиг “ТАТ-ын аргын зарим картанд модификаци хийсэн нь” сэдэвт бүтээлээр МУИС-ийн НШУС-ийн СССХУ-ы тэнхимийн бакалаврын зэрэг горилсон¹². (2013) Тус судалгааны ажил нийт 40 оролцогчийг хамруулан, ТАТ-ын аргын хоёр картын зургийн нүүр дүр төрхөд Монгол хүний нийтлэг царай төрхийг оруулан хувиргаж, өөрчилсөн зураг болон эх зураг хоорондын үр дүнгийн ялгаа бий эсэхийг судалж модификаци хийх шаардлагыг тодруулсан. Судалгааны дүнд соёлын ялгаа байгааг илрүүлсэн бөгөөд ТАТ-ын аргыг модификаци хийх шаардлагатай байгааг илрүүлжээ.

1. Оюун ухаан бол сэтгэхүйн цэвэр чанарууд, амьдралаас тасархай зүйл биш. Энэ нь хүний идэвхитэй үйл ажиллагаа, амьдрах арга ухаантай холбоотой ерөнхий чадвар юм. Иймээс оюун ухааны хөгжлийн түвшинг оюуны үйлийн агуулга, арга барил, эцсийн үр дүн талаас нь судлах боломжтой.
2. Хүүхдийг амьдрал үйл ажиллагаанд бэлтгэн төлөвшүүлэх зорилт бүхий өнөөгийн сургалтын агуулга нь хүүхдийн оюун ухааны хөгжлийн гол бүрэлдэхүүн хэсгийн (ерөнхий мэдлэг чадвар, хэл яриа, сэтгэхүй, ой, анхаарал, орон зайн төсөөлөл гэх мэт) хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлж чадаж байвал сая хүүхдийг хөгжүүлэх үүргээ гүйцэтгэж байна гэж хэлэх үндэстэй.
3. Оюун ухааны хөгжлийн ерөнхий түвшинг иж бүрэн байдлаар тодорхойлохын тулд оюуны гол гол үйлдлүүдийн (эргэцүүлэн тунгаан бодох, сэтгэмж, сэтгэхүйн хурд, зохион бодохуй, ойд материал хадгалагдах хурд, хугацаа, ухагдахуун төлөвших, шууд мэдрэн таних үйлийн онцлог, анхаарал, орон зайн баримжаалал гэх мэт) хөгжлийн түвшинг тус тусад нь болон ерөнхийд нь иж бүрэн байдлаар дүгнэж болохуйц агуулгын хувьд өргөн хүрээтэй сорил боловсруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Дээрх эрдэмтэд эдгээр үндэслэлийг мөрдлөг болгож, К.М. Гуревич нарын “Психологическая диагностика” (1981), В.А. Худик “Психологическая диагностика детского развития : методы

¹² Энхтүшиг.Б (2013) “ТАТ-ын аргын зарим картанд модификаци хийсэн нь” сэдэвт бүтээлээр МУИС-ийн НШУС-ийн СССХУ-ы тэнхимийн бакалаврын зэрэг горилсон. Улаанбаатар

исследования” (1992), Д.Векслерийн оюун ухааны шатлал бүхий “WISC” (1940) “WISC-R” (1974), Г.Айзенкийн “Өөрсдийнхөө авхаалжийг шалгацгаая” (1995) бүтээлийн үзэл санаа хувилбарын агуулгыг үндэслэн асуулт даалгаврын тогтолцоог боловсруулах замаар энэхүү тестийн хувилбарыг зохиожээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗОХИЦУУЛАН НУТАГШУУЛСАН ТЕСТҮҮД

3.1 “АМЬДРАЛЫН ЗАМ” ТЕСТ Энэхүү тестээр судалгааг зохион байгуулахдаа удлуулагчдад дараах зааврыг өгнө.



“Амьдрал нэртэй аялагч замаар явж байлаа. Энэ зам аялагчийг уулзвар дээр авчирна. Аялагч зогтусан уулзварыг ажиглана. Тэр хэсэг бодлогоширно. Аль замаар цааш явах вэ? Энэ аялагчийн оронд та өөрийгөө тавиад төсөөлөөрэй.

- ✓ Та юу бодож байна вэ?, Та юу мэдэрч байна вэ?, Таны өмнө цэвэр цаас байна. Та харандаа аваад өөрийнхөө өнгөрсөн түүхийг зурна уу. Мөн та одоо байгаа өөрийнхөө боломж болон ирээдүйн амьдралаа дүрсэлнэ үү. Үүнд: Та өөрийнхөө дурсамж, туршлага, мөрөөдөл, зөгнөлийг ашиглаж болно.

- ✓ Та хаашаа явахыг хүсч байна вэ?, Та замдаа юу авч явах вэ?, Замд нь хэн тааралдаж болох вэ?, Та юу сурах вэ?”

Аргыг хөтлөн явуулах нөхцөл Аргын үр дүн (а) гадаад: үйлчлүүлэгчийн биеийн байдал, зурсан байдал, цаас ашиглалт, бичиглэл (б) дотоод: арга зүйд хандаж байгаа байдал, харилцаа зэрэг нөхцлөөс хамаарна.

Тиймд та бүхэн стандарт нөхцлийг баримтлах хэрэгтэй. Үүнд:

- ✓ Сорил хийхийн өмнө үйлчлүүлэгчтэйгээ танилцах хэрэгтэй, түүнийг тайвшрахад нь тусална.

- ✓ Сорилын зааврыг уншиж өгнө.
- ✓ Сорилыг гүйцэтгэх уран сайхан болон зурах чадвар шаардахгүй гэдгийг хэлнэ.
- ✓ Үйлчлүүлэгч ширээний ард суух эсвэл хатуу зургийн тавцан дээр зурах ёстой.
- ✓ А4 буюу 210x297 хэмжээтэй цэвэр цаасан дээр зурах шаардлагатай
- ✓ Энгийн харандаа эсвэл тосон балаар зуруулах
- ✓ Зургийг баллуураар баллах, арилгахыг зөвшөөрөхгүй
- ✓ Даалгаврыг гүйцэтгэх хугацаа битгий тавь. Үйлчлүүлэгчээ битгий яаруул
- ✓ Аргыг гүйцэтгэх явцад үйлчлүүлэгчийн зан байдлын үзүүлэлтүүдийг тэмдэглэх Хэрвээ энэ аргыг ганцаарчилсан хэлбэрээр явуулж байгаа тохиолдолд зураг зурах явцад үйлчлүүлэгчийн үйл хөдлөл бүрийг оношилгооны нэмэлт мэдээлэл болгон нэг бүрчлэн тэмдэглэж авах хэрэгтэй.
- ✓ Далд үе /зөвлөмж танилцуулснаас хойш зурж эхлэх хүртэл хугацаа/
- ✓ Даалгаврыг гүйцэтгэсэн хугацаа
- ✓ Зогсолт /зурах явцад минутаас илүү завсарласан хугацаа/
- ✓ Зурж дууссан дүрслэл рүү эргэж буцах
- ✓ Өнгөрснөөс одоо, одоогоос ирээдүй рүү зурах дараалал алдагдах
- ✓ Үйлчлүүлэгчийн санамсаргүй үг хэллэг: – Асуулт, тодруулга, өөрийгөө өмгөөлөх үг – Тусламж эрэх, өөрийгөө үнэлэх, шүүмжилсэн үг – Даалгаврыг шүүмжлэх, уучлал гуйх, гадаад нөхцлийг шүүмжлэх
- ✓ Даалгаврыг гүйцэтгэхээс татгалзах
- ✓ Гарын хөдөлгөөн
- ✓ Үйлчлүүлэгчийн биеийн байдал – Биеэ хөдөлгөх, – Биеэ эргүүлэх, – Гар, бие хоёр хоорондын зай, Зургаа гараараа халхлах
- ✓ Үйлчлүүлэгчийн зах мэдрэлийн системийн өөрчлөлт: хөлс гарах, нүүр улайх, арьс цайрах, Гар салганах, чичрэх, – Гараа сэгсрэх, хөлөө займчуулах, толгой, хүзүүгээ шилгээх зэргээр хөдөлгөх, – Уруулаа хазах, долоох, харандаагаа мэрэх

Үр дүнгүүдийг хэлэлцэх ерөнхий зарчмууд “Амьдралын зам” зурган арга зүйн үр дүнг хэлэлцэх үндэс нь зохиогч болон дүрслэгдсэн дүрүүдийг хооронд нь адилтгах зарчим юм. Өөрөөр хэлбэл, амьдралын замын дүрслэл нь үйлчлүүлэгчийн бодит амьдралын замын загвар зураг болно. Метафор гэдэг нэр томъёо нь *metaphora* гэсэн грек үгнээс гаралтай шилжүүлэх гэсэн утгатай. Метафор нь нэг үзэгдлийг нөгөөтэй адилтган жиших харьцуулалт юм. Нэг талаас зурган дээрх элементүүд нөгөө талаас үйлчлүүлэгчийн амьдралын үйл явдал,

байгууламж, үйлдэл, хүмүүс хоорондын зарим зохицол байж болно. Хэрвээ үйлчлүүлэгчийн зургийн жижиг хэсгүүдийн харьцааг ил гаргаж чадвал бодит амьдралд дахь ижил зан төлвийг үзэгдэл, эд юмстай харьцах түүний харилцааг авч үзэж болно. Арга зүйн үр дүнг хэлэлцэх үндсэн стратеги нь зохиолын баатрын зорилго, асуудал, нөхцөл боломжоор дамжин үйлчлүүлэгчийн зорилго, асуудал, боломжийг магадлах явдал юм.

Ийм байдлаар дараах гол гурван зорилтоор үйлчлүүлэгчид тусална.

1. Үйлчлүүлэгчийн хувийн зорилгод тулгуурлан түүний амьдралд илүү чухал байгаа, тэр юу руу тэмүүлж байгааг магадлах
2. Үйлчлүүлэгчийн асуудлын агуулгаар тавьсан зорилгодоо хүрэхэд нь юу саад болж байгааг магадлах
3. Үйлчлүүлэгчийн нөөц боломжоор асуудлыг шийдвэрлэх арга, хувилбаруудыг олох,

амжилтад хүрэхэд нь тусалж чадахыг магадлах Энэ гурван зорилгод холбоогүй зүйл нь гол зорилгоос өөр тийш нь хазайлгаж, зөвлөгөөний үр дүнг бууруулах тул хэлэлцүүлгийн явцад “Би ямар даалгаврыг шийдвэрлэж байна вэ?” гэсэн асуултыг өөртөө тавьж байх хэрэгтэй. Арга зүйн гол тактик бол зурсан зураг ба үйлчлүүлэгчийн бодит байдал, зан байдлыг тууштай, дэс дараатай авч хэлэлцэх явдал. Ямар ч тохиолдолд үйлчлүүлэгчтэй зургийн онцлогийг эхлэн хэлэлцээд дараа нь зургийн аль нэг үзүүлэлтийг ашиглан үйлчлүүлэгчийн бодит харилцааны хэлэлцүүлэг рүү шилжүүлэх хэрэгтэй. Зарим тохиолдолд үйлчлүүлэгч зургийн тухай бус, үнэн хэрэгтээ өөрийнхөө юу хүсч, мэдэрч байгаа тухай 13 ярьж байгаагаа анзаардаггүй. Үүний үр дүнд үйлчлүүлэгч түүнд сөргөөр нөлөөлөх нөхцөл, болзошгүй байдлаасаа гарч, хэлэлцүүлэг хийхэд хялбар болдог. Ярилцлагын эхэнд зургийн зүйрлэлийг ашиглан “үйлчлүүлэгчийг эсэргүүцэж түгшээхгүй, нэг их аюултай санагдахгүй байх” мэдрэмжийг бий болгох нь чухал. Энэ арга зүйн туршилтаас харахад, үйлчлүүлэгчийн сонирхолыг нэмж, баяр баясгалантай болгож, түүний жинхэнэ харилцаа, сэтгэл хөдлөлийг илэн далангүй хэлэлцэхэд бэлтгэгддэг. Ийм байдлаар үйлчлүүлэгч өөрийнхөө тулгамдсан асуудал, түүнийг шийдэх аргыг цоо шинээр харж, бүтээлчээр сэтгэн, үүнээсээ дахин сэтгэлийн ханамжийг олж авдаг.

Хэлэлцүүлэг нь хэлбэрийн болон агуулгын үзүүлэлтүүдийн алинийг нь ашиглахаас хамаардаг. Гэхдээ хэлэлцүүлэг нь метафорын дутууг гүйцээх ерөнхий асуултаас эхэлнэ. Энэ үед үйлчлүүлэгч дутуу байгаа хэсгийг гүйцээхэд идэвхтэй оролцдог. Үйлчлүүлэгчид тус болох зорилгоор дараах асуултуудыг тавьж болно.

– Энэ зурганд та ямар нэр бодож олох вэ?

– Энэ нэр юуг илэрхийлж байна вэ? Ямар мэдрэмж төрүүлж байна вэ?

– Энэ зургийг харахад өөр хэн нэгэн юу харж, ойлгож болох вэ? Энэ зураг тэр хүнд ямар санаа, мэдрэмж төрүүлэх вэ?

– Аялагчийн өнгөрсөн зам, одоо ба ирээдүйгээс юугаараа ялгаатай вэ? Ямар нийтлэг зүйл байна вэ?

– Аялагч өөрийнхөө амьдралын замын аль үед илүү аз жаргалтай, баяр баясгалантай байна вэ? Яагаад тэр вэ? Ямар нөхцөл байдлын ачаар вэ? Үүнд юу дөхөм болсон вэ?

– Энэ замын зорилго юу вэ? Аялагч юунд тэмүүлнэ вэ? Тэр юунд хүрэхийг хүсч байна вэ? Түүний зорилго биелэснийг тэр яаж мэдэх вэ?

– Аялагчид юу саад болж болох вэ? Замд нь ямар саад бэрхшээл тулгарч болох вэ?

– Тавьсан зорилгодоо хүрэхийн тулд юу зайлшгүй хэрэгтэй вэ? Ямар нөхцөл, боломж, хөрөнгө байна вэ?

– Замын чиглэл, түүний төлөвлөгөө ямар вэ? Та баримжаалах зүйл, үе шат, шилжилт, зогсоолуудыг нэрлэнэ үү?

– Одоо аялагчид юу илүү хэрэгтэй байна вэ? /газрын зураг, замын хань, багаж хэрэгсэл, хоол унд, хувцас, эмийн сан гэх мэт/ Асуултын дараалал, бүтэц, тоо хэмжээ зэрэгт стандарт байхгүй. Харин үйлчлүүлэгчийн байдал, туршлага, дадал, асуудал, зургийн онцлог зэргээс 14 хамаарч сэтгэл зүйч асуултуудыг тодорхойлно. Дутууг гүйцээх явц нь сэтгэл зүйч зургийн ерөнхий санаа, ойлгомжгүй байгаа хэсгүүдийн учрыг олсон, үйлчлүүлэгч дүрдээ бүрэн орсноор дуусна. Мөн энэ шатанд үйлчлүүлэгчийн ойн ухаандаа өөрийн зан үйлийн зарим онцлогууд, харилцаа, зовнилоо ойлгож эхэлнэ. Цаашдаа ойлголтуудыг гүнзгийрүүлэх зорилгоор тодорхой, салангид үр дүнг хэлэлцэж болно. Хэлэлцүүлэг тодорхой мөчлөгөөр явагдаж болно. Сэтгэл зүйч хэлбэрийн болон агуулгын үзүүлэлт, зургийн онцлог, жижиг хэсгүүд, шинж тэмдэг зэргээр дамжуулан үйлчлүүлэгчдэдээ анхаарал хандуулна. Хэлэлцүүлгийн тодорхой хувилбаруудыг 3-5 дугаар хүснэгтийн “Боломжийн анхааруулга ба асуултууд” гэсэн баганад байршуулсан байгаа. Хэрвээ хэлбэрийн үзүүлэлт бол

1. Энэ үзүүлэлтийн шалтгааны тухай асуулт тавина: “Энэ үзүүлэлт юунаас үүссэн бэ?”, “Үйлчлүүлэгчид юу саад болж байна вэ?”, “Хэрвээ үйлчлүүлэгч өөрөөр хөдөлсөн бол юу тохиолдох байсан бэ?”

2. Зураг зурах явцад бий болсон үйлчлүүлэгчийн мэдрэмжийг хэлэлцэхэд: “Хэзээ, хаана, ямар нөхцөлд үйлчлүүлэгч ийм мэдрэмж мэдэрч байсан бэ?”, “Энэ юунд хүргэж байна?”. Энэ мэдрэмжийг бий болгож байгаа нөхцөл байдал, үйлчлүүлэгчийн мэдрэмж,

зовнил нь түүний асуудлын эх үүсвэр, мөн бусад асуудлыг шийдвэрлэхэд туслах нөөц, боломж байгааг ойлгож эхэлнэ.

Зөвлөгөө -1 Э, 27 настай. Дээд сургуульд англи хэлний багш, нөхөргүй. /атлас зураг 33/ Ажил нь сэтгэлд нийцэхгүй байгаа тухай зөвлөгөө авахаар ирсэн. “Юу хүсч байгаагаа өөрөө ч мэдэхгүй байна. Ажил маань цухалдуулж байна” Эрдмийн ажлаа дуусгаж чадахгүй байна. Урьд нь мэргэжлийн төвд ирж 3 цаг сорил өгч, зөвлөгөө авч байсан. Дараа 10 минут болоод “Амьдралын зам” аргын гүйцэтгэж эхэлсэн. 9 минут ажилласан. Зурах явцдаа өөрөө бие даан зургаа тайлбарлаж эхэлсэн. – Ямар нэг зүйл ярих эсвэл бичих үү? Аль нь дээр вэ? – Танд аль нь дээр байна? – Энэ аялагч ... Цүнхээ авах хэрэгтэй. Тэгээд явна ... Харин хаашаа явж байгаагаа ойлгох хэрэгтэй ... Яаж дүрслэхээ мэдэхгүй байна ... Саарал чоно эсвэл аймшигтай шувуу юу ... эргэн тойрон байгаль, нэлэнхийдээ цэцэг ... Энэ дов сондуулаар явахад хэцүү байна ... Ном авдаг ч юм бил үү? ... Хүмүүсийг зурахыг хүсэхгүй байна. Босоод харлаа. Өнгөрсөн зам тоостой, элстэй юм. Ирээдүйн зам янз бүр. Баруун талын захын зам өнгөрсөн замтай ижилхэн юм. Баруунаасаа хоёр дахь зам ... , дунд талын гурав дахь зам онхол тонхолтой юм. Аялагч яагаад ч явж чадахгүй байна. Ойгоор явдаг юм бил үү? Энэ аймшигтай биш ч удаан залхуутай байна. Хурдан явахыг хүсч байна. Цаас хүрдэггүй. Сондуулаар арай удаан явж байна. Шулуун зам надад таалагдаж байна. (бүдүүн сум зам дээгүүр зурав) – Баярлалаа. Тэгвэл аялагч өөрийнхөө замыг сонгоод зорилгодоо хүрсэн гэж төсөөлье. Тэгвэл тэр зорилгодоо хүрснээ яаж мэдэх – Өөрийнхөө дурсамж, сэтгэгдлээр байж магадгүй. – Яг юуг дурсан санасан бол?


- Түүний толгойд найз нартайгаа ярилцах, аялал зугаалгаар явах тухай орж ирсэн байх.
- Аялагч амьдралынхаа замын ямар үед арай илүү аз жаргалтай байсныг та хэлж чадах уу?
- Хэлэхэд хэцүү. Аз жаргалын үе шат аль нэг цаг хугацаанд сунжирсан байх.
- Харин аялагч ямар нөхцөлд аз жаргалыг мэдэрсэн вэ? Энэ юутай холбоотой вэ?
- Энэ яг ажил албатай нь холбоотой байх.
- Түүний хувьд материаллаг амжилт, чинээлэг амьдрал чухал байсан гэж үү?
- Тэгэлгүй яахав. – Харин таны хувьд?
- Надад ч гэсэн адил.
- Ойлгомжтой. Аялагчид амьдралын ямар үед илүү хүнд, хэцүү байсан бол?
- Дөнгөж ажил хийж эхлэх үед. – Та аялагчийн ажлын эхлэл хаана байгааг зурагт дүрслэж чадахгүй биз? – Яг энд. (төв зам дээрх уулзвараас дээш 2 см-т толбо зурав) – Үнэндээ аялагч ажлаа арай эхлээгүй байгаа юм уу?
- Тийм ээ, тэр хараахан ажлаа эхлээгүй байна.
- Харин та? – Өө, адилхан юм шиг байна.
- Одоо таны их сургууль дээр хийж байгаа ажил таны хувьд жинхэнэ ажил чинь биш гэсэн үг үү?
- Тийм ээ. Би их сургуулиасаа гарах гэж байгаа.

- Та энэ хэсэгт хүчтэй дарж зурлаа. Яагаад тэр вэ? Энэ толбоны дор та юу нуухыг хүссэн бэ?
- Миний хувьд үүнийг хийж эхлэх үнэхээр аймаар байна.
- Та яг юунаас айгаад байна?
- Та ойлгож байна уу? Хэрвээ би үүнийг хийвэл гэр бүлээ алдана гэхээс их айж байна. – Энэ танаас арай их цаг хугацаа, хүч шаардана, бас гэр бүлийн харилцаагаа авч явахад саад болно гэдгээс та айж байна уу?
- Тийм ээ.
- Аялагч зорилгодоо хүрэхэд өөр юу саад болж байна вэ?
- Зам дээрх саадууд. Түүнийг давах гэсээр байтал эрүүл мэнд, хүсэл нь хангалтай хүрэлцэхгүй байж болно.
- Таны санхүүгийн амжилтанд хүрэх хамгийн гол саад гэр бүл, эрүүл мэндээ алдах уу?
- Тийм байх аа.
- Аялагч зорилгодоо хүрэхэд нь юу туслах бол?
- Хүчтэй хөл (хөлийг тойруулан зурсан), эрүүл мэнд.
- Та эрүүл мэндэдээ ямар үнэлгээ өгөх вэ?
- Бэрхшээлийг давахад хангалттай гэж бодож байна. Харин түүнийг ухаантай зарцуулах хэрэгтэй.
- Сайн байна. Танд замд өөр юу тус болж болох вэ?
- Мэдэхгүй байна.
- Екатерина, та “Амьдралын зам” зургийн даалгаврын нэлээд хурдан гүйцэтгэж эхэлсэн. Энэ нь та шийдвэрийг голдуу хурдан гаргадаг гэсэн үг үү?
- Тийм ээ, хурдан, бас амархан гаргадаг. Жишээ нь би сургуулиас гарахаар шийдчихсэн.
- Гэсэн ч цаашид шийд гаргахад юу саад болсон бэ?
- Надад яагаад гэдгийг ойлгоход хэцүү байна.
- Сайн байна. Та ямар нэгэн юм хийж эхлэхээсээ өмнө маш хурдан бодож байсан тохиолдлыг санаж байна уу?
- Тийм ээ, би хоёр тохиолдлыг санаж байна. Тэдгээрийн нэг нь намайг сурч байхад болсон. Миний нэг танил намайг олон жил ажилласан байхаар “хуурамч” хөдөлмөрийн дэвтэр бөглөхийг санал болгосон. Би татгалзсан хариу өгөхөөсөө өмнө удаан бодсон. Нөгөө нэг тохиолдол нь миний найзтай холбоотой. Тэр жаахан шизоидный хэв шинжтэй. Бид аялаж цагийг хамтдаа өнгөрөөдөг байсан. Түүнд их сонирхолтой байсан. Дараа нь тэр надад

- “хэцүү” болсон. Түүнд өөр найз байдаггүй байсан. Би бүх зүйл дээр түүнтэй хамт байх хүч хүрэхээ больсон. Түүнээс харилцаагаа таслах гэж би их удаан зовсон.
- Тэр тохиолдолд чамд шийдвэр хурдан гаргахад юу саад болсон вэ?
 - Нэгдүгээр тохиолдолд хүчтэй уруу татагдахаар байсан. Харин би тэгэхийг хүсээгүй. Харин хоёрдугаар тохиолдолд би найздаа их дассан байсан.
 - Тэгэхээр танд нэг бол өөрийгөө эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байх эрмэлзэл, нөгөө нь хуучин харилцаагаа хадгалах эрмэлзэл шийдвэр гаргахад саад болсон. Харин одоогийн тохиолдол ямар байна? Таны албан тушаал ахих сонголтонд яг юу саад болж вэ?
 - Магадгүй, дасаагүй байх. Би өөрийнхөө зуршлыг амархан өөрчилж чадна. Удахгүй намайг занах болов уу гэж айж байна.
 - Айдас бидэнд тус болно гэж бодъё?
 - Яаж тусална гэж? Айдас ихэнхдээ саад болдог шүү дээ?
 - Аялагч айдастай байна. Энэ айдас юунд ашигтай, юунаас хамгаална гэж? Хэрвээ аялагч айгаагүй бол юу болох байсан?
 - Айдас хурдыг тааруулна ...
 - Айдас өөрийгөө авч үлдэхэд ... –
 - Тэгвэл бид өөрсдийнхөө айдасаар бахархах хэрэгтэй.
 - Яг тийм. – Сайн байна, Катя. Тэгэхээр бид , айдас бол бидний нэг туслагч юм гэдгийг зөвшөөрлөө. За одоо би таныг зураг руу анхаарлаа хандуулахыг хүсч байна. Таны зураг хүрэнээс гарчихлаа. Та өөр ямар тохиолдолд нийтийн зан үйлийн хүрэнээс гадуур байж чадах вэ?
 - Одоо би гэрийн ажил хийж чадахгүй. Мөн бусдад үйлчлэхийг үзэж чадахгүй.
 - Та эмэгтэй хүн гэрийн ажил хийх ёстой гэсэн санал нийлэхгүй юм уу? Та заавал гэрийн ажил хийх шаардлагатай байвал юу болох вэ?
 - Би үүнийг төсөөлж чадахгүй, ёстой уйтгартай.
 - Ийм байдлаар, гэрийн ажилдаа түүртэн өөрийн тэмүүлэл, чадвараа ашиглаж чадахгүй байх юм. Та үүнээс гарахыг хичээж байна уу?
 - Заавал – Би тантай зам дээрх бүдүүн сумуудын тухай авч хэлэлцье. Миний ойлгосноор эд аялагчид зам зааж байна уу? Үүнийг хэн зааж байна вэ?
 - Сумууд бол нийгмийн заалт.
 - Та үүнийг дэлгэрэнгүй ярьж чадах уу? Сум бүр ямар учиртай заалтыг илэрхийлж байна вэ?

– Нэгдүгээр сум /баруун талаас 1-р гэж бичсэн байна/ бол энэ сум сэхээтнүүдийнх. Миний эцэг эхтэй адилхан багш, сэхээтэн. Энэ сумны давуу тал бол тайван, аюулгүй, гэхдээ сонирхолгүй. Хоёрдугаар сум /баруун талаас 2-р гэж бичсэн байна/ бол эрх мэдэл, амжилттай яваа болон баян хүмүүсийнх. Энэ шинэ зам, урьд нь ийм зам байгаагүй. Энэ зам эрсдэлтэй, гэр бүл бий болгоход саад болно. Гэхдээ энэ зам жинхэнэ аз жаргал авчрах байх. Энэ жинхэнэ ёсоор юунаас ч хамааралгүй, хүн байхад хүргэж өгнө. Энд л өөрийхөө бүх боломжуудыг хэрэгжүүлж чадна.

2. “МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛАХ СТРЕСС ОНОШЛОХ БА ЗАЛРУУЛАХ ЦОГЦ АРГА ЗҮЙ “ИДИКС”



Энэ аргачлал нь ажлын үе дэх стрессийг судлах зориулалттай ба янз бүрийн төлөвлөгөө бүхий олон тооны бүтэцтэй ажлууд дээр суурилсан алдартай загваруудыг нэгтгэсэн. Мөн эмпирикт үндэслэсэн үзэл баримтлалуудад дүн шинжилгээ хийж өөрийн парадигмаа боловсруулан гаргасан.

Экологийн үзэл баримтлал “Бие хүн–орчин” тогтолцоонд үндэслэдэг. Байгаль хүн хоёрын хоорондын тэнцвэрт харилцаа алдагдсанаас өргөн хүрээтэй сөрөг нөлөөллүүд үүсч (биеийн, хөдөлмөрийн, нийгмийн), ажиллагчдын бие махбодын эрүүл мэндэд өөрчлөлт орж, улмаар

хөдөлмөрийн үр ашиг буурдаг.

Танин мэдэхүйн үйл явцын талаарх үзэл баримтлал Р.Лазарусын стрессийн сэтгэл зүйн загвар дээр үндэслэдэг. Энэ нь харилцан үйлчлэлийн хандлагын хэлбэр. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд бэрхшээлийг даван туулах дотоод нөөц ба субъектив үнэлгээний үйл явц нэн чухал гэж үздэг.

Зан байдлыг зохицуулах үзэл баримтлал Стресст дүн шинжилгээ хийхийг анхаардаг. Стресстэй гэнэт тулгарсан болон удаан хугацаагаар өртсөн үед хүний үйл ажиллагааг

зохицуулж байгаа зан байдлын механизмд илэрч байгаа өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийж ангилах нь чухал гэж үзнэ.

Идикс нь 3 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Оношилгоо Хувь хүн болон бүлгийг хамарсан судалгаанд ажлаас үүдэлтэй стрессийн шинж тэмдгийг үнэлэхдээ олон хүчин зүйлт үнэлгээг ашиглана.
- Үнэлгээ Ажлын байрны стрессийн ерөнхий түвшинг стандартчилагдсан психометрийн асуулга болон үнэлгээний алгоритмын үндсэн дээр тодорхойлон чанарын дүн шинжилгээг гаргадаг.
- Урьдчилан сэргийлэлт Ажлын байран дахь стрессийн хам шинжийг илрүүлэхэд тохирсон оновчтой арга хэмжээг сонгож, хөтөлбөрийг бүрдүүлнэ.

ИДИКС систем нь бүтцийн хувьд асуулгын төрөлд багтах ба 6 үндсэн хэмжүүртэй. Тэдгээр нь дотроо 4-6 дэд хэмжүүртэй.

Асуулгын бүтэц нь стрессийн шинжилгээний шаталсан бүдүүвчийн хэлбэртэй ба судалгааг үүний дагуу авна.

Оношилгоо хийхдээ ажлын стрессийн алдартай загварууд дээр тулгуурлан зохиосон психометрийн аргачлалыг гүйцэтгүүлж улмаар факторт анализын үндсэн дээр үр дүнг боловсруулан гаргана.

ИДИКС систем нь бүтцийн хувьд асуулгын төрөлд багтах ба 6 үндсэн хэмжүүртэй. Тэдгээр нь дотроо 4-6 дэд хэмжүүртэй. Асуулгын бүтэц нь стрессийн шинжилгээний шаталсан бүдүүвчийн хэлбэртэй ба судалгааг үүний дагуу авна. Оношилгоо хийхдээ ажлын стрессийн алдартай загварууд дээр тулгуурлан зохиосон психометрийн аргачлалыг гүйцэтгүүлж улмаар факторт анализын үндсэн дээр үр дүнг боловсруулан гаргана.

Аргачлалыг дараах хэмжүүрүүд бүрдүүлнэ.

- ✓ Хэмжүүр V1. Стресс бүрэлдэх болсон шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн талаарх объектив шинж чанарыг тодорхойлох: Ингэхдээ ажлын орчин, ачаалал, ажлын эрчим, хөдөлмөрийн агуулга, зохион байгуулалт зэрэг тодорхой нөхцөл байдлыг уламжлалт профессиографийн загварт тулгуурлан гаргана.
- ✓ Хэмжүүр V2. Хөдөлмөрийн зорилтуудыг үнэлэх субъектив үнэлгээний онцлогийг тодорхойлох: Мэргэжлийн нөхцөл байдалд хэрэглэж байгаа арга маяг тохирч байгааг эсэхийг авч үзнэ.

- ✓ Хэмжүүр V3. Шагнал урамшуулал/ хамт олны уур амьсгал: Хөдөлмөрийг зохистой үнэлж байгаа байдал хөдөлмөрлөсний төлөөх шагнал, хамт олон болон удирдлагатайгаа харьцах харьцаа, ажил хөдөлмөрт хандах хандлагын сэдэл, үнэлгээ, цалин хөлсөнд сэтгэл ханамжтай байгаа байдал, байгууллагын орчин дахь хүмүүс хоорондын харилцан үйлчлэл, гүйцэтгэлийн хяналт, үр дүнтэй холбоо харилцааг үнэлнэ.
- ✓ Хэмжүүр V4. Стрессийн хурц хэлбэр: тухайн цаг үеийн байдал, бие физиологи тав тухгүй байх, танин мэдэхүйн ба сэтгэл хөдлөлийн үйл ажиллагаа, өөрийгөө мэдрэх болон сэтгэл санааны бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт, зан үйлд илрэх өөрчлөлт, зан аашийн бэрхшээлтэй байдал зэргийг оношилно.
- ✓ Хэмжүүр V5. Стрессийн архаг хэлбэр: Сөрөг стресс хуримтлагдан бэхэжсэнээр илрэх түгшүүр, хэрцгий байдал, сэтгэл гутрал, ерөнхий тамирдалт, архаг ядаргаа, психосоматик хариу урвал ба нойронд өөрчлөлт гарсныг үнэлнэ.
- ✓ Хэмжүүр V6. Стрессийн сөрөг нөлөө хуримтлагдсанаар бие хүний зан ааш болон зан үйлийн бүтэц өөрчлөгддөг бөгөөд эдгээр нь стрессийн ийм хэлбэр болох А хэв шинжийн үед тухайн хүний зан үйлд гутралын шинж тэмдэг, невротик хариу үйлдэл, биед хортой нөлөө үзүүлэх зэргээр илэрдэг. Судалгаанд хамрагдагчдын хариултын үнэлгээг шалган үзэхэд, аргачлалын бүрэлдэхүүнд нэмэлт болгон оруулсан “нийгмийн хүлээлт” (LO) гэсэн хэмжүүр үнэн магадтай байна. Гол хэмжүүрт орсон дэд хэмжүүрүүдийг тооцоолж тайлбарлахад бүрэн боломжтой. Үндсэн хэмжүүр V1-т (Хөдөлмөрийн зохион байгуулалт ба нөхцөл) 4 дэд хэмжүүрүүд (Хөдөлмөрийн нөхцөл, Ажлын ачаалал, эрчим, Хөдөлмөрийн агуулгын онцлог, Хөдөлмөрийн ажиллагааны зохион байгуулалт) багтах бөгөөд энэ нь уламжлалт хөдөлмөрийн профессиограф шинжилгээний янз бүрийн техникүүдийг илрүүлдэг тул чухал хэсэг юм.

Үндсэн хэмжүүр V2-ын (Мэргэжлийн байдал дахь субъектын үнэлгээ) 4 дэд хэмжүүрүүд нь Дж. Р.Олдхэм, Дж. Хакман нарын [Hackman & Oldhem, 1971] сонгодог онолд тэмдэглэсэнчлэн, хөдөлмөрийн нөхцөл байдал дахь үндсэн бүрэлдэхүүн болох субъектив төлөвийг агуулна. V3 үндсэн хэмжүүрт нэмэлт хүчин зүйлүүд болгож ажлын нөхцөл байдлын субъектив дүр агуулгын шаардлагатай мэдээллийг нэмдэг. Эдгээрт ажлын орчин, зохион байгуулалт, хамт олны харилцаа, урам зориг, цалин хөлс, үнэлгээ, сэтгэл ханамж зэрэг орно. Эдгээр хүчин зүйлс нь К.К.Купер, Р.Карасек и Т.Теорел, Дж.Зигрист [Брайт, Жонс, 2003;

Купер, Маршалл, 1995; Cartwright et al., 1996; Karasek, 1979; Karasek & Theorell, 1990; Theorell, 2000] нарын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн загваруудад стрессийг даамжрахад шалтгаалах үндэслэлүүд хэмээн тодорхойлсон.

Үндсэн V4, V5 хэмжүүрт стрессийн цочмог ба архаг хэлбэрүүдийг онолоход чиглэгдсэн ба судалгааны зохицуулах чиг хандлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн олон тооны судалгааг нэгтгэн улмаар стрессийн төрлүүдийн нийтлэг болон онцлог шинж тэмдгүүдийг тодорхойлсон. 14 Үндсэн V6 хэмжүүрт стрессийн уршгаар зан үйлд гажилт үүсч улмаар бие хүний тогтвортой байдал хувиран өөрчлөгддөг аюултай илрэлийг оношилно.

Жишээ нь, зан үйлийн А хэв шинж нь амжилтын төлөө өрсөлдөж, арсалддаг, хурдан хөдөлгөөнтэй, (тэмүүлэлтэй/ шаламгай), догшин ширүүн, тэсвэргүй, тайван биш, хэт идэвхитэй, үг яриа нь илэрхийлэлтэй, нүүрний булчин байнгын хүчлэлтэй, цаг хугацаа хомс юм шиг мэдрэмж төрдөг, хариуцлагын зовнил мэдрэмж байнга нэмэгддэг, “гутрах” шинж тэмдэг илэрнэ, архи ууж, тамхи татна, невротик шинж илэрнэ. Орчин үеийн ном зохиолд, эрүүл хүний сэтгэц, бие махбодийн эрүүл мэндэд нөлөөлж байдаг шууд бус шалтгаан, эрсдэлт хүчин зүйлүүд нь хөдөлмөрийн үйл ажиллагааны үр ашгийг бууруулдаг тухай тэмдэглэсэн байдаг.

Тестийн хариултад 4 онооны хэмжүүрийг ашиглах бөгөөд оноо бүр ялгаатай үзүүлэлттэй. Үүнд:

- ✓ 1 оноо - хариултыг бүрэн зөвшөөрөхгүй үед өгнө. (“үгүй, энэ үнэн биш”, “Ихэндээ хэзээ ч үгүй” гэсэн үед)
- ✓ 2 оноо – “магадгүй”, “зарим нь үнэн”, эсвэл “хааяа” гэж хэсэгчлэн зөвшөөрөх үед энэхүү оноог авна.
- ✓ 3 оноо – хангалттай түвшинд зөвшөөрч байгаа буюу “үнэн”, “байнга” гэсэн сонголт хийхэд хэрэглэнэ.
- ✓ 4 оноо - бүхэлд нь зөвшөөрч байгаа үед (“маш зөв” эсвэл “нь бараг үргэлж”) энэ оноог өгнө.

Ийм хэлбэрийн хэмжээсийг орчин үеийн сэтгэл зүйн оношилгооны чанарын үнэлгээнд ихэвчлэн ашигладаг ИДИКС-ийн бүх л үндсэн болон дэд хэмжүүрээр стрессийн индекс дүнг тооцоолдог. “Зөвхөн муу” гэсэн үнэлгээ дэх тогтсон хандлагыг арилгах үүднээс оношилгооны хэсгийн өгөгдлүүдийг шууд болон урвуу хэлбэрээр нь тодорхой томъёолсон. Судалгааны оношилгооны хэсэг дэх зохион байгуулалттай ярилцлагын дүнд судлуулагчийн хүн ам зүйн байдлын тухай (хүйс, нас, гэр бүлийн тухай), ажлын хэрэгсэлтэй ажиллах,

дадлагажих хугацаа, стрессийн дарамттай байдал тэдний амьдралд нөлөөлдөг тухай, эрүүл мэндэд хортой дадал үүсч байгаа байдал, идэвхитэй амралтын тухай дэлгэрэнгүйгээр урьдчилан мэдэж авна.

Үнэлгээ Судалгааны материал болох ИДИКС системийн цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн ажлын байрны стресст тоон болон чанарын үнэлгээ өгдөг. Энэ нэгдсэн үнэлгээ нь дараах багц үзүүлэлт дээр суурилсан байна.


- ✓ Аргачлалын үндсэн индексүүдийн дэд хэмжүүр тус бүрийг тооцсон байх;
- ✓ Гол индексүүд нь үндсэн хэмжүүр бүр дэх дэд хэмжээсийн нийт оноог тусгах;
- ✓ Ерөнхий үзүүлэлт буюу стрессийн ерөнхий индекс нь бүх үндсэн хэмжүүрээр стрессийн түвшинд үнэлгээг өгдөг.
- ✓ Нэмэлт индекс нь нийгмийн хэрэгцээ, шаардлагаар судалгааны үр дүнгийн найдвартай зэргийг тодорхойлоход хэрэглэнэ.

ИДИКС-ийн бүх индексийн үнэлгээг харьцуулж, стандартчилахын тулд анхдагч оноог Т-утга руу шилжүүлнэ.8 Арга зүйг стандартчилахдаа, үндсэн оноо болгон авсан анхдагч оноог хувирган Колмогоров-Смирновын шалгуураар [Леонова, 2004] үнэлэхэд хэвийн тархалттай байгаа нь энэ аргачлалыг хэрэглэж болох үндэслэл болно.

Асуулгын үр дүнг тайлбарлахад стрессийн үндсэн индекс ба индексийн үндсэн хэмжүүрийн стандартчиллын Т-утгыг ашигласан. Энэ зорилгоор Т-утгын 5 онооны үнэлгээг ашиглах бөгөөд түүний тодорхойлох хязгаар нь: 1. стресс доод түвшин 2. стресс дунд зэргийн түвшин 3. стресс дунджаас дээш түвшин 4. стрессийн өндөр түвшин 5. стрессийн туйлын өндөр түвшингээр илэрхийлэгдэнэ. Энэхүү дэс дараалсан шатлал нь хувь хүний болон бүлгийн тестийн үр дүнг чанарын аргаар тайлбарлахад нэгдсэн хүснэгтийг гаргана.

Стрессийн индексийн хөгжлийн түвшинг тодорхой тохиолдол бүрт хүчтэй илрэх стрессийн хам шинжийн бүрдлүүдийг харгалзан “оргил” Т-утгын хэр хэмжээгээр тодорхойлно. 8 Бурлачук, Морозов, 1989; Бодалев, Столин, 2002; Гусев ба бусад., 1998

3. ЗАН ҮЙЛ, СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙГ ҮНЭЛЭХ ТЕСТ (BERS-2)



Олон жилийн турш хөгжиж ирсэн, хүний үйл ажиллагааны талаар тодорхой гаргалгаа гаргасан таамаглалтай, туршилтаар батлагдсан сул талд суурилсан арга барилтай харьцуулахад давуу талд суурилсан арга барил нь зөвхөн сүүлийн үед л олонд танигдаж дэмжлэг аваад байгаа юм. Энэхүү арга барил нь хүүхдийг хэрхэн харж, үнэлж, тэдэнтэй хэрхэн харьцаж байснаас нэлээд өөр шатад гарсан арга барил юм. Хэдийгээр мөн чанарын хувьд хэд хэдэн дутагдалтай хэрхэн хэрэгжих нь тодорхой бус байгаа ч гэсэн давуу талд суурилсан үнэлгээ нь дараах хэд хэдэн үзэл баримтлалд суурилдаг.

1. Бүх хүүхэд өөрийн гэсэн давуу талтай. Эдгээр давуу тал, авьяас, чадвар, нөөц бололцоо нь хүүхэд бүрийн хувьд онцлогтой байдаг. Тухайн хүүхдийн үйл ажиллагаа, хувийн нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлийн онцлогоос үл хамааран хүүхэд бүр нэг болон түүнээс дээш өөрийн гэсэн давуу талтай байдаг. Хэрэв мэргэжилтнүүд хүүхдийн давуу талыг олж тогтоон түүнд нь суурилахад цаг зав гаргаж чадвал хүүхэд болон тэдний гэр бүл нь хэцүү нөхцөл байдлыг илүү хялбар даван туулах боломжтой юм.
2. Багш, эцэг эх болон бусад хүн өөрт нь ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаас хүүхэд урам зориг авах боломжтой. Томчууд хүүхдийн сөрөг болон сул талд нь байнга анхаарал хандуулаад байвал, хүүхдийн идэвх чармайлт нь багасаж, бусдаас өөрийгөө тусгаарлах, уурлах уцаарлах хандлагатай болдог бөгөөд томчууд давуу болон эерэг талд нь ач холбогдол өгч байвал идэвх чармайлт нь сайжирч, зохих үйл ажиллагаанд оролцохдоо илүү идэвхтэй, түүнээсээ сэтгэл ханамж авч, нийгэмд оролцох байдал нь улам нэмэгдэх боломжтой.

3. Хүүхэд өөрийнхөө давуу талыг харуулж чадахгүй байна гэдэг нь хүүхдийн өөрийнх нь буруутай үйлдэл биш бөгөөд харин ч тухайн хүүхэд тодорхой чадавх, ур чадварыг суралцах хангалттай боломжийг олж авч чадаагүй байна гэсэн байна. Сургууль, гэр бүл, орон нутгаас нь хангалттай боломж, заавар чиглэл болон туршлагыг өгч чадах юм бол хүн олон төрлийн давуу талыг харуулах боломжтой байдаг.
4. Хүүхдэд зориулсан боловсрол, сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэнд болон нийгмийн үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөр, үйлчилгээ нь хүүхдийн давуу талд суурилах ёстой. Хүүхдийг асуудалтай эсвэл эмгэгтэй гэж харахын оронд мэргэжилтнүүд тэднийг илүү эерэг талаас нь харах ёстой. Давуу талын үзэл баримтлал нь тухайн хүний эерэг ур чадвар болон чадавх дээр төвлөрч чадах юм бол тэр өөрийнхөө ур чадвар болон давуу талаа илүү өргөн хүрээнд ашиглах боломжтой гэж үздэг байна. (Вейк, Рапп, Сулливан, & Кистардт, 1989).

Давуу талд суурилсан үнэлгээний давуу тал Саяхнаас давуу талд суурилсан үнэлгээг сургууль, сэтгэцийн эрүүл мэндийн клиникүүд, нийгмийн үйлчилгээний байгууллагуудад илрүүлэх, төлөвлөх, үнэлгээний үйл явцын нэг хэсэг болгож хэрэглэж байна. Хэдий тийм ч гэсэн мэргэжилтнүүд хэд хэдэн давуу талыг олж тогтоосон байна. Давуу талд суурилсан үнэлгээ нь дараах үр ашигтай. Үүнд:

1. Хүүхэд үйлчилгээ авахад нь ялангуяа тухайн хүүхэд болон түүний гэр бүл нь үйлчилгээ авахдаа дургүй, эсвэл өмнө нь үйлчилгээнээс төдийлөн амжилт олж байгаагүй түүхтэй бол тэднийг үйлчилгээ авахад нь илүү эерэг хандлагыг бий болгох (Жонсон & Фрейдмен, 1991 харна уу);
2. Хүүхдийн амьдралд юу болоод байгааг олж илрүүлэхэд нь хүүхэд, эцэг эх, гэр бүлийн бусад гишүүд болон мэргэжлийн хүмүүст туслах;
3. Ирээдүйн өсөлт болон хүүхдийн талаарх эерэг хүлээлтийг бий болгох үндэс суурь болсон чадавхыг мэргэжлийн хүмүүст сануулан ойлгуулах;
4. Харилцан итгэлцэл, дэмжлэг, нээлттэй байдал болон зорилгоо тодорхой болгох зэргээр эцэг эх мэргэжлийн хүмүүсийн хооронд эерэг харилцааг бий болгох (Салееби, 1992-г харна уу) (Энэхүү эцэг эх, мэргэжлийн хүмүүсийн хоорондын

энэхүү харилцаа нь хүүхэд болон эцэг эхэд зориулсан үйлчилгээний зорилгод хүрэх чухал давуу тал нь болох юм);

5. Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр (IEP), үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөнд оруулах ёстой нөөц бололцоог олж илрүүлэхэд нь туслах
6. Хүүхдийг нийгмийн бүтээлч гишүүн болоход нь хэрэгтэй давуу талыг олж илрүүлснээр мэргэжлийн хүмүүс болон гэр бүлд төлөвлөгөө гаргахад туслах болно.
7. Гэр бүл заримдаа хүүхдүүдийг өөрийнх нь амьдралд нөлөөлөх шийдвэр болон үйл явдалд өөрөө хариуцлага хүлээдэг болгоход чадваржуулах (Салееби, 1992-г харна уу);
8. Тусгайлсан үйлчилгээ авах явцдаа тухайн хүүхэд ямар давуу тал, ур чадварыг суралцсан талаар нь баримтжуулж бүртгэх


Эрсдэл, даван туулах хат чадвар болон хамгааллын хүчин зүйлүүд (Risk, resilience, and protective factors) Эрсдэлийн хүчин зүйлүүд нь хүүхэд зан үйл, сэтгэл зүйн асуудал, эмгэг үүсэх магадлалыг нэмэгдүүлж байдаг. Мэдэгдэж байгаа эрсдэлийн хүчин зүйлүүд нь төрөлхийн (тухайлбал генийн эмгэг, хөгжлийн хоцрогдол) болон хүрээлэн буй орчны (тухайлбал, ядуурал, ээж нь сэтгэл гутралтай) зэрэг байна. Тогтоогдсон эрсдэлийн хүчин зүйлүүдэд өртсөн бүх хүүхэд дасан зохицох чадвар сул, амьдралын хүлээлт нь доогуур байдаг гэж хэлж болохгүй юм. Харин ч өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд судлаачид амьдралын маш хүнд хэцүү нөхцөл байдалд байсан ч түүнийгээ даван туулж хэвийн үр дүнтэй амьдралтай болсон хүмүүсийн талаар судалгаа хийсэн байдаг. Мастений тодорхойлсноор даван туулах хат чадвар гэдэг нь “эрсдэл болон хүнд нөхцөл байдалд байсан ч амжилттай даван туулах” чадвар юм. (Masten,1994,хуудас 3). Амьдралын сөрөг хүчин зүйл, бүрхэг ирээдүйтэй байх эрсдэлээс хүүхдийг хамгаалах хэд хэдэн хүчин зүйл байдаг. Мастений хэлсээр хамгаалах хүчин зүйл гэдэг нь “хүнд хэцүү нөхцөл байдалд өртөх эрсдэл бүхий хүмүүст эерэг үр дүн авчрах бие даасан болон орчны нөхцөл байдлыг” хэлнэ гэсэн байна”

- Хамгааллын хүчин зүйлийг хувь хүний, гэр бүлийн, олон нийтийн хүчин зүйлүүд гэж ангилж болно (Гармези, Мастен, & Теллеген, 1984; Раттер, 1985). Хувь хүний хүчин зүйлд дунджаас дээгүүр оюун ухаан, сурлагын амжилт өндөр байх, тодорхой салбарт илүү чадвартай байх (тухайлбал, хөгжмийн нэг зэмсэг эсвэл спортоор хичээллэдэг байх) зэрэг орно. Гэр бүлийн хүчин зүйлд дэмжиж тусалдаг эцэг эхтэй байх, гэр бүл нь найрсаг бат бөх байх, хүмүүжлийн эерэг арга зэрэг орно. Орон нутгийн хүчин зүйлд хүүхэдтэй эерэг харилцаа үүсгэх хамаатан садан (тухайлбал эмээ өвөө) эсвэл албан бус дэмжлэг (тухайлбал, хөрш, хамба ламтан) зэрэг орно. Раттер (1985, 1987, 1989) зэрэг судлаачид эрсдэлийн хүчин зүйл болон хамгааллын хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэл нь хүүхдэд эерэг эсвэл сөрөг үр дүн гарахад нөлөөлж байдаг гэжээ.
- Давуу талд суурилсан үнэлгээ нь эрсдэл, даван туулах хат чадвар болон хамгааллын хүчин зүйлийн талаарх судалгаатай холбоотой юм. Давуу талд суурилсан үнэлгээ нь хүүхэд болон гэр бүлийн давуу тал, чадавх, чадвар болон нөөц бололцоог олж тогтооход чиглэдэг. Миний бодлоор хүүхдийн давуу тал нь хүүхдийн цаашдын өсөлт хөгжлийн суурь болж өгдөг бөгөөд хүүхдийн амьдралын эерэг болон сөрөг туршлагыг олж тогтоож байдаг. ЗСҮТ-2 бол хүүхэд, гэр бүлийн хүчин зүйлийг үнэлэх зориулалттай бөгөөд ирээдүйн амьдрал нь бүрхэг байх эрсдэл бүхий хүүхдийн хамгааллын хүчин зүйл болдог байна.

Хүүхдийн үйл ажиллагаа зан үйлийг бүрэн ойлгоход ганцхан эх сурвалж хангалтгүй байдаг учраас ЗСҮТ-2 нь олон эх сурвалжаас мэдээллийг цуглуулж авдаг. ЗСҮТ-2 нь хүүхдийн сэтгэл зүй, зан үйлийн давуу талын талаарх мэдээллийг хүүхэд, түүний эцэг эх, багш эсвэл сэтгэл зүйч гэсэн гурван үндсэн эх сурвалжид суурилан мэдээлэл авдаг. ЗСҮТ-2 нь хүүхдийн давуу талыг үнэлэх үнэлгээний гурван тестийн нэгдсэн цогц юм. Багшийн зүгээс үнэлэх тест (БТ), Эцэг эхийн зүгээс үнэлэх тест (ЭТ), Хүүхдийн зүгээс үнэлэх тест (ХТ) юм. Ихэнх хүүхдийн хувьд мэдээллийг бүх гурван эх сурвалжаас авдаг. Гэвч зарим хүүхдийн хувьд гурван эх сурвалж нь бүгд хамааралтай байх албагүй юм. Тухайлбал, сургуульд явдаггүй хүүхдүүдийн хувьд Багшийн тестийг хэрэглэх боломжгүй байдаг. Саяхан асрамжийн газарт шилжсэн хүүхдийн хувьд эцэг, эхийн тестийг авах боломжгүй байна. 11-ээс доош насны хүүхдүүд эсвэл хөгжлийн хувьд хоцрогдолтой хүүхдээс Хүүхдийн тестийг авах боломжгүй байж болно.

ЗСҮТ-2 нь сайтар боловсруулсан, сэтгэц хэмжил зүйн үзүүлэлт сайтай оношилгоо үнэлгээний хэрэгсэл юм. Үүнийг зарчмын хувьд таван өөр байдлаар ашиглах боломжтой: (a) давуу тал цөөнтэй хүүхдийг олж илрүүлэх, (b) интервенц болон эмчилгээний төлөвлөгөөний зорилгыг тодорхойлох, (c) интервенцийн давуу болон сул талыг олж тогтоох, (d) тусгайлсан үйлчилгээний үр дүнд гарсан ахицыг баримтжуулах, (e) судалгаа, үнэлгээний төслүүд дэх давуу талыг хэмжих зэргээр хэрэглэх боломжтой.

4. TAT TEST Thematic Apperception Test



Бие хүний сэтгэл хөдлөл, мэдрэмж, давамгайлж буй хүсэл, бодол санаа, зовнил болон зан байдлын зөрчилдөөн зэргийг илрүүлэх TAT (The Thematic Apperception Test)-ийг Харвардын сэтгэл зүйн эмнэлгийн сэтгэл судлаач доктор Ву. Henry, А. Murray нарын боловсруулсан TAT (The Thematic Apperception Test) нь судлуулагчийн намтар, түүхийг яриулж байгаагаараа онцлогтой. Ингэж тухайн судлуулагчийн чөлөөтэй төсөөлөх чадвар болон нууцлаг зүйлийг мэдэх болно. Мөн судлуулагчийн өөрийнх нь мэдэрч буй зүйл, өнгөрсөн, одоо,

ирээдүйн талаарх төсөөллийг гаргаж ирдэг. Эдгээрт дараах зүйлс илэрч болно.

- Тулгарч байгаа нөхцөл байдал
- Мөрөөдөлд автах үеийн төсөөлөл
- Дурсгалтай мөчүүд
- Асуудалтай тулгарахад хүсдэг болон хүсдэггүй, айдаг зүйл

Энэ бүхэн өнгөрсөн, одоо эсвэл ирээдүйн алинтай илүү холбоотой болохыг шийддэг. Эндээс үзэхэд, судлуулагчийн тухайн цаг үеийн зан байдал шийдвэрлэх ач холбогдолтой.

Удирдамжид ТАТ-ын аргачлалаар судалгаа явуулах зарчим, өгөгдсөн зургийн тайлбар, зохиомж, гол баатруудын үзэл санаа, хүрээлэн буй орчны нөлөө, оношилгооны үр дүнг тайлбарлах зэрэг шаардлагатай мэдээллийг нэгтгэсэн. ТАТ нь зориулалт өөр, хоёр хувилбар бүхий удирдамжтай. Үүнд:

А хувилбар: Оюуны чадамж хэвийн өсвөр насны хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан

Б хувилбар: Бага насны хүүхдүүд болон оюуны чадамж дунджаас доош түвшний насанд хүрэгчид, сэтгэцийн эмгэгтэй хүмүүст гэсэн хувилбартай.

Судлуулагчийн талаарх эцсийн үнэлгээ, дүгнэлтийг мэргэшсэн сэтгэл зүйч гаргана.

Судлуулагчийг бэлтгэх Ихэнх судлуулагчид /өвчтөнд/ сорилыг гүйцэтгэх зааврыг уншиж танилцуулахаас өөр нэг их бэлтгэл ажил шаарддаггүй. Гэхдээ өмнө ямар нэг сэтгэл зүйн сорил өгч үзээгүй хүмүүсийн хувьд оюун ухаан, дадал, Рошахын гэх мэт сорилтой ажиллуулж тэднийг бэлтгэх хэрэгтэй байдаг. Хүүхдүүдийн хувьд ямар нэгэн дүрст болон тоглоомуудаар тоглуулсны дараа сорилыг илүү сайн хийж гүйцэтгэдэг.

Сорилын үеийн байдал Судлуулагчийн нас, хүйс, харилцааны өнгө аяс болон судалгааны орчин зэргээс сорилын үеийн уур амьсгал шалтгаална. Энэ бүгд судлуулагчийн сэтгэмж хөгжил хэр эрчтэй, хүчтэй

байхад нөлөөлдөг. Иймээс сорилын үе нөхөрсөг уур амьсгалтай байх хэрэгтэй. Судлаачийн гол зорилго нь судлуулагчаас чанартай сайн мэдээлэл авах байдаг бөгөөд энэ нь судлуулагчийн бүтээлч байдлаас ихээхэн хамаардаг. Судлуулагчийн бүтээлч байдал нь идэвхгүй, зориудын бус, хамтарсан биш үйл ажиллагаа байдаг тул нэлээд төвөгтэй байдаг. Хамгийн гол нь судлаачийн зүгээс өөрсдийг нь ойлгож хүлээн авч байгааг мэдрэх чухал байдаг. Иймээс тэднийг дэмжих, найрсаг уур амьсгалтай байх нь сорилын үр дүн сайн гарах баталгаа болдог.

Ихэнх тохиолдолд судлаачийг судлуулагч шаардлагатай мэдээллээр хангахгүй байх явдал гардаг. Энэ нь судлаач сорилын үед хайрамжгүй хандсан эсвэл зохиосон түүхийг хэт шүүмжилсэн байж болно.

Эхний цуврал Судлуулагч түшлэгтэй, зөөлөн сандал дээр тухлан суух эсвэл буйдан дээр хэвтэж болно. Судлаач судлуулагчид дараах хоёр хувилбарын аль нэгийг ойлгомжтой уншиж сонсоно.

А хувилбар Энэ хувилбар оюун ухааны хөгжлийн дунд болон түүнээс дээш төвшинтэй өсвөр насны болон насанд хүрсэн хүмүүст зориулагдсан.

“Энэ бол оюуны үйл ажиллагааны нэг хэлбэр болох төсөөлөл дээр тулгуурласан сорил юм. Би танд хэдэн зураг дарааллаар нь үзүүлнэ. Харин таны даалгавар бол зурагт тохирох сэтгэл хөдлөм түүхийг зохиох.

Өгөгдсөн хугацаанд зурагт дүрсэлсэн үйл явдлуудыг тайлбарлаж гол дүрийн баатар юу мэдэрч, юуны тухай бодож байгааг хэлнэ. Дараа нь тухайн нөхцөл байдлын үр дагаврын талаар яриарай. Таны толгойд ямар санаа орж ирж байна, түүнийгээ ярина. Та ойлгосон уу? Та 10 зурагт 50 минут зарцуулна. Өөрөөр хэлбэл, таны нэг түүхэнд таван минут өгнө. Эхний зураг энэ байна”
Б хувилбар Энэ хувилбарыг сэтгэцийн эмгэгтэй өвчтөн болон боловсрол, оюун ухааны хөгжлийн төвшин доогуур хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан.

“Энэ нь зохиож ярих чадвар шалгах сорил. Надад танд үзүүлэхээр бэлтгэсэн хэдэн зураг байна. Би таныг зураг болгоноор ямар нэг түүх зохиогоосой гэж хүсч байна. Та юу болсон, одоо юу болж байгаа, яаж дуусахыг хэлнэ. Мөн хүмүүс юу мэдэрч, юуны тухай бодож байгаа талаар ярина. Та дурын түүхээ зохиож болно. Танд ойлгомжтой байна уу? За, сайн байна. Энэ эхний зураг. Танд түүх зохиох таван минутын хугацаа байна. Үүнийг хэрхэн хийж гүйцэтгэхийг харъя”

Сорилын зааварчилгаа судлуулагчийн нас, оюун ухаан, бие хүний чадваруудаас хамаарч өөрчлөгдөж болно. Гэхдээ эхэнд нь “чөлөөтэй уран сэтгэ” гэж хэлэх хэрэггүй. Учир нь иймэрхүү төлөвлөгөө бүхий зааварчилгаа психоанализын чиглэлд байдаг шиг чөлөөт холбоослолыг тайлбарлах нь гэсэн бодлыг судлуулагчид төрүүлж болно. Энэ бодол төрж байгаа санааг хүчтэй хянах болно. Харин судлуулагч, туршилт зөвхөн түүний уран зохиол ба бүтээлч чадварыг сонирхож байна гэдэгт итгэж байх ёстой.

Эхний түүхийг ярьсны дараа өвчтөн залхвал зааварчилгааг дахин сануулах хэрэгтэй. Жишээлбэл: Судлаач ингэж хэлж болно. “Энэ үнэхээр сонирхолтой түүх байлаа. Гэхдээ та, ээж нь буруутгаж байхад хүү өөрийгөө хэрхэн авч явааг хэлэхээ мартчихлаа. Та энэ байдлыг орхигдууллаа. Та гарах үр дагавруудыг хэлсэнгүй. Та энэ түүхийг гурав орчим минутанд ярилаа. Дараагийн түүх бага зэрэг урт байж болно. Одоо хоёр дахь зураг дээр ярилцъя”

Судлуулагч төлөвлөсөн болон дэгийн дагуу даалгаврыг гүйцэтгэхгүй байгаа тохиолдол, мөн чухал хэсгийг орхигдуулсан бол судлаач түүнд сануулга өгөх шаардлага байхгүй. Харин ямар ч зүйл ярихгүй бол түүнтэй яриа өрнүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй.

Судлуулагч хэт удаан ярих эсвэл асуулттай холбогдолгүй зүйл ярьж эхлэх үед судлаач түүнийг зогсоож “ийм үйл явдал, зохиомж яриулахыг хүсч

байгаа юм шүү” гэдгийг хэлж болно. Эсвэл судлуулагч зурган дээр хэт нарийвчлан тодорхой ярих гэвэл түүнд эвтэйхнээр “Энэ бол төсөөллийн сорил” гэдгийг сануулах нь чухал.

Хэрвээ судлуулагч ойлгохгүй байгаа зүйлийнхээ талаар асуувал “Та үүнийг яаж ч төсөөлж болно” гэж хариулж болно. Гэхдээ нэг зураг дээр олон богино хэмжээний өгүүлэмж ярилцах боломжгүй. Аль болох нөхцөл бололцоог сайхан зохиомж бүтээхэд төвлөрүүлэх хэрэгтэй байдаг.

Хүүхдүүд болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүстэй сорил эхлэхээс өмнө маш сайн ойлголцсон байх шаардлагатай. Хэтэрхий дуу цөөнтэй хүүхдээс сорил авахдаа тун сайн зөвшилцсөн байх нь илүү үр дүнтэй. Судлаач “Хэрвээ чи надад гоё зохиомжууд ярьж өгвөл би чамд бэлэг өгнө” эсвэл “Хэрвээ чи даалгавраа сайн гүйцэтгэвэл би сонирхолтой түүх ярьж өгье”, “Надад хамгийн шилдэг түүх ярьсан хүүхдэд ном бэлэглэнэ” гэх мэтээр ярилцаж болно.

Судлуулагчийн чадварын хэмжүүр байдаг. Тухайлбал, 300 үгтэй бол насанд хүрэгчид, 150 үгтэй бол 10 настай хүүхдийн зохиомжийн жишиг юм. Ихэнх судлаачид туслагчгүйн улмаас судлуулагчийн хэлсэн үгийг нарийн тодорхой бичиж авахын тулд чадлаараа хичээж дүрмийн болон дүрмийн бус таталган бичгийн аргыг хэрэглэх хэрэгтэй. Мөн микрофоны тусламжтайгаар өөр өөрөөнөөс эсвэл шилний цаана сууж бичлэг хийж болно.

Хоёрдугаар цуврал. Нэг болон хоёрдугаар цувралын хооронд хамгийн багадаа нэг өдрийн зайтай байна. Энэ хэсгийн судалгаа хийх зарчим түүрүүчийнхтэй адил боловч төсөөллийг илүү чөлөөтэй хийлгэдгээрээ ялгаатай.

“А” хувилбар “Өнөөдрийн ажил өмнөхтэй адил. Гэхдээ арай илүү чөлөөтэй сэтгэх боломжтой. Таны өмнөх 10 түүх гайхалтай байсан ч та өөрийнхөө

төсөөллийг зөвхөн өдөр тутмын амьдралын нөхцөл байдлаар хязгаарлаж байна. Одоо үүнээс өргөн хүрээнд үлгэр домог эсвэл ёгт үлгэр шиг сэтгэхийг чинь сонсохыг хүсч байна. Ингээд эхний зураг ...”


“Б” хувилбар “Өнөөдөр би танд хэдэн зураг үзүүлэх болно. Энэ удаагийн зургууд урьдынхаасаа сонирхолтой байх учраас танд илүү хялбар байх болно. Урьд нь та надад хэдэн сайхан зохиомж ярьж өгсөн. Өнөөдөр би таныг дахиад хэдэн зохиомж ярихыг чинь сонсьё. Болж өгвөл урьд зохиож байснаасаа илүү үлгэр шиг зохиомж ярихыг эрмэлзээрэй. Ингээд нэг дугаартай зураг ...”

Хоосон цаас. 16 хүртэл дугаарласан карт бүхий хуудсанд тусгай заавар шаардлагатай. Судлаач “Таны өмнө хоосон цаас байна. Энд ямар нэгэн байж болох зүйлийг төсөөл. Тэгээд түүнийгээ бич” гэж хэлнэ. Хэрэв судлуулагч энэ заавраас татгалзвал судлаач “Нүдээ ань. Тэр зургийг төсөөл” гэж хэлж болно. Үүний дараа судлуулагчийн бодсон зүйлийг бичүүлнэ. Тэгээд судлаач “Одоо энэ тухай түүхийг надад ярьж өгнө үү” гэнэ.

Дараа нь хийх ярилцлага Судлуулагчийн зохиомжийг сайтар задлан шинжлэх нь түүнийг ямар эх сурвалжаас үүсэлтэй болохыг тогтооход тустай. Үүнийг нөхцөл байдлаас шалтгаалаад шууд хийж болох ч хэдэн өдөр хойшлогдож болно. Судлаач зохиомжийг үзээд өөрийн асуултуудыг лавшруулж болох юм. Ийм маягаар ТАТ-ын зохиомжуудад чөлөөт холбоослол үүсгэдэг. Энд зохиомжуудын сэдэв, зохион байгуулалт, хэв маяг зэргийн хамаарлыг авч үзнэ. Эдгээр хамаарал дээр үндэслэн судлуулагчийн зан авир, сэтгэл хөдлөл, ажиглах чадвар, оюун ухаан, гоо зүй, төсөөлөл, зохион бичих болон хэл ярианы чадамж, сэтгэл зүйн нарийн ухаан, бодит байдлын мэдрэмж, танин мэдэх гээд хэд хэдэн зүйлийг судалж болно. Хэлний хэрэгцээ, сэдэв хоёрын зохицолгүй байдал мөн үзэл бодол, үйл явдлын үл нийцэл зэрэг нь төөрөгдөл үүсгэдэг.

ТАТ-ын үр дүнгээс харахад судлуулагчийн түр зуурын сэтгэл хөдлөл болон амьдралын байдалтай холбоотой байдаг. Иймд зохиомжийг үйл явдлын агуулга, чиг хандлага, шинж чанарыг бодитой илэрхийлнэ. Гэхдээ энэ талаар хангалттай мэдээлэл байхгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЕРТӨНЦ ЗӨВЛӨМЖ



Багш, эцэг эхчүүд өөрийн шавь болон хүүхдэдээ тусалж, тэднийг дэмжихэд ямагт бэлэн байдаг. Та хүүхдэдээ байнга ямар нэгэн үүрэг хариуцлага ногдуулж, үйл ажиллагааг нь хянаж, үр ашиггүй дэмий зүйл хийхээс үргэлж сэргийлж, өөрийнхөө бүхий л үйл ажиллагаагаараа үлгэр жишээ үзүүлдэг байх ёстой. Энэ нь түүнд урам зориг, хүч чадал, өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх чадвар

төлөвшүүлэх ба өөрийг нь их хүндэлдэг гэдгийг ухаардаг

Өөрийгөө хүндлэх чанар нь хүүхэд нийгмийн харилцаанд дасан суралцах төдийгүй муу зуршлаас өөрийгөө татаж авах, тэдний аливаа сэдэл, үйлдэл, ололт амжилт зэрэгт гол үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн үзэл бодол, өөрийгөө хүндлэх чанар тэдэнд багаас нь төлөвшиж эхэлдэг. Зарим хүүхэд өөрийнхөө талаар эерэг сэтгэгдэлтэй, өөрийн үнэ цэнийг ойлгож, авьяас билэг, ололт амжилт, гадаад төрх зэргээ үнэлэн хүндлэх, бахархах чадвартай байдаг. Тэд

өөрсдийн алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрч, зарим үед гаргадаг бүтэлгүйтлээ ухаарна. Харин нэг хэсэг хүүхдүүд өөрсдийн талаар арай өөр сэтгэгдэлтэй байх явдал цөөнгүй. Өөрсдийгөө сул дорой, амьдралдаа ямар нэг өөрчлөлт бий болгон түүндээ хүрэх чадваргүй гээд итгэчихсэн байдаг. Магадгүй тэд зожиг, аливаа зүйлд хэт болгоомжтой ханддаг, бусдаар өөрийгөө сонжуулах дургүй, эрсдэлд өөрийгөө сорихыг хүсдэггүй.

Өөрийгөө хүндлэх чанар гэж юу вэ? Энэ нь хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлгээний нэг хэлбэр юм. Өөрийгөө хүндлэх чанар нь хүүхдийн дан ганц таамаглалаар бус амьдралд нь чухал нөлөө үзүүлэх хүмүүсийн бодол санаа болон эцэг эх, найз нөхөд, багш нартаа ямар сэтгэгдэл төрүүлдэг зэргээр тодорхойлогдоно.

Хүүхдийн өөрийгөө хүндлэх чанар нь түүний биологийн буюу төрөлхийн онцлогууд /темперамент, оюун ухаан гэх мэт/ болон орчны нөлөөллүүдээс /эцэг эхийн сурган хүмүүжүүлэх хэв маяг, эдийн засгийн байдал, үе тэнгийнхэн, насанд хүрэгчидтэй харилцах харилцаа гэх мэт/ үүдэн бий болдог.

Хэрвээ танд дараах байдал :

- Таны хүүхэд ямар нэгэн зүйл хийхээс зайлсхийвэл
- Тэр тоглож байсан тоглоомоо эсвэл хийж байсан зүйлээ орхивол
- Бусдад нэр хоч өгөх, шоолох , доромжлох
- Сургуулиас зугтах эсвэл сурах идэвх нь буурах
- Найзуудтайгаа харьцах нь бага байх буюу нийгмийн идэвхгүй байх
- Гуньсан, уурласан, ноомой байдал ажиглагдах
- Өөртөө итгэлгүй, “Би хэзээ ч зөв юм хийдэггүй”, “Надад бүх хүмүүс дургүй”, “Би л буруутай” гэх мэт байдал үзүүлэх
- Магтаал, зэмлэл , бусдын саналыг эмзгээр хүлээж авах
- Бусдын муу зуршлын /архи, тамхи, бодис/ нөлөөнд илүү автагдах гэх мэт
- Хүүхдэдээ цаг гаргаж, ямагт түүнтэй хамт байхыг хичээ.
- Хүүхэдтэйгээ тоглож бай. Тэгэхдээ ялагч, ялагдагчгүй бөгөөд хүүхдэд чинь хөөр баясал, баяр баясгалан авчрахаар байвал сайн.
- Ямар нэгэн бодол санаагаа илэрхийлэхэд нь шүүмжлэхгүйгээр анхааралтай сонс.
- Ямар ч үед тэдэнд шийдвэр гаргах боломжийг өг.
- Тэдний баярладаг, бахархдаг, дуртай зүйлээс нь ярьж өгөн, тэдэнд үнэн сэтгэлээсээ ханд.
- Хийсэн зүйлийг нь үнэлж амжилтыг нь энгийн үгээр магт.
- Та авьяас чадварт нь үргэлж найддаг, итгэдэг гэдгээ ойлгуул. Ингэснээр тэр хичээл зүтгэлийнхээ үр дүнд авьяас чадвартай болж байгаагаа мэдэж урам зориг орох болно.
- Таны хүүхэдтэйгээ харилцах түүнд хандах шинэ арга барил тань тэдэнд шинэ сэдэл тэмүүлэл төрүүлээд зогсохгүй авьяас чадварыг нь хөгжүүлэх

Хүүхэд гэр бүлийн дэмжлэг туслалцаатайгаар өөрийгөө хүндлэх чанарыг олж авдаг. Биеэ хүндэтгэх нь амжилтын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хүүхдэд насанд хүрэгчдийн хүрээнд орох бололцоог олгох хэрэгтэй. Хүүхэд өсвөр насандаа их зүйл бүтээдэг бөгөөд энэ үед хүүхдийн үр бүтээлд амжилт гаргах чадвар, өөртөө итгэж найдах байдал нь дээшилдэг. Энэ байдал хүүхдийн ирээдүйд нөлөөлнө.Таны хүүхэд эргэцүүлэн боддог, өөрийн ухамсартай болоход та хамгийн их нөлөөтэй хүн нь байх ёстой. Тэдэнд тохиолдсон бэрхшээлийг ярилцаж тусалж, зөвлөгөө өгч байх нь чухал.

Үе тэнгийнхний бүлэг нь харьцангуй тогтвортой байдаг бөгөөд хэсэг хугацаанд өөрийн хамт олонч байдлаа хадгалж чаддаг. Маш богино хугацаанд хүүхдийн бүлэглэл үүсдэг. Танилцаад л удалгүй харилцан бие биенээ хүндэтгэх, нэг нэгэндээ нөлөөлөх, бүлгийн өөрийн дэглэм тогтох үйл явагдана. Бүлгийн гишүүдэд нэгдсэн сонирхол, хэм хэмжээ байдаг. Үе тэнгийнхний бүлгийн гишүүдийн хувьд бүлгийн ач холбогдол 10-12 насанд улам өндөрждөг.

Охид, хөвгүүдийн нөхөрлөл, тэдгээрийн бие биенээ хайрлах энэрэх асуудал нь ижил төстэй ба ялгаатай талтай. Сургуулийн амьдралд ч тоглоомын талбайд ч, сургуулийн цайны газар хүртэл “хөвгүүдийн ширээ”, “охидын ширээ” гэсэн албан бус хуваарилалт цөөнгүй ажиглагддаг. Хөвгүүдэд хамтдаа цэнгэж зугаацдаг, баясаж нааддаг тодорхой бүлэг үе тэнгийнхэн хөвгүүд хэрэгтэй байдаг. Ийм бүлэг бүрэлдсэн үед тэдэнд илүү эрх чөлөөтэй, сайхан санагддаг. Тэд ихэвчлэн өөр өөрийн сонирхдог зүйлээрээ тухайлбал: хөл бөмбөг, гар бөмбөг тоглодог өөрсдийн хүсэл сонирхлоороо нэгдсэн байдаг. Хөвгүүд сонирхол нэгтнээ найз нөхрөө болгож авдаг байхад, охид өөртэйгээ хувийн онцлог шинжээрээ ижил төстэй хэн нэгнийг найзаа болгохоор хайдаг байна. Охид хамгийн сайн найзаасаа холдон явах буюу харилцаагаа таслах болоход сэтгэлээр амархан унаж, хямардаг Эцэг, эхийн хувьд: та хүүхдийнхээ зан байдлаас болж санаа зовох, бухимдах, уурлах, гэмших, уй гашууд автах, зүйд нийцэхгүй санагдах зэрэг нь хэвийн зүйл юм гэдгийг сайтар ойлго. Төгс төгөлдөр байх, үр хүүхдээ төгс өсгөх гэж өрсөлдөх нь дэмий. Та хүүхэд байхдаа ямар ааш гаргаж, яаж эвгүй аашилдаг байсан, ээж аав тань, таны ааш зантай яаж зохицдог байсан, тэдний хүмүүжүүлэх арга барилыг нь та юу гэж үздэг байсан тухайгаа эргээд нэг бодоод үз. Тэд төгс төгөлдөр байгаагүй. Тэдний алдаа дутагдлыг нөхөж, өөрийгөө төгс төгөлдөр болгох гэж “Би эцэг эхийнхээ хийж байсан алдааг давтахгүй” гэж өөртөө тушаал өгөх гэж битгий хичээгээрэй.

Хүүхдүүд бол уян, зөөлөн, өршөөнгүй, өөрсдийнхөө алдаан дээр суралцаж өсч өндийдөг. Эцэг эхчүүд өөрсдийн хувийн бүх сэтгэл ханамжийг үр хүүхдүүдээсээ болон эцэг эх байх гэдэг үүргийг хэрхэн биелүүлж байгаагаасаа олж авах гэж хүсээд хэрэггүй. Эцэг эхийн хувьд та өөрийн философийг хөгжүүлэх хэрэгтэй. Үүгээрээ та тохитой байж, уян зөөлөн дасан зохицох боломжтой орчинд байх болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЯВЦ, ҮР ДҮН

“Монгол хүний сэтгэцийн хөгжлийг судлах тестүүд нутагшуулах ба үндэсний сан бүрдүүлэх” төслийн багийнхан 2018-2020 онуудад календарчилсан төлөвлөгөөний дагуу ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

- Сэтгэл зүйн суурь тест сорилуудад адаптаци хийж Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлон, өөрийн оронд нутагшуулах зорилгын хүрээнд Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлоход нэн шаардлагатай тестүүдийн судалгааг гаргаж, зарим тестүүдийг захиалан худалдаж авах, орчуулах ажлуудыг үе шаттайгаар төлөвлөгөөний дагуу энэхүү төслийн хүрээнд санхүүжилтийн эхний жил дараах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 1. “ИДИКС” сэтгэл зүйн тестийг орчуулсан. Үүнд:
 - Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС”
 2. Мэргэжлийн байгууллага, сэтгэл судлаач, мэргэжилтнүүдийг оролцуулан Монгол хэлнээ хөрвүүлсэн дээрх тестүүдийн орчуулгын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан орчуулгын үг хэллэг, найруулгыг засан сайжруулсан.
 3. Улаанбаатар хотын Хан –Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийт 350 хүнээс Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” арга зүйгээр судалгаа авч, үр дүнг боловсруулан, тестийн даалгаврын хүндрэлийн индексийг тодорхойлсон.
 4. Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” тестээр сэтгэл хөдлөл, мэдрэмж, давамгайлж буй хүсэл, бодол санаа, зовнил болон зан байдлын зөрчилдөөн зэргийг илрүүлэх судалгаа авч боловсруулан үр дүнд чанарын шинжилгээ хийж, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн.
 5. Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” удирдамжийг нягтлан дахин засварлан сайжруулсан хувилбарыг мэргэжлийн сэтгэл судлаачдаар хэлэлцүүлсэн.
 6. Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” удирдамжийг хэвлүүлж, МУБИС болон сэтгэл судлалын шинжлэх ухааны хэрэглээнд нэвтрүүлэн Монгол хүний сэтгэцийн онцлогийг судлах тестийн үндэсний санг нэмэгдүүлсэн.

- Сэтгэл зүйн суурь тест сорилуудад адаптаци хийж Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлон, өөрийн оронд нутагшуулах зорилго бүхий энэхүү төслийн хүрээнд санхүүжилтийн хоёр дахь жилд дараах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Дараах сэтгэл зүйн тестүүдийг захиалан авч Монгол хэлнээ хөрвүүлсэн.

- Мэргэжлийн стрессийг оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС”
- Thematic Apperception Test “ТАТ” тест

Хөрвүүлэх ажлыг 2 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

Нэгдүгээрт, Thematic Apperception Test “ТАТ” тестийг Англиас - Монгол хэл рүү

Мэргэжлийн стрессийг оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” тестийг Оросоос - Монгол хэл рүү орчуулсан.

Хоёрдугаарт, Монгол хэлнээ хөрвүүлсэн тестийн хувилбарыг үндсэн эх хэл рүү нь хөрвүүлэх ажлыг хийсэн. Өөрөөр хэлбэл, бид дахин англи, болон орос хэл рүү нь орчуулж сэтгэл зүйн тестийг гадаадын улс орон зохицуулан хэрэглэх, адаптаци хийхэд баримталдаг шаардлагын дагуу орчуулсан.

2. Мэргэжлийн байгууллага, сэтгэл судлаач, мэргэжилтнүүдийг оролцуулан Монгол хэлнээ хөрвүүлсэн дээрх тестүүдийн орчуулгын талаар хэлэлцүүлгийн ажлыг үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Тестийн орчуулгын үг хэллэг, найруулгыг өсвөр насны монгол хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохируулан хэл шинжээч, монгол хэлний багш, сэтгэл судлаачид, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан, тэдний санал, зөвлөмжид тулгуурлан засан сайжруулсан.

3. Улаанбаатар хотын Хан –Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн боловсролын болон худалдааны байгууллагын нийт 350 багш, ажилтан, алба хаагчдаас Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” арга зүйгээр судалгаа авч, үр дүнг боловсруулан, тестийн даалгаврын хүндрэлийн индексийг тодорхойлсон. Зарим даалгаврыг өөрийн орны нийгэм, соёлын онцлогт тохируулан зохицуулах ажлуудыг хийж, тухай бүрт нь мэргэжлийн байгууллагын төлөөлөл, сэтгэл судлаачдаар хэлэлцүүлж даалгаварт тохиргоо хийх ажлыг амжилттай гүйцэтгэсэн.

4. Өөрийн орны нөхцөлд зохицуулан туршсан Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” тестээр туршигдагдагч судлуулагчдын сэтгэл хөдлөл, мэдрэмж, давамгайлж буй хүсэл, бодол санаа, зовнил болон зан байдлын зөрчилдөөн зэргийг илрүүлэх үндсэн судалгааг зохион байгуулсан. Судалгааг SPSS-21

программаар боловсруулан, чанарын шинжилгээ хийж судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн.

5. Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй “ИДИКС” удирдамжийг нягтлан дахин засварлан сайжруулсан хувилбарыг мэргэжлийн сэтгэл судлаачдаар хэлэлцүүлэн Профессор П.Цэрэндондов хянан тохиолдуулж арга зүйн удирдамжийг хэвлүүлэн сэтгэл судлалын оношилгоо-судалгаанд хэрэглээнд нэвтрүүлсэн.
- Сэтгэл зүйн суурь тест сорилуудад адаптаци хийж Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлон, өөрийн оронд нутагшуулах зорилгын хүрээнд Монгол хүний сэтгэцийн хөгжлийг оношлоход нэн шаардлагатай тестүүдийн судалгааг гаргаж, зарим тестүүдийг захиалан худалдаж авах, орчуулах ажлуудыг үе шаттайгаар төлөвлөгөөний дагуу энэхүү төслийн хүрээнд санхүүжилтийн эхний жил дараах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

1. Суурь судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээр хэлэлцүүлэх хэлэлцүүлгүүдийг үе шаттайгаар зохион байгуулж, төстийн аргачлалд сайжруулалтууд хийсэн.
2. Суурь судалгааны үр дүнгүүдийн боловсруулалтын тоон болон чанарын шинжилгээнүүд хийгдсэн. Тест, аргачлалын сүүлийн хувилбараар авсан үндсэн судалгааны үр дүнгээр магистрант, докторантууд эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлж, магистрын дипломын ажлууд гүйцэтгэсэн. Мөн одоо Сэтгэл судлалын чиглэлээр суралцаж буй 2 докторант эрдэм судлалын ажлынхаа судалгаанд ашиглаж эхний үр дүнгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллага, судлаачдаар хэлэлцүүлээд байна.
3. Өсвөр насны хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийг үнэлэх BERS-2 судалгааны үр дүнд тулгуурлан өсвөр насны хүүхдүүд болон тэдний багш, эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх ЗӨВЛӨМЖ боловсруулан, гарын авлага хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгон ашиглаж байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Монгол хүний сэтгэцийн хөгжлийг судлах тестүүд нутагшуулах үндэсний сан бүрдүүлэх” суурь судалгааг хэрэгжүүлж, дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Өөрийн орны нийгэм, соёлын онцлогт тохируулан зохицуулж, сорилын удирдамж, хэрэглэгдэхүүнийг хэвлүүлэн хэрэглээнд ашиглахад бэлэн болгосон байна. Үүнд:
 - ✓ ТАТ /Thematic Apperception Test/ (2018)
 - ✓ ИДИКС мэргэжлээс шалтгаалах стрессийг оношлох, залруулах арга зүй
 - ✓ Амьдралын замнал проектив тест (2019)
 - ✓ BERS-2 өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийг үнэлэх тестүүдийн арга зүйн удирдамж хэвлэгдсэн. (2020)
- Адаптаци хийгдсэн манай оронд нутагшуулсан энэхүү тестүүдээр МУБИС-ийн сэтгэл судлал арга зүйн тэнхмийн 4 магистрант эдгээр тестүүдээс ашиглан сэтгэл судлалын магистрын зэргийг амжилттай хамгаалсан. Одоо сэтгэл судлалын 2 докторант эрдэм шинжилгээ -судалгааны ажлаа амжилттай хийж гүйцэтгэж байна.
- Эрдэм шинжилгээний 8 илтгэл хэлэлцүүлсэн. Үүнээс:
 - Дотоодод 7
 - Гадаадад 1

Хэлэлцүүлсэн илтгэлийн сэдвүүд:

- ✓ “Өсвөр насны хүүхдийн үерхэл нөхөрлөлийн онцлогийг судалсан нь”
- ✓ “Өсвөр насныханд тулгамдсан сэтгэл зүйн зарим асуудал”
- ✓ “Өсвөр насны хүүхдийн сэтгэл хөдлөлөө хянах чадварын судалгаа”
- ✓ “Суралцахуйн амжилтад сэтгэл хөдлөлийн оюун ухааны нөлөөлөл”
- ✓ “Personal identity impact on career and professional choice for high school students and the concept of specialty options”
- ✓ “Өсвөр насны хүүхдийн өөрийгөө удирдахад тулгамдсан асуудал”
- ✓ “Ахлах ангийн сурагчдын сэтгэл хөдлөлөө хянах чадварын судалгаа”
- ✓ “Өсвөр насны хүүхдийн PC тоглоомын хэрэглээг судалсан нь”
- ✓ “Personal identity impact on career and professional choice for high school students and the concept of speciality options” – ОХУ –Сборник статей

- ✓ Архангай аймагт зохион байгуулагдсан Боловсролын шинэчлэл багшийн хөгжил олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Ахлах ангийн сурагчдын өөрийгөө хчнах чадварын судалгаа”
 - ✓ MULTIDISCIPLINARY BRAIN SCENCE-2019 олон улсын эрдэм шинжилгээний хуралд “RESEARCH ON SKILS OF SELF-REGULATION OF JUNIORS” илтгэл
 - ✓ Сэтгэл судлалын орчин үеийн асуудлууд монголын сэтгэл зүйчдийн эрдэм шинжилгээний хуралд “Өсвөр насны хүүхдийн сэтгэл хөдлөлөө хянах чадварын судалгаа” сэдвээр илтгэлийг тус тус амжилттай
 - ✓ хэлэлцүүлсэн.
- Төслийн хүрээнд дараах эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулсан. Үүнд:
 - ✓ “Сэтгэл судлалын орчин үеийн асуудал”- 2018 он
 - ✓ “Нийгмийн сэтгэл зүйн өнөөгийн байдал”- 2019 он
 - ✓ “Оюутны сэтгэл зүйд тулгамдсан асуудал”- 2020 он

ИДИКС АРГАЧЛАЛ**Судлуулагчийн товч намтар**

Овог нэр _____

Нас _____ Хүйс эр _____ эм _____ огноо _____

Ажил, боловсролын тухай

Ажил _____ Үүрэг _____

Бүрэн бус дунд

Дээд сургуулиа төгсөөгүй

Бүрэн дунд

Дээд

Тусгай дунд

Эрдмийн зэрэгтэй (магистр, доктор)

Таны боловсролын чиглэл _____

Та мэргэжлээрээ ажилладаг эсэх _____

Таны эрүүл мэндийн байдлын ерөнхий тодорхойлолт

Сүүлийн 6 сард өвдсөн эсэх _____

Сүүлийн сарын туршид эмч нарын тусламж авсан эсэх _____

Танд ямар нэгэн архаг өвчин бий эсэх _____

Хэрэв та ямар нэг групптэй эсэх (тэмдэглэнэ үү?)

зүрх судасны системийн өвчин

булчин хөдөлгөөний аппаратын өвчин

хоол боловсруулах тогтолцооны өвчлөл

сэтгэл зүйн асуудал

Бодисын солилцооны өөрчлөлт

бусад

Таны амьдрал дахь стрессийн нөхцөл байдал ноцтой үйл явдлууд

Сүүлийн 6 сарын туршид танай амьдралд тохиолдсон ноцтой үйл явдлууд:

Ажил, мэргэжлийн хүрээнд:

Хувийн амьдралд:

ажлын ээлж

нүүдэл хийх

ажлаа алдах

хурим

албан тушаал ахих

шинэ хүүхэдтэй болох

удирдлага болон хамт олонтойгоо

гэр бүл дэх зөрөлдөөнт байдал

зөрөлдөөнтэй байх

гэр бүл салалт

байгууллагын санхүүгийн хүнд байдал

хүнд өвчлөл

Дахин зохион байгуулалт

ойр дотны хэн нэгэн нас барах

Таны амьдралын хэв маяг, дадал зуршлын онцлог

А. Та тамхи татдаг уу?

Тийм Үгүй

Судлуулагчийн товч намтар

Овог нэр _____

Нас _____ Хүйс эр _____ эм _____ огноо _____

Хэсэг 1. Хөдөлмөр зохион байгуулалт, ажлын нөхцөл

Та асуултад хариулахдаа 4 онооны хэмжүүрээр дүгнэнэ.
1-тийм биш, 2-заримдаа, 3- хааяа 4-яг тийм

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32

Хэсэг 2. Хөдөлмөрийн агуулга, ажлын гүйцэтгэл

Та асуултад хариулахдаа 4 онооны хэмжүүрээр дүгнэнэ.
1-тийм биш, 2-заримдаа, 3- хааяа 4-яг тийм

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15		16
17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31		32

Хэсэг 3. Хүний тухайн байдлын янз бүрийн илрэл

Та асуултад хариулахдаа 4 онооны хэмжүүрээр дүгнэнэ.
1-тийм биш, 2-заримдаа, 3- хааяа 4-яг тийм

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32

Хэсэг 4. Өөрийгөө мэдрэх, сэтгэл хөдлөл, мэдрэмжийн байдал

Та асуултанд хариулахдаа 4 онооны хэмжүүрээр дүгнэнэ.
1-бараг үгүй, 2-заримдаа, 3-ихэвчлэн 4-бараг үргэлж

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32

Хэсэг 5. Янз бүрийн нөхцөл дэх хувийн харилцаа ба зан байдлын онцлог

Та асуултад хариулахдаа 4 онооны хэмжүүрээр дүгнэнэ.
1-бараг үгүй, 2-заримдаа, 3-ихэвчлэн 4-бараг үргэлж

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18	19	20	21	22

ИДИКС АРГА ЗҮЙН АСУУМЖ

Та өөрийн хувийн туршлагад нийцэж байгаа асуулт бүрийг үнэлнэ үү?

Танд дараах дэс дараалуулан байрлуулсан 4 онооны хэмжүүрийг ашиглах саналыг дэвшүүлж байна.

1 оноог- “Үгүй”, “энэ ч тийм биш”, эсвэл “бараг хэзээ ч үгүй” зэрэг бүрэн зөвшөөрөөгүй тохиолдолд

2 оноог- Бүрэн бус зөвшөөрч байвал өөрөөр хэлбэл, “магадгүй”, “зарим нь үнэн” эсвэл “заримдаа” гэсэн хариултууд өгөх үед

3 оноог- Хангалттай өндөр түвшинд зөвшөөрч байгаа буюу “ихэвчлэн”, “зөв” гэсэн хариултуудыг өгч байгаа үед

4 оноог- Бүрэн зөвшөөрч, “ туйлын зөв”, “бараг үргэлж” хэмээн хариулж байгаа үед өгнө.

Ажил эхлэхийн өмнө товч заавартай анхааралтай танилцаж, хэрхэн үнэлэхээ тодорхойлно.

Асуулгын хариултыг сонгохдоо удаан эргэлзэлгүй, зөв хариулах гэж оролдолгүй бөглөнө үү!

Үнэндээ, таны итгэлтэйгээр хариулсан, хувийн туршлага, харилцааны ихэнх түвшинд тохирох хариултуудыг бид сонирхож байгаа юм. Таны оюун ухаанд хамгийн түрүүнд орж ирсэн хариулт бол яг зөв байх бөгөөд бясалган бодсон хариулт бол эргэлзээнд хүргэж болох юм.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ Ажиллах нөхцөл, хөдөлмөр зохион байгуулалтын янз бүрийн талыг харуулсан өгөгдлийн жагсаалтыг танд толилуулж байна. Дараах өгөгдөл бүрийг уншиж таны ажлын онцлогтой хэрхэн тохирч байгааг тэмдэглэнэ үү.

1. Надад янз бүрийн хүмүүстэй идэвхтэй харилцах шаардлага гардаг.
2. Миний ажлын байрны зохион байгуулалт тав тухгүй.

3. Би ихэвчлэн илүү цагаар ажилладаг.
4. Манай байгууллагын ажилтнуудын чиг үүрэг хангалттай тодорхой биш.
5. Би ажил дээрээ дарга болон хамт олонтойгоо төвөгтэй харилцаатай байдаг.
6. Би бусад ажилтнуудаас илүү ажиллаж, бага цалин авдаг.
7. Миний ажлын өрөө маш их дуу чимээтэй.
8. Миний ажилд надаас үл шалтгаалах сул зогсолт гардаг бөгөөд дараа нь ажлаа нөхөж хийх болдог.
9. Миний гүйцэтгэх ажилд баримт бичигтэй ажиллах ачаалал хэтэрхий их.
10. Би ихэнхдээ хэд хэдэн чухал ажлыг зэрэг гүйцэтгэдэг.
11. Багийнхантайгаа ажил гүйцэтгэх үед зөрчил гарах нь цөөнгүй байдаг.
12. Миний мэргэжлийн өсөлтөд ажлын амжилт огт нөлөөлдөггүй.
13. Утасны хонх болон хөндлөнгийн бусад саад намайг ажлаас байнга сатааруулж байдаг.
14. Ихэнх даалгавар болон төслүүдийг хэт давчуу хугацаанд гүйцэтгүүлэхээр оноодог.
15. Ажлынхаа ихэнх хугацааг компьютерын ард өнгөрөөдөг.
16. Надад бусдын хийх ёстой ажлыг хийж гүйцээх шаардлага цөөнгүй гардаг.
17. Байгууллагын ажилтнууд албан тушаал, суудлын төлөө байнга тэмцэлддэг.
/өрсөлддөг/
18. Сайн гүйцэтгэсэн ажлынхаа төлөө би зохих сайшаал урамшууллыг авдаггүй.
19. Ихэнх цагаа гадуур ажилд зарцуулдаг.
20. Яаралтай даалгаврыг гүйцэтгэхийн тулд заримдаа шөнийн цагаар болон амралтын өдөр ажиллах нь цөөнгүй.
21. Хариуцлагатай чухал шийдвэр гаргах шаардлага цөөнгүй тулгардаг.
22. Техник, тоног төхөөрөмжийн гэмтэл ба дутагдалтай байдал нь ажлыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд саад учруулдаг.
23. Надтай хамтран ажиллагчдын ур чадварын түвшин өндөр байхыг их хүсдэг.
24. Байгууллагад хийж буй ажил нь өсөж дэвжих боломж олгодоггүй. иний ажлын өдөр тогтоосон хэм хэмжээгүй байдаг.
25. Ажлын үеэр амсхийх буюу тайван хооллох цаг олддоггүй.

26. Би үргэлж шинэ асуудлыг шийдвэрлэх эсвэл хүнд хэцүү даалгавар гүйцэтгэх шаардлагатай тулгарч байдаг.
27. Яаралтай тохиолдол, эсвэл бэрхшээлтэй нөхцөл байдал зэргээс болж төлөвлөгөөний хэрэгжилт ихэвчлэн алдагддаг.
28. Зохион байгуулалтын чухал шийдвэр гаргах үед ажиллагчдын санал бодлыг харгалздаггүй.
29. Би мөнгөний төлөө л энэ байгууллагад ажилладаг.
30. Би хамт олон /удирдуулж байгаа хүмүүстэй/ ямагт эелдэг харилцдаг.
31. Миний ажлын зохион байгуулалтад сул тал бараг байхгүй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ Ажлын гүйцэтгэл болон хөдөлмөрийн агуулгын онцлогийг тодорхойлсон өгөгдлийн жагсаалтыг танд толилуулж байна. Дараах өгөгдөл бүрийг уншиж, таны ажлын онцлогтой хэрхэн тохирч байгааг тэмдэглэнэ үү.

1. Миний үүрэг хариуцлага төрөл бүрийн зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байдаг.
2. Миний ажил олон талын мэдлэг, чадварыг шаарддаг.
3. Байгууллагын нэгж, тэр байтугай байгууллагын бүхий л үйл ажиллагаа амжилттай явагдахад миний гүйцэтгэж байгаа ажил чухал үүрэгтэй.
4. Өмнөө тулгарсан зорилтоо шийдвэрлэхийн тулд би арга барил болон ашиглах хэрэгслээ өөрөө чөлөөтэй сонгодог.
5. Би ажлаа төлөвлөж үр дүнгээ хянах боломжтой.
6. Миний ажлын гүйцэтгэлд удирдлага хатуу хяналт тавьдаг.
7. Ажлаа хэрхэн гүйцэтгэх талаар бодож тунгаах шаардлага бараг гардаггүй. Учир нь миний гүйцэтгэх даалгаврууд хоорондоо маш төстэй байдаг.
8. Миний өмнөө тавьж буй зорилт бүр өвөрмөц бөгөөд бүтээлч хандлагыг шаарддаг.
9. Миний ажлын чанараас хамтран ажиллаж байгаа бусад хүмүүсийн ажил шууд хамаардаг.
10. Ажлыг гүйцэтгэхэд нарийн дараалал, зааврыг дагаж мөрдөх хэрэгтэй байдаг.
11. Алдааг засахад хэтэрхий оройтсон үед би алдаа гаргаснаа мэддэг.

12. Ажлын үе шат бүртээ тогтмол тайлагнахыг надаас шаарддаг.
13. Би хэтэрхий энгийн, хоорондоо хамааралгүй даалгавруудыг гүйцэтгэх нь их.
14. Миний гүйцэтгэх ажил хоорондоо холбоо хамааралтай бөгөөд би түүнийг хэрхэн гүйцэтгэхээ сайн мэддэг.
15. Миний ажилд утгагүй, хэнд ч хэрэггүй зүйл их байдаг.
16. Үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа болон ажлын хэмжээ хүрээг би бие даан төлөвлөдөг.
17. Хийсэн ажлаа хүлээлгэн өгөхдөө цаашдын хувь заяаны талаар би юу ч мэдэхгүй.
18. Миний бүх л үйлдэл, үйл ажиллагааг байнга хянаж байдаг.
19. Өглөөнөөс орой хүртэл би нэгэн хэвийн ажил гүйцэтгэдэг.
20. Эхнээс нь дуустал гүйцэтгэх ёстой хамгийн хүнд хариуцлагатай үүрэг даалгаврыг надад оноодог.
21. Миний шийдвэрлэх асуудлууд хувийн шинжтэй бөгөөд бусад ажилтнуудын үйл ажиллагаанд нөлөөлдөггүй.
22. Надад өөрөө санаачилга гаргах эсвэл бие даан зорилт тавих ямар ч боломж байхгүй.
23. Удирдлага болон хамт олон маань миний ажлын эерэг үр дүнгийн талаар ярилцдаггүй.
24. Намайг хэдэн цагаар, хэрхэн хөдөлмөрлөж байгааг хэн ч анхаардаггүй бөгөөд үр дүнд хүрэх нь л чухал байдаг.
25. Би ажил дээрээ танил биш бөгөөд шинэ үүрэг даалгавартай нүүр тулах нь цөөнгүй.
26. Миний ажил оюуны хүч их шаарддаггүй.
27. Миний ажилд хэн ч оролцдоггүй, юу хийхийг ч заадаггүй, би хэнээс ч хамаарахгүй ажлаа хийдэг.
28. Миний ажил хүмүүст ашиг тустай.
29. Удирдлага эсвэл үйлчлүүлэгчдээсээ өөрийн ажлын чанарын тухай мэдээллийг би байнга авдаг.
30. Хийсэн ажлынхаа тайланг хэнд, хэзээ тайлагнах нь тодорхойгүй байдаг.
31. Удирдлага намайг муу ажиллалаа гэж загнахад би хэзээ ч гомддоггүй.

32. Хамгийн уйтгартай, нэгэн хэвийн ажил ч надад таашаал өгдөг.

ГУРАВДУГААР ХЭСЭГ Хүний тухайн үеийн байдлын янз бүрийн илрэлийн талаарх өгөгдлийн жагсаалтыг танд толилуулж байна. Дараах асуулт бүрийг уншиж, тухайн үед таны сэтгэл мэдрэмжид хэр тохирч байгааг тэмдэглэнэ үү.

1. Миний биеийн байдал сайн байна.
2. Миний сэтгэл догдолж, нэг л таагүй байна.
3. Миний гар /түгшсэн үед/ чичирч байна.
4. Эргэн тойрны эд зүйлс, хүмүүс надад бүдэг, бүүдгэр харагдаад байна.
5. Гэнэт, надад ярихад хэцүү байна.
6. Би нэг ажил дээр төвлөрч чадахгүй байна.
7. Би сандарч байна.
8. Би их хөлөрч байна.
9. Эргэн тойронд байгаа хүмүүсийн яриаг ойлгоход хэцүү байна.
10. Эргэн тойронд байгаа хүмүүсийн яриа намайг бухимдуулж байна.
11. Бүх зүйл маань буруу болоод байна.
12. Би өөрийгөө хүчтэй гэдгээ мэдэрч байна.
13. Түгшүүр, айдас нэмэгдээд байна.
14. Миний ам хатаад байна.
15. Гэнэт тулгамдаад чухал буюу хамгийн энгийн мэдээллээ санахад хэцүү байна.
16. Надад хүмүүсийн нийтлэг ярианд оролцоход хэцүү байна.
17. Би тэнэг алдаа гаргаад байна.
18. Би баяр баясгалантай байна.
19. Би тайван биш байгаа бөгөөд тэнцвэрээ алдахад тун ойрхон байна.
20. Миний дотор муухайрч байна.
21. Тодорхой зүйл дээр анхаарлаа хандуулах нь надад хэцүү байна.
22. Надад энгийн санааг ч үгээр илэрхийлэхэд хэцүү байна.
23. Дасал болсон үйл ажиллагааг гүйцэтгэхэд надаас нэмэлт хүч шаардаж байна.
24. Би идэвхтэй байж, хийж бүтээмээр байна.

25. Дотоод хурцадмал байдал миний бодол санаа, мэдрэмжийг боогдуулж байна.
26. Толгой, чамархай орчим шуугиж байна.
27. Бүх л бодол санаа төөрөлдөж тархинд эмх цэгцгүй эргэлдэж байна.
28. Ярилцагчийн үгийн утгыг ойлгоход хүнд байна.
29. Хөдөлгөөн минь оновчтой бус замбараагүй байна.
30. Хэн нэгэн эсвэл ямар нэгэн зүйл яаралтай ажлаас минь хөндийрүүлэхэд уурлаж, уцаарлаж байна.
31. Ямар ч нөхцөлд би өөрийгөө бүрэн хянаж чадаж байна.
32. Би сэргэлэн цовоо, хөгжилтэй, өөртөө итгэлтэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ Сэтгэл хөдлөл, мэдрэмж, биеийн ерөнхий байдлыг тодорхойлсон өгөгдлийн жагсаалтыг танд толилуулж байна. Дараах өгөгдөл бүрийг уншиж сүүлийн хагас жил таны мэдрэмжтэй тохирч байгааг тэмдэглэнэ үү.

1. Юу ч болж байсан би тайван байдаг.
2. Надад чиглэсэн ёжтой үг, сануулгад би хайхрамжгүй ханддаг.
3. Би өөрийнхөө ажил, үүргийн тухай бодож эхлэх үед надад түгшүүр төрж эхэлдэг.
4. Би уйтгар гунигийг мэдэрдэг.
5. Бие нэг л үлбэгэр, сайн амарч чадаагүй мэт санагдаж байна.
6. Толгой, чамархайн хэсэг дэх хүчтэй өвдөлт намайг шаналгадаг.
7. Ямар ч шалтгаангүйгээр өөртөө болон эргэн тойрныхондоо уурладаг.
8. Би нойргүйдэлтэй.
9. Өөрийнхөө хийсэн алдаа, муу зүйлдээ удаан хугацааны турш шаналдаг.
10. Намайг шүүмжлэхэд хүчтэй уурладаг.
11. Надад дүнсгэр, гунигтай мэдрэмж төрдөг.
12. Ажлаа хийж эхлэнгүүт ядарч байгаагаа мэдэрдэг.
13. Надад дотор муухайрах, толгой эргэх шинж илэрдэг.
14. Хэрэв би шөнө сэрвэл, дараа нь унтахад хэцүү байдаг.
15. Ялимгүй асуудалд би санаа зовдог.
16. Хэрвээ ажил бүтэхгүй байвал өмнөө харагдсан бүхнээ шидэлж хаях эсвэл иймэрхүү зүйл хиймээр санагддаг.

17. Муу совин намайг дарангуйлдаг.
18. Надад хэн ч саад болоогүй байсан ч ажилдаа бүрэн төвлөрөхөд хэцүү байдаг.
19. “Зөөлөн хоол орж ирэхэд” Дотор муухайрч таагүй мэдрэмж үүсдэг.
20. Хэдийгээр шөнө унтсан ч би өдөржин унтахыг хүсдэг.
21. Өөртөө итгэлгүйн улмаас надад шийдвэр гаргахад хүнд байдаг.
22. Хэн нэгэн надад шахалт хийхийг оролдвол би хэрэлдэж эхэлдэг.
23. Надад бүх зүйл найдваргүй санагддаг.
24. “Ой тогтоолт муу юм шиг” Би ямар нэгэн чухал зүйлийг хийхээ мартчихдаг.
25. Миний хоолой боогдож амьсгалахад хэцүү болдог.
26. Хар дарсан, хүнд зүүд намайг түгшээдэг.
27. Би ирээдүйгээ итгэлтэйгээр харж байна.
28. Би маргаантай асуудлыг хэрүүлгүй, сандралгүй шийдвэрлэдэг.
29. Амьдрал надад таашаал өгдөг.
30. Би бөх сайн унтдаг.
31. Би ажилдаа ямагт эрч хүчтэй байдаг.
32. Би өөрийгөө цоо эрүүл гэдгээ мэдэрдэг.

ТАВДУГААР ХЭСЭГ Танд **өөр өөр нөхцөл байдалд хувь хүний харилцааны онцлог, зан байдлыг тусгасан өгөгдлийн** жагсаалтыг санал болгож байна. Тэдгээрийг уншаад өөрт тохирч байгааг тэмдэглэнэ үү.

1. Би ажлаа бусдаас хурдан, илүү сайн гүйцэтгэхийг эрмэлздэг.
2. Хамт олон болон үйлчлүүлэгчтэйгээ харилцах нь намайг бухимдуулдаг.
3. “Өлсгөлөн чоно” шиг их идмээр санагддаг.
4. Санаа зовсон үедээ би тамхи татдаг.
5. Би гүйх шахам ажиллаж яаралтай олон асуудлыг шийдвэрлэдэг.
6. Баг хамт олноороо энгийн ажил хэргийн асуудал хэлэлцэх үед босоод явчихмаар санагддаг.
7. Ямар ч учир шалтгаангүйгээр надад айдас түгшүүр төрж байдаг.
8. Санаа зовох болон гуних үед хамгийн сайн эм бол бага зэрэг ууж, тайтгарах

явдал.

9. Хэн нэгнийг хүлээх хэрэгтэй болоход тэвчихэд хэцүү байгаагаа нуухад надад хэцүү байдаг.
10. Ажил дээр намайг дутуу хүндэлж, үнэлж байна гэсэн мэдрэмж надад байсаар байдаг.
11. Хэдийгээр одоо мэдэгдэхгүй байгаа ч өөрийгөө хүнд өвчтэй гэж би сэжиглэж, санаа зовж байдаг.
12. Өлсөхгүй байсан ч би их иддэг.
13. Амжсангүй, хийж болох л байсан гэж би байнга боддог.
14. Надад хүч барагдаж байгаа мэт мэдрэмж төрдөг.
15. Хүнд байдалд орохоороо миний гар салганаад би ээрч эхэлдэг.
16. Нөхцөл байдал тодорхой бус эсвэл хэтэрхий төвөгтэй болох үед би эрсдэлтэй алхам хийдэг.
17. Ажлын дараа амарч чаддаггүй. Яагаад гэвэл хойшлуулшгүй өөр ажил гараад ирдэг.
18. Би ажил мэргэжлээсээ мөрөөдөж байсан зүйлийнхээ хагасыг нь ч аваагүй юм шиг санагддаг.
19. Би үнэхээр бүх зүйлээ хийсэн үү гэдгээ дахин дахин шалгах байнгын хүсэл төрдөг. (Жишээ нь: Машинаа түгжсэн эсэх, зуухаа унтраасан эсэх, бичиг баримт, захиа илгээсэн эсэхээ шалгах гэх мэт)
20. Миний ажил сайнгүй үед би хийх өөр зүйл хайдаг.
21. Би найз нөхөд, өрсөлдөгч нарынхаа амжилтад чин сэтгэлээсээ баярладаг.
22. Ямар ч тохиолдолд би тайван байдлаа хадгалж, бодлогогүй үйлдэл гаргадаггүй.

ХАВСРАЛТ 4

<i>Асуумж</i>					IS	FI	IaS	SF	AS
1	Гэр бүлийн нэг хэсэг гэсэн мэдрэмжтэй, үүнийгээ илэрхийлдэг.	3	2	1	0		<u>3</u>		
2	Өөрийнх нь амьдралтай холбоо хамааралтай насанд хүрсэн хүнд итгэдэг.	3	<u>2</u>	1	0		<u>2</u>		
3	Гэр бүлийн хэн нэгэн тэврэхэд татгалздаггүй.	3	2	<u>1</u>	0				<u>1</u>
4	Олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцдог.	3	<u>2</u>	1	0		<u>2</u>		
5	Өөртөө итгэлтэй.	3	<u>2</u>	1	0			<u>2</u>	
6	Сэтгэл нь эмзэглэсэн, зовнисноо илэрхийлдэг.	3	2	1	<u>0</u>				<u>0</u>
7	Гэр бүлийнхэнтэйгээ эерэг харилцаатай.	<u>3</u>	2	1	0		<u>3</u>		
8	Хошин мэдрэмжтэй.	3	<u>2</u>	1	0			<u>2</u>	
9	Хэрэгтэй үедээ тусламж хүсч ханддаг.	3	2	<u>1</u>	0				<u>1</u>
10	Уур бухимдлаа зохицуулах чадвартай.	3	2	<u>1</u>	0	<u>1</u>			
11	Эцэг эхтэйгээ зан байдлынхаа талаар гэртээ ярилцдаг.	3	<u>2</u>	1	0		<u>2</u>		
12	Бусдыг гомдоосон эсвэл уурлуулж бухимдуулсан зан үйлдэлдээ гэмшиж харамсаж байгаагаа илэрхийлдэг.	3	2	<u>1</u>	0	<u>1</u>			
13	Бусад хүмүүсийн сэтгэл санааг анхаарч, санаа тавьдаг.	3	2	1	<u>0</u>				<u>0</u>
14	Юм хийлгэх хүсэлт, шаардлагыг нэг хэлүүлээд хийж гүйцэтгэдэг.	<u>3</u>	2	1	0			<u>3</u>	
15	Эцэг эхтэйгээ эерэгээр харилцдаг.	<u>3</u>	2	1	0		<u>3</u>		
16	Сэтгэл санаанд нь хүрээгүй зүйл гарах, гомдох, гутрах зүйлд тайвнаар ханддаг.	3	2	1	<u>0</u>	<u>0</u>			
17	Өөрийнхөө зан үйлийн үр дагаврыг ухамсарладаг.	3	2	1	<u>0</u>	<u>0</u>			
18	Шүүмжлэлийг хүлээн авдаг.	3	2	1	<u>0</u>	<u>0</u>			
19	Шашин, сүсэг бишрэлийн үйл ажиллагаанд оролцдог.	3	<u>2</u>	1	0		<u>2</u>		
20	Насандаа тохирсон эрүүл ахуйн чадварыг эзэмшсэн.	3	<u>2</u>	1	0			<u>2</u>	
21	Үе тэнгийнхэн, найз нөхдөөсөө дэмжлэг хүсдэг.	3	2	<u>1</u>	0			<u>1</u>	
22	Хобби, сонирхсон зүйлтэй.	<u>3</u>	2	1	0			<u>3</u>	
23	Бэрхшээлтэй асуудлаа бусадтай хуваалцаж ярилцдаг.	3	2	<u>1</u>	0				<u>1</u>
24	Сургуулиас болон хичээлийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэдэг.	<u>3</u>	2	1	0			<u>3</u>	
25	Бусдын ойр дотно байдал, дотно харилцааг хүлээн зөвшөөрдөг.	3	2	<u>1</u>	0				<u>1</u>
26	Өөрийнхөө дотоод сэтгэл, мэдрэмжээ тодорхойлох, илэрхийлэх чадвартай.	3	2	<u>1</u>	0			<u>1</u>	
Багана тус бүрээр онооны нийлбэр					2	17	11	6	4